

Energy Mongolia

2024.10 | №03

www.erchimkhuch.mn

ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

Эрчим хүчний
салбар
Улаанбаатар хот
ба 21 аймагт

БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД

Эрчим хүчний
үндэсний хороо

ШАДАР САЙД

Т.Доржханд:
Эрчим хүчний
салбар хувийн
хэвшлийнхэнд
хаалгаа нээх ёстой

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ЮУ БОЛОХ ГЭЭД БАЙНА ВЭ?





ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС ▶ 5

Эрчим хүчний салбарт зах зээлийн салхи сэвэлзэх нь ээ

ОНЦЛОХ НИЙТЛЭЛ ▶ 6

Эрчим хүчний салбар өнөөдөр

▶ 7 Эрчим хүчний үндэсний хорооны гишүүд**ҮНЭ ТАРИФ ▶ 8**

Үнэ тариф эрчим хүчний хөгжлийн гацаа юу?

ЭХ ҮҮСВЭР ▶ 12

Насжилт, баталгаат хугацаа нь дууссан цахилгаан станцууд

ШАДАР САЙД ▶ 22

Т.Доржханд: Эрчим хүчний салбар хувийн хэвшлийнхэнд хаалгаа нээх ёстой

**БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧ**

- ▶ 28 М.Энхцэцэг: Эрчим хүчний салбарт шинэтгэл хийх цаг болсныг бүх түвшинд хүлээн зөвшөөрч, дэмжиж байна
- ▶ 31 С.Цэнгүүн: Эрчим хүчний реформыг дэмжих бүлэгт УИХ-ын 100 гаруй гишүүн гарын үсэг зурсан
- ▶ 33 Б.Найдалаа: Эрчим хүчний шинэчлэлийн суурийг одоо л тавих цаг ирсэн
- ▶ 34 Д.Энхтуяа: УИХ-ын гишүүд эрчим хүчний реформ хийхээр зориг гаргаад ажиллаж байна
- ▶ 35 Ч.Анар: Халамжийн сэтгэхүйгээр яваад байвал энэ салбарт хөгжлийн тухай яриад нэмэргүй
- ▶ 36 Ж.Золжаргал: Эдийн засгийн тэлэлт нь эрчим хүчнээсээ болоод боомилогдсон

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА ▶ 36

Х.Нямбаатар: Улаанбаатар хотын бүх бүтээн байгуулалт эрчим хүчээс болж саатах гээд байна

НИЙСЛЭЛ ▶ 40

“Бурханаас заяасан зовлон”-той Монгол Улсын цахилгаан эрчим хүч

Л.ОЮУН-ЭРДЭНЭ:

Монгол Улсын Ерөнхий сайд:

30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын либералчлалыг цаг алдалгүй хийхэд улс төржилгүй хамтран ажиллахыг Та бүхнээс хүсье. Эрчим хүчний салбарыг эргэн сэргээхгүйгээр хот байгуулах, эдийн засгийг тэлэх гэдэг бол хоосон мөрөөдөл юм.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдсоны дараа УИХ-д хэлсэн үгнээс. 2024.07.06



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРАА АВАРЬЯ

Эрчим хүчний салбарт зах зээлийн салхи СЭВЭЛЗЭХ НЬ ЭЭ



Ерөнхий Эрхлэгч
Д.Бэхбаяр

Сэтгүүлчийнхээ хувьд ийм гарчигтай зурвас бичих өдөр ирдэг л юм байна. Шинээр байгуулагдсан засаг эрчим хүчний салбарт анхаарч, өөрчлөлт шинэчлэл хийхээр ажиллаж эхэлсэнд баяртай байна. Өнгөрсөн хугацаанд тус салбарын асуудлыг хүлээн зөвшөөрч, бодит үнэнтэй тулж, өөрчлөлтийн төлөө зоригтой дуугарч гарч ирж байсан нам, засаг төр үгүй билээ. Нөгөө талдаа асуудал хоолойд тулж, гэрэл цахилгаан, дулаангүй болох дээрээ ирсэн учраас энэ салбарт анхаарахаас өөр аргагүй байдалд хүргэж байгаа хэрэг.

Миний хувьд 24 жил эрчим хүчний сэдвээр бичиж байгаа билээ. Энэ хугацаанд энэ салбарт дорвитой өөрчлөлт хийсэн зүйлгүй ярьж явсаар өнөөдөр уруудан доройтсоор зогсох дээрээ тулав. Харин одоо тулгамдсан асуудлыг яаралтай шийдэж, реформ ч байна уу, шинэчлэлт ч байна уу өөр юу байдаг юм бүгдийг л хийх шаардлагатай. Өөр сонголт үгүй юм.

Харин төрийн бодлогын түвшинд томоохон шинэчлэл хийхээр зоригтой дуугарч, ярих бус үйлдэл хийж эхэлсэн нь сайшаалтай. УИХ дээр Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг бий болгосон бол Засгийн газрын түвшинд Эрчим хүчний үндэсний хороог байгуулсан. Ямартаа ч тус салбарт гэрэл асах нь гэж ойлгогдож байна. Үндэсний хороонд орсон УИХ-ын гишүүд маш их ажиллаж байгаа. Тэд өнгөрсөн наймдугаар сараас хойш эрчим хүчний салбарын ажилтай танилцаж, үйлдвэр компаниудаар явж уулзсан. Одоо тэд эрчим хүчний талаар арвин мэдлэг мэдээлэл, ойлголттой болж бодлогын чанартай ажлууд руугаа чиглээд

оржээ. Таван чиглэлд бодлогын реформ хийх талаар Үндэсний хорооны дарга Т.Доржханд ярилцлагадаа тодотгов.

Бид энэхүү дугаартаа Эрчим хүчний үндэсний хорооны гишүүдийг онцоллоо. Учир нь тэд эрчим хүчний реформыг эхлүүлэх маш том бөгөөд ярвигтай ажил руу ханцуй шамлан орсон бодлого тодорхойлогчид. Тэд зоригтой, хурдтай ажиллахаа илэрхийлж байна. Харин бид тэднийг дэмжиж, хамтран ажиллах ёстой. Учир нь эрчим хүч бол бид бүгдийн асуудал, аж амьдрал шүү дээ. Улсаараа, салбараараа, ард иргэдээрээ хамтарч нэгдэж, хүчирхэгжиж байж эрчим хүчний салбарыг аварч, шинэчлэл өөрчлөлт хийж, зах зээлийн системд шилжүүлэх юм.

Эцэст нь хэлэхэд. Бид баяртай байна. Бид “Эрчим хүчний салбараа аварья” уриатай контентын аяныг 2022 онд эхлүүлж, Energy Mongolia сэтгүүлээ гаргаж, эрчим хүчний салбарын бодит байдлын талаар олон нийтлэл, ярилцлага хийсэн. Харин одоо төр засгийн түвшинд асуудалд ийн хандана гэдэг бол салбарыг аварч, реформ хийж, хөгжлийн зөв замд нь оруулахын том дохио юм. Тиймээс бид Эрчим хүчний үндэсний хороотой хамтран ажиллана.

Бид энэхүү дугаартаа эрчим хүчний салбарын өнөөгийн бодит байдлыг харуулсан, мөн Үндэсний хорооны гишүүдийн салбарын хөгжлийг хэрхэн харж байгаа, ямар өөрчлөлт хийх талаарх байр суурийг онцлон гаргаж тавилаа. Мөн нийслэл хот болон 21 аймгийн цахилгаан, дулааны бодит байдлын талаар товч мэдээлэл хүргэж байна. Эрчим хүчний салбарт зах зээлийн салхи сэвэлзэж, улс орон маань хурдтай хөгжин дэвших болтугай.



Эрчим хүчний салбар өнөөдөр




- Төрөөс үнийг барьсан
- Алдагдалтай ажилладаг
- ДЦС-ууд тэтгэвэрт хэдийнэ гарсан ч ажилласаар л
- Шугам сүлжээнүүдийн ашиглах хугацаа дууссан.
- Тоног төхөөрөмжүүд хуучирч хоцрогдсон.
- Салбарын мэргэшсэн боловсон хүчнүүд ажлаасаа олон зуугаараа гарч байгаа.
- Сүүлийн 40 жилд нэг ч том эх үүсвэр бариагүй.
- Сүүлийн 30 жилд нэг ч том төсөл хэрэгжүүлээгүй.
- Сүүлийн 30 жилд мега том төслүүдийг ярьсны ой болсоор байна. Тухайлбал, Эгийн голын УЦС, Тавдугаар цахилгаан станц, Багануурын станцыг барихаар ярьсны 30,40 жилүүд тохиож буй.
- Улстөрчид эрчим хүчний үнийг сонгуулийн оноо авах хэрэгсэл болгож ирсэн.
- Салбарын бүх үйлдвэр компани төрийн өмчийнх.
- Улаанбаатар хот, Монгол Улсаараа гэрэл цахилгаангүй, өвөл хөлдөх эрсдэл хажууд ирсэн
- Цахилгааны хязгаарлалт хийж эхэлсэн
- Эрчим хүчний хараат байдалд байгаа.
- Үндэсний аюулгүй байдал энэ салбарт онцгой анхаарууштай асуудал болсон
- Эрчим хүч хөгжлийг хязгаарлагч, боомилгоч салбар болсон
- Цахилгаан, дулаанаа хэмнэнэ гэдгийг мэддэггүй байгууллага, ард иргэдтэй
- Монгол Улсын хамгийн хямдхан бүтээгдэхүүн бол эрчим хүч болсон. Сэлбэг материал олдохгүй болсон. Учир нь гол сэлбэг материалаа ОХУ, Украин улсаас авдаг. Энэ хоёр улс дайнтай байгаа.

Энэ зах зээлийн систем мөн үү?

Нэг кВт.ц цахилгааны өртөг бодит өртөг **224.11** төгрөг
 Борлуулдаг үнэ: **175** төгрөг
 Тайлбар: **224** төгрөгийн өртгөөр бүтсэн бүтээгдэхүүнээ 175 төгрөгөөр борлуулдаг.

Эрчим хүчний салбар ийм алагдалтай ажиллаж байна

2019 онд **59** тэрбум төгрөг
 2020 онд **88.1** тэрбум төгрөг
 2021 онд **78** тэрбум төгрөг
 2022 онд **187.4** тэрбум төгрөг
 2023 онд **98.0** тэрбум төгрөг
 2024 онд **203** тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах төсөөлөлтэй байна.



Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдийн өвлийн их ачааллын үед суурилагдсан бүрэн хүчин чадлаараа, нөөц тоноглолгүй аваарын горимд ажиллаж байна.

2023-2024 оны өвлийн их ачаалалд **63** зуух, **41** турбоагрегат ажиллаж, системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй ажилласан.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны гүйцэтгэлээр:

10.9

тэрбум кВт.ц
цахилгаан
эрчим хүч
боловсруулсан

9.9

тэрбум кВт.ц
цахилгаан
эрчим хүчийг
түгээсэн

Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний хангалт

77.7

хувийг дотоодын
эх үүсвэрүүдээс

22.3

импортын цахилгаан
эрчим хүчээр

Нийт импортлосон цахилгаан эрчим хүч

938.0

сая кВт.ц буюу
38.3%-ийг ОХУ-аас

1508.6

сая кВт.ц буюу
61.7%-ийг БНХАУ-аас

Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийн эх үүсвэрийн бүтэц

90.9%

-ийг дулааны
цахилгаан станцууд,

9.06%

-ийг нар, салхи, усны эх
үүсвэрүүд,

0.01%

-ийг дизель эх үүсвэр

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД

Төрөөс хамтарсан Засгийн газарт орсон намуудын төлөөлөл бүхий Эрчим хүчний үндэсний хороог байгуулсан. Тус хорооны гол зорилго эрчим хүчний салбарын бүтцийг задалж, реформ хийх, зах зээлийн харилцаанд оруулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалт орж ирэх боломжийг бүрдүүлж, эдийн засгийн хувьд орлогожсон салбарыг бий болгох зорилготой. Мөн УИХ дээр эрчим хүчний салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хэсгийг байгуулсан байгаа.

Эрчим хүчний үндэсний хорооны даргаар Монгол Улсын УИХ-ын гишүүн, Шадар сайд Т.Доржханд, Үндэсний хорооны нарийн бичгийн даргаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн ажиллаж байна. Үндэсний хорооны гишүүдээр МАН-аас УИХ-д сонгогдсон УИХ-ын гишүүн М.Энхцэцэг, Ч.Анар, АН-аас Д.Энхтуяа, С.Цэнгүүн, ХҮН намаас Ж.Золжаргал, Б.Найдалаа нар ажиллаж байна.

Мөн яамд, агентлагууд, Эрчим хүчний зохицуулах хороо, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудын төлөөлөл орсон өргөн бүрэлдэхүүнтэй хороо эрчим хүчний салбарт өөрчлөлт шинэчлэл хийхээр ажиллаж байна.



Үнэ тариф эрчим хүчний хөгжлийн гацаа юу?

Үнэ тарифыг нэмэгдүүлж, хуулийн хүрээнд индексжүүлж чадахгүй байгаа нь эрчим хүчний салбарын хөгжлийн гол гацаа болж байна.



У.САРАНГЭРЭЛ

Сэтгүүлч

М

онголын үндэсний олон нийтийн радио, телевизээс “Цахилгааны үнийг нэмэх ёстой юу” гэдэг судалгааг иргэдээс авахад 12 хувь нь “тийм” гэсэн бол 88 хувь нь “нэмэх шаардлагагүй” гэж хариулжээ. Ямар ч хүн “Би илүү мөнгө төлье” гэж гараа өргөхгүй

нь тодорхой. Сэтгүүлч би ч үнэ нэмэхийг хүсэхгүй байна. Гэхдээ эрчим хүчний салбар тартагтаа тулжээ. Хүнээр бол хөгширч туйлдсан ч ажиллах гэж хамаг хүч тамираа бараад сөгдөж унах дээрээ тулсан байна. Гэвч захирал нь “Чи ямар ч үнэ хөлсгүйгээр →



ажиллаад бай, энэ өвлийг заавал давна шүү” гэж тушааж буйтай агаар нэг. Тус салбарын цахилгаан станц, шугам сүлжээнүүд ихэнхдээ социализмын үеийнх. Насжилт нь хэдийн хэтэрч, эвдэрч хуучирсан ч инженерүүдийнхээ хүчээр арайхийн өдөр хоногийг аргацаан ажиллаж байна.

Монгол Улс зах зээлийн системд шилжсэн өнгөрсөн хугацаанд бусад салбарт хөгжил дэвшил харагдаж байгаа бол эрчим хүчний салбар харанхуй руу хурдтай уруудсаар байгаа нь бодит үнэн юм. 2001 онд УИХ баталсан Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт, шинэчлэлт оролгүй өнөөг хүрэв. “Эрчим хүчний үнэ тарифыг ярихаас өмнө засаглалаа сайжруулах хэрэгтэй. Засаглалаа сайжруулаагүй цагт үнэ нэмээд ч хэрэггүй” гэж салбарын зарим эрдэмтэн, судлаач үздэг. Гэхдээ бодит байдалд, яг одоо тулгамдсан, тулчихсан асуудал бол үнэ тарифыг зах зээлийн өртөгт нийцүүлж бага багаар нэмэхгүй бол энэ салбар энэ өвлийг давж чадахгүйд хүрээд байна гэдгийг гал голомтод нь ажиллаж буй, зовлонг нь мэдэх мэргэжилтнүүд учирлаж буй. Ер нь эрчим хүчний салбарт засаглалын ч, үнэ тарифын ч асуудлыг хөндөж, тодорхой алхмууд хийхээс аргагүй байдалд байгааг төр, засаг ойлгох ёстой.

Өнгөрсөн есдүгээр сарын сүүлчээр болсон “Шинэ эрчим хүчний чуулган 2023”-аар салбарын засаглалын асуудлыг түлхүү хэлэлцэж, тулгамдсан асуудлуудаар ярилцсан. “Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдлыг авч явах салбараа нийгмийн халамж руу хамж оруулсан. Саармагжиж, үндсэн зорилгоосоо хазайсан учраас бид өнөөдөр хүмүүст муухай харагдаж байна. Эрчим хүчний салбарын гол зорилго хэрэглэгчийг

чанартай, найдвартай эрчим хүчээр тасралтгүй хангах. Бид энэ зорилгынхоо төлөө л ажиллах ёстой. Эрчим хүчээр хангадаг үүрэг, зорилготой болохоос биш халамжийн байгууллага биш” гэдгийг оролцогчид хэлсэн билээ.

Өнөөдөр эрчим хүчний салбар 224 төгрөгийн өртгөөр бүтсэн бүтээгдэхүүнээ 175 төгрөгөөр борлуулж байна. Ингэж алдагдалтай ажилладаг учир 2020 онд 88.1, 2021 онд 77.8, 2022 онд 187.3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээжээ. Үүнд эрчим хүч, дулааны тарифыг үйлдвэрлэлийн зардлаас үргэлж багаар тогтоож ирсэн буюу зарим хэрэглэгчид 68 хувийн бага үнээр нийлүүлж буй нь нөлөөлсөн байна. Алдагдал жилээс жилд өсөж буй энэ үед айл өрхийг цахилгааны төлбөрөөс бүрэн чөлөөлсөн шийдвэрийг Засгийн газар цар тахлын үеэр гаргасан. Хэдийгээр энэ нь хүнд хэцүү цагт ард иргэдээ бодсон шийдвэр мэт боловч нөгөө талдаа эрчим хүчний үнэ цэнийг улам унагасан, цахилгааныг үнэгүйдүүлж, хямд хэрэглээ мэт ойлголтыг ард иргэдэд төрүүлсэн юм. Эрчим хүчний салбар халамжийн байгууллага биш, цаг тутамд технологийн шинэчлэлт хийж, хөрөнгө эргэлдэж байх ёстой талбар гэдгийг мэргэжилтнүүд нь санаа алдан хэлсээр...

Үнэ тарифыг нэмэх шалтгаан

Эрчим хүчний хангамжийн сүлжээ, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч элэгдсэн, дулааны цахилгаан станцуудын цахилгаан дамжуулах шугамын дийлэнх хэсэг, дулааны шугам сүлжээний дамжуулах хоолойн 30, дэд станцын 30 хувь нь тус бүр 30-аас дээш жил болж ашиглалтын

Сүүлийн 10 жилд дулаан, эрчим хүчний шугамын алдагдал 3-4, цахилгаан эрчим хүчнийх 13-15 хувьд хүрснийг 2023 оны төсвийн төсөлд тэмдэглэжээ.

хугацаа дууссан. Сүүлийн 10 жилд дулаан, эрчим хүчний шугамын алдагдал 3-4, цахилгаан эрчим хүчнийх 13-15 хувьд хүрснийг 2023 оны төсвийн төсөлд тэмдэглэжээ. Нэг ёсондоо чадлын дутагдалд ороод байна гэсэн үг. Эрчим хүчний эх үүсвэрүүд нөөц тоноглолгүйгээр бүрэн хүчин чадлаараа ажиллаж буй бөгөөд аль нэг тоноглолд гэмтэл гарвал хүчин чадлынх нь хэмжээгээр хэрэглээг хязгаарлах эрсдэлтэй нөхцөл үүссэн. Өнөөдөр Монгол Улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 1544 мегаватт. Үүнийг 2030 он гэхэд хоёр дахин өсгөх зайлшгүй шаардлага бий. Үнийн өсөлт, мөнгөний ханшаас шалтгаалан тус салбарт ажиллагсдын ажилд орж, гарах хөдөлгөөн мөн ихэсжээ. Цалин хөлсийг нь боломжийн хэмжээнд өгч чадахгүй, засвар, шинэчлэлтээ ч хийж чадахгүй хэмжээнд хүрсэн байна.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх “Иргэд, аж ахуйн нэгжүүд хэрэглэж буй цахилгаан, дулаанаа үйлдвэрлэлийнх нь бодит өртгөөр худалдан авах хэрэгтэй. Эрчим хүчний салбарын санхүүгийн алдагдал жилээс жилд нэмэгдэж байна. Энэ оны байдлаар 240 орчим →

Айл өрхүүд
цахилгаан,
дулааны нэг
сарын зардалд
орлогынхоо

2.4-4.4

хувийг
зарцуулдаг

тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар байна. Уг алдагдлын цаана хийж чадаагүй засвар, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил, төлж чадаагүй бэлтгэн нийлүүлэгчдийн өглөг, авлага бий. Бид үнийг дор хаяж өртөгт нь хүргэх шаардлагатай байна. Үнэ тарифын асуудлыг хариуцсан бие даасан Эрчим хүчний зохицуулах хороо гэж байгууллага бий. Бид өнөөдөр аж ахуйн нэгж, яамнаас эрх бүхий байгууллагад саналаа байнга тавьж байгаа. Энэ асуудлыг удахгүй шийдэх байх” хэмээн телевизүүдэд өгсөн яриандаа дурджээ.

Нэг судалгаанаас эш татъя. Айл өрхүүд цахилгаан, дулааны нэг сарын зардалд орлогынхоо 2.4-4.4 хувийг, харин гар утас болон интернэтийн төлбөрт 10 орчим хувийг төлж буй судалгааг Эрчим хүчний зохицуулах хорооноос хийжээ. Гэтэл эрчим хүчний хэрэглээ өнгөрсөн оны мөн үеэс 127 мегаваттаар өссөн. Тиймээс ахуйн хэрэглээний эрчим хүч, дулааны тарифыг 28 хүртэлх хувиар нэмэгдүүлэх саналыг Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргаад байгаа юм.

Өнгөрсөн оны аравдугаар сард аж ахуйн нэгжүүдийн цахилгааны үнийг 14-38 хувиар

нэмж, 215 төгрөгт хүргэсэн. Өртөгт нь жаахан ойртуулсан гэсэн үг. Харин айл өрхийн цахилгааны үнийг нэмээгүй. Үүнд эдийн засгийн нөхцөл байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, айл өрхүүдийн орлого хүнд буйг харгалзан үзжээ. Аж ахуйн нэгжүүдийн цахилгааныг хэрэглээнээс нь хамаараад ялгаатай тухайлбал, 5000 кВт.цаг хүртэлхийг 14 хувь, 5000 кВт.цагаас дээшихийг 24, өндөр хэрэглээтэй уул уурхай, экспортын том хэрэглэгчдийг 38 хувиар нэмжээ.


Тэгвэл айл өрхийн цахилгааны төлбөрийг дунджаар 28 хувиар нэмэх саналд хэрэглээнээс нь хамаараад ялгавартай тогтоох тарифыг оруулжээ. Тодруулбал, 150 кВт.цагаас ихгүй хэрэглээтэй айл өрх нэг кВт.ц цахилгааны төлбөрт сардаа 134.28 төгрөг төлдөг байсан бол 171.88 төгрөг болно. Харин 150-300 кВт.цаг нь 197 төгрөг, 300-гаас дээш кВт.цаг хэрэглэсэн айл өрх 229 төгрөг төлөх тооцооллыг Эрчим хүчний зохицуулах хорооноос хийсэн байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-д үнэ тарифыг индексжүүлэх гэдэг заалт бий. Үүнд, эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчилнэ, хэрэглэгчийн дундаж тарифыг бодит өртөг, ашгийн зохих түвшнийг хангасан хэмжээнд хүргэж, индексжүүлэх гэж тусгажээ. Харин Эрчим хүчний тухай хуулийн 26.2-д үнэ тариф тогтоохдоо үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах, үнийг инфляцтай уялдуулан тооцох зарчмыг баримтална гэж заасан. Тэгвэл Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрхэд тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж

батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх гэж заажээ. Гэтэл 2014 оноос хойш үнэ тарифыг нэг л удаа индексжүүлэх оролдлого хийсэн байдаг. Нэг үгээр хэлэхэд, үнэ тарифыг нэмэгдүүлж, хуулийн хүрээнд индексжүүлж чадахгүй байгаа нь эрчим хүчний салбарын хөгжлийн гол гацаа болж байна.

Алдагдалтай тариф мөрдөж буй тохиолдолд хөгжил дэвшил, гадаадын хөрөнгө оруулалт, засаглал, зах зээлийн эдийн засгийн гол хүчин зүйл болсон хувийн хэвшлийнхний оролцооны тухай бодоод ч хэрэггүй. Нөгөө талаар эрчим хүчний салбарт бодлого, хууль эрх зүйн орчин бүрдчихсэн. Гагцхүү хуулийг мөрдөхгүй байгаа нь асуудал болж байна. Учир нь эрчим хүчний салбарыг арилжааны хэлбэрт шилжүүлэх, алдагдалгүй үнэ тариф мөрдүүлэх асуудлуудыг тусгасан Эрчим хүчний тухай хуулийг УИХ 2001 онд баталчихсан. Харин хуульд заасан алдагдалгүй үнэ тариф мөрдүүлэх агуулгыг хэрэгжүүлэхгүй, мөрдөхгүй өнөөг хүрсэн нь тус салбарын уналтын хамгийн том шалтгаан болж байна.

Эрчим хүчний салбар хуулиа мөрдөж, засаглалаа сайжруулж, бодлогоо шинэчилж, салбартаа зах зээлийн салхи сэвэлзүүлэх цаг иржээ. Зах зээлийн салхи сэвэлзүүлэх эсэхийг шийдэх хамгийн том эрх Засгийн газар, Ерөнхий сайдад л бий. Хуулийг Засгийн газар мөрдөж, хэрэгжүүлж ажиллах ёстой. Үе үеийн Засгийн газар сонгуулийн, улс төрийн шийдвэр гаргаж ирснээр эрчим хүчний салбарыг уналтад хүргэснийг бүгд харж байна. Харин өнөөгийн засаг ирэх оны сонгуулиа бодоод асуудлыг хойшлуулах уу, эсвэл улс орны хөгжлийг бодоод урагшаа нэг алхах уу гэдэг түүхэн сонголт дээр тулж ирлээ. ●




ЦАХИЛГААНЫ НЭГЖИЙН ӨРТӨГ БА ДУНДАЖ ҮНЭ

(ТӨВИЙН БУС), ТӨГ/КВТ.Ц




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛДАГДАЛ

ТЭРБУМ ТӨГРӨГ



АЙЛ ӨРХИЙН НЭГ САРЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

(ТӨВИЙН БУС), ТӨГ/КВТ.Ц





Насжилт, баталгаат хугацаа нь дууссан цахилгаан станцууд



Цахилгаан, дулааны хэрэглээ өсөн нэмэгдсээр буй энэ үед станцууд сөхөрч унах дээрээ тулсан нь харамсалтай.



Насжилт, үйлдвэрийн хугацаа нь дуусаад 10-30 жил болсон ч ажилласаар байгаа нь хачирхалтай

Хэрэглэгчдийг цахилгаан дулаанаар тасралтгүй, найдвартай хангаж ажиллах ёстой станцуудын нөхцөл байдал өнөөдөр хүнд байна. Ингэж яриад, санаа зовоод олон жилийг ардаа орхилоо. Дахин ярьж сануулах цаг нэгэнт иржээ.

Төвийн эрчим хүчний системийг бүрдүүлдэг дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолын насжилт 10-30 жилээр хэтэрч, Дулааны IV цахилгаан станцаас бусад нь өндөр настай болсон.

Дулааны цахилгаан станцуудын үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа

гэдэг нь станцуудын зуух, турбин генераторууд өндөр параметртэй орчинд (439-560 градусын халуун, 39-138 кгс/см²) 220 мянган цаг ажиллах нормыг хэлдэг байна. Энэ нь ойролцоогоор 30 жил ажиллах ёстой гэсэн үг юм. Гэтэл Дулааны II цахилгаан станцын тоног төхөөрөмжүүд 53-62 жил ажиллаж байгаа бөгөөд нэг, дөрөв, тавдугаар зуух болон нэг, гуравдугаар турбин генераторын үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа аль эрт дуусчээ.

Дулааны III цахилгаан станцын нэг, хоёр, тавдугаар зуух болон 1-8 дугаар турбин генераторууд 40-55 жил ажиллаж байна. Тус станцад 13 зуух, есөн турбин генератор суурилагдсан байдгаас есдүгээр турбин генераторыг с 2015 онд шинэчилжээ. Харин бусад найман турбин генератор нь 220 мянган цагаас дээш ажилласан, хэзээ л бол хэзээ зогсоход бэлэн, үйлдвэрийн →



баталгаагүй болсон байна.

Дулааны IV цахилгаан станц энэ жил нас сүүдэр 40 жилийг зооглож байна. Бусад станцтай харьцуулбал зуух, турбин харьцангуй гайгүй. Долдугаар турбин генераторыг 2015 онд шинээр суурилуулж, 1-4 дүгээр турбин генераторт 2018-2020 онд шинэчлэл хийснээр 190 мянган цаг ажиллаад байна. Гэхдээ тус станц манай төвийн эрчим хүчний системийн гол тохируулгыг хийж ажилладаг учир ачаалал нь маш их хэлбэлздэг аж. Тиймээс зуухнуудын халаах гадаргуу, экран хоолойнууд, уур халаагчийн шугам хоолойны ажиллах хугацаа дуусжээ.

“Дарханы дулаан цахилгаан станц”-ын насжилт 37-58 жилд хүрсэн бөгөөд гуравдугаар зуух болон нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр турбин генераторуудын ажиллах хугацаа дууссан байна. Харин тавдугаар турбин генераторыг

2019 онд шинээр суурилуулжээ.

“Эрдэнэтийн дулаан цахилгаан станц” 36 жил ажиллаж байна. Зуухнууд нь харьцангуй гайгүй боловч нэгдүгээр турбин генераторын ажиллах хугацаа нь мөн дууссан.

Монгол Улсын төвийн эрчим хүчний системийг бүрдүүлж байгаа дулааны цахилгаан станцуудын нөхцөл байдал ийм л байна. Насжилт, үйлдвэрийн хугацаа нь дуусаад 10-30 жил болсон ч ажилласаар байгаа нь

хачирхалтай. Цахилгаан, дулааны хэрэглээ өсөн нэмэгдсээр буй энэ үед дээрх станцууд сөхөрч унах дээрээ тулсан нь харамсалтай. Үүнийг засахын төлөө төр, засаг нь санаа зовж, шинэчлэлт хийж, дорвитой шийдвэр гаргаагүй нь бүр гайхалтай санагдана. Олон үг нуршихгүйгээр энэ салбарт ажиллаж, тогоонд нь буцалж байгаа мэргэжилтний үгийг хүргэе. Түүний ярианаас дулааны цахилгаан станцуудын нөхцөл байдлыг төвөггүйхэн ойлгоно биз ээ. ●

ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦУУДЫН НАСЖИЛТ





Б.Эрхэмзаяа: Хайртай хүн маань цахилгаан байхгүйгээс зүрх нь зогсчихлоо гэдэг зүйлийг сонсохгүйн төлөө бид хичээсээр ирсэн



Улаанбаатар хотод үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч хаа байсан Баянхонгор, Завханд хүрч байна. Маш алслагдмал байдаг

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер Б.Эрхэмзаяатай ярилцлаа.

Олон жил иргэдэд цахилгаан эрчим хүч дамжуулсаар ирсэн компанийнхаа үйл ажиллагааны талаар манай уншигчдад товч танилцуулна уу?

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” компани Монгол Улсын нутаг дэвсгэрийн 66 хувь, хүн амын 72 хувийг хамарсан 5360 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг хариуцан ажилладаг. Тодруулбал, 220 кВ-ын 2024 км, 110 кВ-ын 3311,6 км, 35 кВ-ын 23,7 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон нийт 82 дэд станцын үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангаж ажиллаж байна. Нийт 1283 инженер, техникийн ажилтан Улаанбаатар, Төв, Хангай, Зүүн Өмнөд, Говийн гэсэн таван салбарын бүтцээр ажилладаг.

-Цахилгаан дамжуулах шугамуудын ашиглалтын хугацаа ямар байдалтай байгаа вэ?

-35-220 кВ-ын хүчдэлийн түвшинд төмөр

болон төмөр бетон тулгуурууд ашиглаж байна. Эдгээрээс төмөр тулгуур нь 50 жилээс дээш, төмөр бетон тулгуур нь 35 жилээс дээш ажиллах үйлдвэрийн заавартай. 110 кВ-ын агаарын шугамууд 1963 оноос ашиглалтад орсон. Төвийн бүсийн салбарт харьяалагдах Шарын гол-Дарханы хаалттай хуваарилах байгууламж, мөн 220 кВ-ын агаарын шугамууд 1976 оноос ОХУ-ын системтэй зэрэгцээ ажилладаг 257, 258-р тооцож болно. Нийт цахилгаан дамжуулах сүлжээний 70 гаруй хувийнх нь ашиглалтын хугацаа хэтэрсэн.

Ашиглалтын хугацаа нь дууссан тоноглолуудын ашиглалтыг цаашид хэрхэн авч явах талаар ямар нэгэн зааварчилгаа, дүрэм одоогоор байхгүй. Олон жилийн үечилсэн графикын дагуу үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах, хэсэгчлэн сольж шинэчлэх ажлыг л хийдэг. Үзлэгээр габарит барихгүй хазайсан, гаднын биет, тусгаарлагч элемент нэвт цохигдсон, утасны судал тасарсан, чичиргээ намдаагч гүйсэн, тулгуурын боолтон холбоос суларсан, төмөр бетон тулгуурт босоо, хөндлөн цууралт үүссэн зэрэг маш олон гэмтлийг илрүүлж яаралтай

засварлан ажиллаж байна.

Сүүлийн үед хамгийн их хүндрэл үүсгэж байгаа хүчин зүйл бол цаг уурын өөрчлөлт. Цаг агаараас болж энэ жил томоохон хэмжээний дөрвөн саатал, аваар гарсан. Өнгөрсөн нэгдүгээр сард 220 кВ-ын 203, 204 дүгээр агаарын шугамын тулгуур унасан бол гуравдугаар сард 215, 216 дугаар агаарын шугамын тулгуур, зургаадугаар сард 110 кВ-ын Хархорин А, Б (үндсэн болон нөөцийн хоёр хэлхээт) агаарын шугамын 24 ширхэг тулгуур Булган аймгийн Гурван булаг сумын нутагт унасан. Наймдугаар сард Хархорин А, Б агаарын шугамын таван ширхэг тулгуур Архангай аймгийн Хашаат сумын нутагт унасан. Үүссэн нөхцөл байдлыг манай инженер, техникийн ажилтнуудын ур чадвараар богино хугацаанд зассан ч цаашид аваар давтагдахгүй байх талаас нь судалгаа хийж эхэлсэн. Булган Өвөрхангай аймгийг холбодог 110 кВ-ын Хархорин А,Б агаарын шугам есөн аймгийн 70 гаруй сумыг цахилгаан эрчим хүчээр хангадаг. Тус шугамд 24 ширхэг тулгуур унасан нь манай компанийн түүхэнд гарч байгаагүй гэмтэл юм. Агаарын шугам утсаар хоорондоо холбоотой байдаг. Нэг тулгуур унавал нөгөөхөө татаж унагадаг аюултай. Төгсгөлийн эргэлтийн төмөр анкераас анкерын хооронд тулгуур унасан гэсэн үг. Унасан тулгууруудыг буцаагаад ашиглах ямар ч боломжгүй болсон. Бид нөөцөнд байсан бүх тоноглолоо ашиглаж засварласан.

Цаашид бид алгаслалт, хөрсний гулсалт ихтэй газруудад шугамыг хүчитгэн анкер босгох болон төмөр бетоны гадуур нь бетон болон төмөр хийцээр бөгжлөх, өлгийдөн хүчитгэх ажлуудыг хийж байна. Үүний цаана хөрөнгө мөнгө яригдана. Дамжуулах компани улсаас батлагдсан төсөв, зардлаараа л ажилладаг. Гэнэтийн аваар гарсан тохиолдолд хөрөнгө мөнгө тулгамдсан асуудал болдог.

-Хуучирч гэмтсэн шугам болон бусад төхөөрөмжөө хэрхэн засварладаг вэ? Хөрөнгө мөнгөний асуудал тулгамддаг гэж байна.

-Энэ жил Эрчим хүчний яамнаас трассын дагуу шалгалт үзлэг хийх үүрэг даалгавар өгсөн. Хугацаатай учир өөрсдийн хөрөнгөөр

хийх боломжтойг нь хийж, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Бид дээр дурдсан шиг олон жилийн графикт засвар үйлчилгээг хийхээс гадна ээлжит болон ээлжит бус үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах ажлуудыг хийдэг. Бидэнд тулгамдаж байгаа бас нэг асуудал бол дамжуулагч утасны хуучралт. Тус утас нь ган голтой хөнгөн цагаан утас байдаг. Хөнгөн цагааны гадна тал бохирдож, улмаар дотогш гол руугаа нэвчээд дунд нь бэхлэх гангуудыг зэв идэх, утсууд нь тасарч унах, унахдаа тулгууруудыг татаж унах гэмтэл гарч байсан. Чойр-Бор-Өндөрийн цахилгаан дамжуулах шугамын дамжуулагчийг лабораторид өгөхөд шаардлага хангахгүй гэдэг дүгнэлт гарсан. Үүнийг солихын тулд 20 гаруй тэрбум төгрөгийн асуудал яригдана. Монгол Улсыг хэрсэн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг бүгдийг нь нэг дор сольё гэвэл улс орны хөрөнгө мөнгөнд хэрхэн тусах билээ. 100 жилийн дотор босгосон том бүтээн байгуулалт шүү дээ.

Улс орны өөрийнх нь онцлог байна. Манайх эрчим хүчийг дамжуулахын тулд үүсгэвэр болон хэрэглэгчийн хооронд урт шугамууд татсан. Маш алслагдмал байдаг. Улаанбаатар хотод үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч хаа байсан Баянхонгор, Завханд хүрч байна. Гэхдээ Завхан аймгийн зөвхөн ахуйн хэрэглээг л хангаж, томоохон хэмжээний үйлдвэр, уурхайн эрчим хүчийг хангаж чадахгүй. Хэрвээ алслагдсан аймгийн том уурхай, үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангаж чаддаг бол цахилгаан эрчим хүч дамжуулсныхаа төлөө хөрөнгө оруулалт авдаг тогтолцоо байх хэрэгтэй л дээ. Ингэвэл эргүүлээд өртгөө нөхөөд явах боломжтой болно. Тиймээс эдийн засгийн үр өгөөж талаасаа сольж шинэчлэх л ёстой. Гэтэл эрчим хүчний салбар алдагдлаа нөхөж чадахгүй байгаа. Өр багасах биш үргэлж нэмэгдэж байна. Тиймээс техникийн шинэчлэлд оруулах хөрөнгө алга.

-Дэлхийд манайх шиг алслагдмал газар руу урт татсан агаарын шугамтай орон цөөхөн гэдэг. Хэрэв ямар нэгэн гэмтэл гарвал зардал ихтэй, хүрэх газар нь хол юм, тийм үү?



Ашиглалтын хугацаа нь дууссан тоноглолуудын ашиглалтыг цаашид хэрхэн авч явах талаар ямар нэгэн зааварчилгаа, дүрэм одоогоор байхгүй. Олон жилийн үечилсэн графикын дагуу үзлэгээр илэрсэн гэмтлийг устгах, хэсэгчлэн сольж шинэчлэх ажлыг л хийдэг



Бид хоорондоо
“Хамгийн
зоригтой эр
бол халуун
хөнжлөөсөө
дуудагдах”
гэж хошигнож
ярьдаг. Аваар
гарсан үед
өөрийнхөө
унаагаар
ирнэ. Цаана
нь хэрэглэгч
байгаа учраас
бидэнд унтах
эрх байхгүй

-Монгол Улс эрчим хүчний сул системтэй. Үүсгэврээс хэрэглэгчид очихдоо хоёр хэлхээгээр очно. Хэрэв энэ хоёр хэлхээ унавал аюултай. ОХУ, Монгол хоёр ижилхэн сул системтэй. Барууны орнууд газар нутаг багатай. Дээрээс нь хэрэглэгч, хүн ам нягтаршил ихтэй учраас хэрэглэгч, үүсгэвр хоёрын хооронд 3-4 шугамаар зэрэгцээ ажиллагаанд холбогдохдог. Нэг шугам нь гэмтэхэд нөгөө гурав нь аваад явчихдаг учраас их найдвартай байдаг. Манайх газар зүйн тархмал байдлаасаа шалтгаалж сул систем гэж нэрлэгддэг. Эрчим хүчний салбар үүсгэврийн томоохон дутагдалтай. Сүүлийн 40 жилд томоохон үүсгэвр баригдсангүй.

-“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д улсаас жилд хэчнээн төгрөг төсөвлөдөг вэ? Төсөвлөсөн хөрөнгө нь үйл ажиллагааны зардалд хүрэлцдэг үү?

-Урсгал болон их засварын ажилд 10 орчим тэрбум төгрөг төсөвлөдөг. Үүсгэвр нь хязгаартай учраас ирүүлж байгаа саналуудын 60-70 хувийг хасаж, дотор нь эрэмбэлж, хөрөнгө мөнгөндөө багтааж тухайн жилдээ батлагдсан ажлуудыг 100 хувь хийж өвлийг давдаг. Манай инженер, техникийн ажилчдаас “110 кВ-ын цахилгааны шугамын урсгал засварт 200 төгрөг хуваарилсан байна” гэдэг гомдол санал ирдэг. Инээдтэй ч юм шиг, гомдмоор ч юм шиг байгаа биз. Тоосжилт ихтэй цахилгааны шугамыг арчих материал авах гэхээр 200 төгрөг нь хүрдэггүй. Хөөрхий монтерүүд маань бээлий, хувцсаараа арчдаг. Гэхдээ алхам алхмаар өөрчлөгдөж байгаа зүйл ч бий. Бид өөрсдийн нөөц бололцоогоор мэдээллийн хяналтын системтэй болж байгаа. Ингэснээр 12 станцыг алсаас хянах боломжтой болох юм. Гадаадын донор орнууд болон дотоодын эх үүсвэр, хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжөө сольж байна. 220 кВ-ын хүчдэлийн түвшингийн хэмжүүрийн трансформатор, таслуурууд солигдсон. Хуучны тосон таслуурыг хийн таслуураар солих ажил дуусаж байна. Мөн хүчний трансформаторуудыг сольж байгаа. Хамгийн тулгамдсан асуудал нь цахилгаан дамжуулах агаарын шугамууд болоод байна. Эдгээр

шугамыг бид алхам алхмаар шинэчлэх хэрэгтэй. Шинэчилж хараахан чадахгүй байгаа шугамуудын заримынх нь дамжуулах чадварыг өөрчилж, сүүлийн үеийн алдагдал багатай утсаар солих техникийн ажлууд хийгдэж байна. Ингэж бага багаар солих замаар өсөн нэмэгдэж байгаа цахилгааны хэрэглээг хангахаас өөр арга алга.

-Энэ салбарт олон залуус ажилладаг.


Цалин мөнгө тааруу учраас олноор ажлаасаа гарч байгаа гэсэн. Танайх ямар байдалтай байна вэ?

-Залуучууд олноороо ажлаасаа гарч байна. Сурсан мэдсэнээрээ ажиллах гэхээр цалин бага учраас ар гэр нь хэцүүдэх гээд байдаг. Салбарын цалингийн доод хэмжээ 880 мянган төгрөг. Үүнээсээ нийгмийн даатгалаа хасуулна. Ганц бие хүн хүртэл амьдрахад бэрх цалинтай. Инженер нь нэг сая гаруй төгрөгийн цалин авдаг. Ийм бага цалингаар их ажлыг өдөр шөнөгүй хийж байна шүү дээ. Аваар гарлаа гэхэд унтах эрх бидэнд байхгүй. Бид хоорондоо “Хамгийн зоригтой эр бол халуун хөнжлөөсөө дуудагдах” гэж хошигнож ярьдаг. Аваар гарсан үед өөрийнхөө унаагаар ирнэ. Цаана нь хэрэглэгч байгаа учраас бидэнд унтах эрх байхгүй. Улсын компанид ажиллаж, их зүйл сурсан ажилчдыг уул уурхай компаниуд мөнгөөр цохиод авчихдаг. Тэднийг бага ч гэсэн тогтоож аргамжих арга бол цалин шүү дээ.

Сүүлийн хэдэн жилд манайх орон сууцны дэмжлэг ажилчдаа үзүүлж чадаагүй. Хашаа байшингийн дэмжлэг гэж гурван сая төгрөг л өгдөг. Бололцоо нь тэр. Хүн байхгүй бол техник нь байгаад ч ажиллахгүй шүү дээ. Эрчим хүчний салбар нь ахмад, дунд, залуу үеийн холбоостой. Ахмад үе маань дунд үеэ боловсруулах, туршлагаа өвлүүлж үлдэх харин дунд үе нь залуу үеэ хамгаалах, ажил мэргэжилдээ дуртай болгох, бахархах сэтгэлийг нь төрүүлэхийг хичээж ажилладаг. Бид айл бүрийн цахилгааныг асааж өгдгөөрөө бахархаж, хийж байгаа ажлаа үнэнчээр, алдаа дутагдал гаргахгүйн төлөө ажилладаг. Хайртай хүн маань цахилгаан байхгүйгээс зүрх нь зогсчихлоо гэдэг зүйлийг сонсоод суухгүйн төлөө бид хичээж ажилласаар ирсэн.



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ НИЙТ ХЭРЭГЛЭЭ БОЛОН ЭРЧИМ ХҮЧНИЙ СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ



ЦЭХ-ний суурилагдсан хүчин чадал 1,574.4 МВт


ДЦС: 1,269.0 МВт, **80.6%**
СЭХ: 296.8 МВт, **18.9%**
Дизель ЦС: 8.6 МВт, **0.6%**

ДЭХ-ний суурилагдсан хүчин чадал 6,275.9 МВт

Төвийн бүс: 3,971.0 МВт, **63.3%**
Орон нутаг: 1,275.9 МВт, **20.3%**
Аймаг, нийслэл 33: 1,029.0 МВт, **16.4%**

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФЫН ХАРЬЦУУЛАЛТ

Зарим орнуудын хэрэглэгчдийн цахилгааны дундаж үнийн харьцуулсан судалгаа, ам.цент/кВт.ц



Манай улсын 1 кВт.ц цахилгааны үнэ дунджаар **6.3 ам.цент** (215.69 төгрөг) байна. ОХУ-ны цахилгааны үнээс айл өрх **65 хувиар**, ААНБ **32 хувиар**, ВЬНАМ-ын цахилгааны үнээс айл өрх **89 хувиар**, ААНБ **23 хувиар** хямд байна.



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд, мөн Хорооны Эрчим хүчний салбарын 2022 оны баримтлалтай оролцон нийлэгжүүлсэн.


https://www.globalenergyprices.com/electricity_prices/

<https://worldpopulationreview.com/countries/countries-by-gdp/>


ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭ



УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ



ТӨВИЙН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМНИЙ ОРГИЛ АЧААЛЛЫН ТААЦ



ИМПОРТООР ХУДАЛДАЖ АВСАН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

ОХУ-аас худалдаж авсан ЦЭХ сая.кВт.ц

Үзүүлэлт	ТБНС	БЭЭХС	Бусад	Нийт
2021 он	333.7	153.1	0.1	486.9
2022 он	510.5	183.8	0.1	694.3
2023 он	752.7	285.2	0.1	938.0
Өөрчлөлт	Биет 222.2	21.4	0.0	243.7
Хувь	43.5%	11.7%	51.5%	35.1%

38 хувь

Төлбөр: 214 тэрбум төг



БНХАУ-аас худалдаж авсан ЦЭХ сая.кВт.ц

Үзүүлэлт	Оюу-толгой	БЭЭХС	Бусад	Нийт
2021 он	1,339.5	9.2	26.3	1,375.0
2022 он	1,427.5	10.0	29.6	1,467.2
2023 он	1,436.9	10.2	32.6	1,509.7
Өөрчлөлт	9.4	0.2	33.0	42.5
Хувь	0.7%	1.5%	111.3%	2.9%

62 хувь

Төлбөр: 464 тэрбум төг

Эх сурвалж: ЭХЯ



Эрчим хүчний үнийг дэлхийн жишигт хүргэх шаардлагатай



Ү.ТӨМӨРХҮЯГ:
ДЦС-4 ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал

Монгол Улсын эрчим хүчний салбар өвлийг өнтэй давах эсэх нь Дөрөвдүгээр станц өвлийг хэрхэн давахаас бүрэн шалтгаалдаг. Манай станц нийт эрчим хүчний 58 хувийг үйлдвэрлэж байна. Өнөөдөр станцын зуухнуудын халах гадаргууны хугацаа дуусаж, даруй солих шаардлагатай болсон. Хөрөнгө мөнгөнөөс шалтгаалж, зөвхөн гэмтсэн хэсгийг л хэсэгчлэн засварлаад явж байна. Зуухнууд эхнээсээ цоорч эхэлсэн бөгөөд цоорч зогсох тохиолдол ихсэж байна. Өвлийн их ачааллын үед нэг зуух цоороод зогсоход хамгийн багадаа 100 мегаватт ачаалал

хаягдаж байгаа юм. Хэрэв нэг аймгийн төв 10 мегаватт хэрэглэдэг гэж үзвэл 10 аймгийн төв цахилгаангүй болж байна гэсэн үг. Дөрөвдүгээр станцын эрчим хүчний үйлдвэрлэл эцэстээ тулчихвал эрчим хүчний үнэ гэрлийн хурдаар өснө. Ийм хямдхан үнээр өнөөг хүртэл явж ирсэн бол цаашаа өсөн нэмэгдэж буй хэрэглээ өндөр үнэтэй орж ирж буй учраас үнэ жил бүр өндөр хувиар өсөхөөс аргагүй. Учир нь хямдхан үйлдвэрлэдэг эх үүсвэр нь нөөцөө барж байна шүү дээ. Цаашид нөөцтэй яриад ч хэрэггүй болсон. Тиймээс эрчим хүчний үнийг дэлхийн жишигт хүргэх шаардлагатай.

Эрчим хүчний үнэ хямд учраас хэрэглэгчид цахилгаанаа хэмнээ гэж бодохгүй байна



Р.ДАГДАН:
“УБЦТС” ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал

Юутай ч эх үүсвэрийн дутагдалд орчихсныг нийтээрээ мэдэрлээ, ойлголт авлаа. Манай компанийн хувьд тулгамдсан асуудлууд бий. Асуудлуудаа нэг дор нэг мөр шийдэх боломжгүй. Олон улсын жишгийн дагуу бусад улсад түгээх компаниуд бүгд ухаалаг тоолуурын системд шилжихсэн. Гэтэл эрчим хүчний салбарын хамгийн олон буюу 490 мянган хэрэглэгчтэй “УБЦТС” ухаалаг тоолуурын системд шилжиж чадаагүй байна. Ухаалаг тоолуурын технологийн асуудлыг шийдэж, энэ системд даруй шилжих шаардлага үүссэн. Дараагийн асуудал гэвэл, нийслэлийн гэр хорооллуудын цахилгаан эрчим хүчний чанарын асуудал учир дутагдалтай хэвээр байсаар байна. Хамгийн гол асуудал, эрчим хүчний салбарын ажилтнуудын цалин бага байна. Мэргэжлийн, туршлагатай ажилтны нөөц ажлын ачаалал, цалин хөлсний асуудлаас болж алдагдаж байна. Энэ нь эрчим хүчний салбарын хөгжлийг зах зээлийн зарчмаар нь явуулахгүй байгаатай холбоотой. Төр тодорхой хэмжээнд оролцож, бодлогоор явуулж байгаа нь нөлөөлж байна гэж боддог. Уг нь эрчим хүчний салбарын үнэ тарифыг чөлөөлж, цэвэр арилжааны хэлбэрээр нь явуулбал дорхноо технологигоод босоод ирэх

салбар. Хөгжлийн гол суурь салбар шүү дээ. Гэтэл өөрчлөлт шинэчлэл, технологижих процесс явагдахгүй олон жил болсноос өнөөдөр ийм хүнд байдалд орж байна.

Та үнэхээр эх оронч байхыг хүсдэг бол оргил цагуудад эрчим хүчээ хэмнээрэй гэж хэлье. Эрчим хүчний үнэ хямд учраас хэрэглэгчид цахилгаанаа хэмнээ гэж хичээдэггүй, боддоггүй. Хүссэн хэмжээгээрээ хэрэглэнэ, төлбөрийг нь төлчихнө гэсэн ойлголт энгийн зүйл болчихсон байна.

Манай салбарын ахмад хүн надад үндэсний аюулгүй байдал хэр хангагдаж байгааг 17.00-22.00 цаг тодорхойлж байна гэж хэлсэн. Энэ айхавтар үг шүү. Юу гэж бодогдсон гэхээр хэмнэнэ, гамнана гэдэг нь дараагийн асуудал юм байна. Хамгийн том ойлголт эх оронч байа. Одоо эх оронч байгаач гэж хэлж, ярьдаг болсон шүү дээ. 17.00-22.00 цаг нь үндэсний аюулгүй байдал, салбар, системийн асуудал болоод байна. Би Монгол Улсын иргэн. Эх орныхоо төлөө зүрх цохилдог гэсэн сэтгэлгээ хандлагаа 17.00-22.00 цагийн хооронд гаргаач ээ. Энэ талаас нь ойлгож хандаарай гэж уриалмаар байна. Үндэсний аюулгүй байдал гэж ярихаар юун том зүйл ярьдаг юм гэх байх. Үнэхээр тулчихсан асуудал шүү.

Станцуудад аваар, саатал гарахгүй гэх баталгаа алга



Т.БАТДОНДОГ:
Эрчим хүчний
яамны Эрчим
хүчний бодлогын
хэрэгжилтийг
зохицуулах газрын
Дулааны хэлтсийн
дарга

Эрчим хүчний үйлдвэрлэлийн үндсэн тоноглол зуух, турбин генераторын их засварыг дөрвөн жилд нэг удаа, урсгал засварыг хоёр жил тутамд хийх ёстой. Компаниуд аваар, саатлаас сэргийлж, өөрийнхөө хэмжээнд засвараа хийгээд л байна. Гэхдээ үйлдвэрийн баталгаат хугацаа нь дууссан тоноглолтой учир хэзээ л бол хэзээ аваар саатал гарахгүй гэх баталгаа байхгүй шүү дээ.

Дулааны III цахилгаан станцын есөн турбин генераторын найм нь, “Дарханы дулаан цахилгаан станц”-ын таван турбин генераторын дөрвийнх нь хугацаа дууссан байхад яаж болж бүтэж байна гээд яриад суух вэ дээ. Станцууд үнэхээр хэцүү байдалд байна.

Өвлийн их ачаалалд тулсан тоноглолтой ажиллаж байгаа үед зуухнуудын халаах гадаргуу нь хагараад явахгүй, засварлаад явуулах хугацаанд тухайн тоноглолын хүчин чадлын хэмжээгээр цахилгаан, дулааны эрчим хүчний хязгаарлалт хийнэ.

Их хэмжээний эрчим хүчний дутагдал үүсвэл зарим газарт хөлдөлт болохыг үгүйсгэхгүй. Ийм байдал тулж ирсэн тул шинээр цахилгаан, дулааны станцуудаа яаралтай барих хэрэгтэй. Жил болгон бага чадлын эх үүсвэрүүд орж байгаа боловч том чадлын эх үүсвэрүүдээ нэн тэргүүн ээлжинд хэрэгжүүлж, ашиглалтад оруулах нь чухал байна.

Мөн салбарын мэргэжилтэй ажилчид ажлаасаа их гарч байна. Дулааны III, IV цахилгаан станцын ажилчид зуу зуугаараа ажлаасаа гарч гадагшаа явж байна. Шинэ ажилтан аваад шууд ажилд нь оруулж болдоггүй салбар. Өчнөөн сар жил дадлагажиж байж хийдэг ажлуудыг хүмүүс нь хаяад явчихаар боловсон хүчний асуудалд орж байна. Тиймээс эрчим хүчний үнэ тарифыг зохистой түвшинд хүргэж салбарын ажилчдын цалин хөлс, хөрөнгө оруулалт, бусад хүндрэлтэй зүйлийг дариу шийдэх хэрэгтэй байна.

Эрчим хүч бол халамж үзүүлдэг салбар биш



Ц.СҮХБААТАР:
Эрчим хүчний
ассоциацийн тэргүүн

Эрчим хүчний үйлдвэрлэл аль ч улсад өртөг зардлаа нөхөж байх ёстой, ингэснээр эрүүл эдийн засаг бий болдог. Гэтэл манай эрчим хүчний салбар хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Үнэ тарифыг өнөөг хүртэл хатуу барьж байна. Эрчим хүчний тухай хуульд үнэ тарифыг өртөг зардлаас нь доогуур барина гэсэн заалт байхгүй, харин өртгөө нөхсөн үнэ тарифыг мөрдөнө, эрчим хүчээр найдвартай хангана гэсэн заалт байдаг. Орлого багатай, төлбөрийн чадваргүй хэрэглэгчдэд хямд эрчим хүчээр дамжуулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь ч буруу зарчим юм.

Эрчим хүчний салбарынхны эхний үүрэг бол улс орноо, хэрэглэгчдээ найдвартай эрчим хүчээр хангах ёстой. Өртгөө хаасан үнэ тариф мөрдөж, үйл ажиллагаа явуулах зарчимтай. Ямар ч тохиолдолд эцсийн хэрэглэгч өртөг зардлаа хаасан үнэ төлж байж эрүүл зах зээл бий олно. Эрчим хүчний үнэ тарифыг бага байлгаж дэмжлэг үзүүлэх биш төлбөрийн чадваргүй хэсэгт захиргааны

шугамаар, хөдөлмөр нийгмийн хамгааллын шугамаар дамжуулан дэмжлэг үзүүлбэл зөв шийдэл болно. Эрчим хүч бол халамж үзүүлдэг салбар биш. Эрчим хүчнийхэн хямд цахилгаан борлуулж халамж үзүүлэх зарчмаа өөрчилж, хуульд заасан найдвартай, чанартай эрчим хүчээр хэрэглэгчдийг тасралтгүй хангах үүргээ л биелүүлэх ёстой. Эрчим хүчний үнийн хөнгөлөлтийг халамжийн байгууллагын шугамаар үзүүлбэл зөв зарчимд орно. Энэ нь төрийн нуруунд очих ачааг ч багасгана. Эрчим хүчний үнэ хямд байх нь эрчим хүчний салбарын ирээдүйн хөрөнгө оруулалтад хүндрэл учруулсаар байна.

Цахилгаан, дулааныг үйлдвэрлэх процесс байгалийн хуулиар явагддаг учир орлого багатай, төлбөрийн чадваргүй хэрэглэгчдийг хангахад зориулсан хямд эрчим хүч үйлдвэрлэх ямарч боломжгүй гэдгийг тал талдаа ойлгох шаардлагатай байна.



Би үнэ тариф нэмснийхээ төлөө ажлаасаа халагдсан хүн



Р.ГАНЖУУР:
Монголын
эрчим хүчний
инженерүүдийн
холбооны тэргүүн,
Эрчим хүчний
зохицуулах газрын
дарга асан

Эрчим хүчний зохицуулах хороо 2022 оны арванхоёрдугаар сард зөвхөн аж ахуйн нэгжийн цахилгааны үнийг маш зөв тооцоо судалгаатай нэмсэн. Харин одоо ард иргэдийн цахилгааны үнийг нэмэхээр судалгаа хийж байгаа юм билээ.

Эрчим хүч улстөрчдийн хоол идэш болчихдог онцлогтой. Ер нь бол Эрчим хүчний зохицуулах хорооны ажил хэцүү, амаргүй шүү. Нэг талаас эрчим хүчний компаниуд үнэ тариф нэмсэнгүй гэж шаардлага тавьдаг, нөгөө талаас ард түмэн үнэ тариф нэмлээ гэж уурлаж бухимддаг. “Хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий” гэсэн үг байдаг даа. Тухайлбал, би Эрчим хүчний зохицуулах газрын даргаар ажиллаж байх үедээ үнэ тариф нэмснийхээ төлөө ажлаасаа халагдсан хүн учраас үүнийг сайн мэднэ. Намайг өдий зэрэгт хүргэсэн эрчим хүчний салбарын хамт олондоо үргэлж баярлаж, бахархаж, хүндэтгэж явдаг. Тийм ч учраас салбарынхаа сайн муу, ярвигтай, хүнд хэцүү байдлыг амьдралаараа туулж үзсэн хүний хувьд олон нийтэд, ард түмэнд аль болохоор зөвөөр ойлгуулахыг хичээж явна даа.

Эрчим хүчний салбарын хувь заяа гурван хүний гарт байдаг. **Нэгдүгээрт**, ард иргэд. Ард иргэд эрчим хүчийг ойлгохгүй явсаар өдийг хүрлээ. Алдагдалтай эрчим

хүчний үнийг засах гэсэн шийдвэр бүрийг эсэргүүцэж ирсэн. Яагаад эрчим хүчний үнэ алдагдалтай байх ёстой гэж тэд бодоод байгаа юм. Монголд үнэхээр ойлгомжгүй зүйл юу байдаг вэ гэвэл энэ л байна. Харин өнгөрсөн арванхоёрдугаар сарын дундуур оросууд манайд өгдөг импортын эрчим хүчээ хоёр дахин бууруулна гэснээс хойш одоо болохоо байж байна гэж бодсон уу, жаахан ойлгох шиг болсон. **Хоёрдугаарт**, эрчим хүчний хувь заяа Ерөнхий сайдын гарт байдаг. **Гуравдугаарт**, эрчим хүчний хувь заяа Эрчим хүчний сайдын гарт байдаг.

Эрчим хүчний салбарт хүндрэлтэй олон асуудал бий. Тэдгээрийг шийдэхийн тулд юун түрүүнд тулгамдсан гурван асуудлыг эхлээд шийдэх ёстой. Нэгдүгээрт, Улаанбаатар хотын дулааны хомсдлыг шийдэж, Тавдугаар цахилгаан станцыг хоёрдугаар цахилгаан станцын газар дээр барих хэрэгтэй. Хоёрдугаарт, хойд хөршийн эрчим хүчний хараат байдлаас гаргах Эгийн голын усан цахилгаан станцыг НҮБ-ын Тусгай хорооны хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлүүлэх хэрэгтэй. Гуравдугаарт, алдагдалтай үнээр эрчим хүч худалдахыг бүрмөсөн зогсоох. Энэ гурван асуудлыг шийдэж чадваас эрчим хүчний салбарын гацааг мулталж чадна.

Төр салбарын засаглалыг дангаараа хариуцаж ирсэн



Ж.ОСГОНБААТАР:
Сэргээгдэх эрчим
хүч үйлдвэрлэгчдийн
холбооны
ерөнхийлөгч

Монгол Улсад өнөөдрийг хүртэл эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн засаглалыг бараг бүхэлд нь төр дангаараа хариуцан эрхэлж ирлээ. Улс орны эдийн засаг огцом тэлж өсөхийн хэрээр эрчим хүчний хэрэгцээ нэмэгдэж байна. Нөгөө талаар хүмүүсийн амьдралын түвшнийг сайжруулах, нийгмийн ялгааг багасгах, байгаль орчны доройтлыг бууруулах зэрэг тулгамдсан зорилтыг шийдвэрлэхийн

тулд асар их хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан, мөн гадаадын зээл тусламжийн үлэмжхэн хэсгээр шинэчилж ирсэн эрчим хүчний салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг урьд урьдынхаас илүү хариуцлагатай, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох шаардлага хурцаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний засаглалаас нийгэм бүхэлдээ хамааралтай байна.

Эрчим хүчний засаглалаа сайжруулмаар байна



Д.ҮЛЭМЖ:
Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрчим хүчний сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

Юуны түрүүнд эрчим хүчний засаглалыг өөрчлөх хэрэгтэй. Жишээ нь, Эрчим хүчний зохицуулах хорооны таван зохицуулагчийн гурвыг нь Засгийн газар буюу Ерөнхий сайд томилдог. Үүнийг УИХ томилдог болох хэрэгтэй. Засгийн газар үнэ тарифын ямар нэгэн өөрчлөлт хийх болохоор сонгуулиас айчихдаг. Эрчим хүчний зохицуулах хороо цэвэр хараат бус байгууллага байх ёстой. Зах зээлээ соргоогоор мэдэрч түүндээ таарсан арга хэмжээг авах хэрэгтэй. 2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуулинд анх “Эрчим хүчний зохицуулах хорооны гишүүнийг УИХ сонгоно” гэсэн байсныг Засгийн газар болгочихсон нь алдаа болсон. Дээр нь энэ салбарт хувийн өмчийн оролцоог нэмэгдүүлэх, цахилгаан, дулаан

түгээх компаниудыг хувьчлах асуудлыг шат дараатай авч хэрэгжүүлмээр байна.

Ковидын дараа Япон, Солонгос, Хятад, Австрали улсуудын эдийн засаг нь сэргэхтэй зэрэгцээд хүний нөөцийн дутагдалд орсон. Манай эрчим хүчний салбараас хамгийн түрүүнд чадвартай инженерүүд нь Оюу Толгойд ажилд орсон. Зарим нь Солонгос, Австрали, Япон руу явсан. Ингэснээр эрчим хүчний салбар хүний нөөцийн маш том дутагдалд орлоо. Сүүлийн үед Япон руу бакалавр төгссөн хүүхдүүд магистрт сураад хажуугаар нь үйлдвэрт ажиллаж байна. Яагаад гэхээр Япон ажиллах хүчгүй. Манай багш ажилчид ажлаасаа гарч байна. Австрали рүү түгээх компанийн монтёрууд их явж байна.

Манай салбар энэ хэвэндээ байвал удахгүй сөнөнө



Д.ТУЛГА:
ДЦС4-ийн инженер

Манай салбар боловсон хүчингүй буюу залгамжлах залуу халаа, сэлбэг материал улам л хомс болж байна. Зэрэгцээд эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж, түүнийг хангаж чадахгүй хэмжээнд хүрлээ. Одоо аваарын харанга дэлдээд эхэлж байна. Бухимдах л юм. Хэлэхээр улс төрөөс хамааралтай болчихдог. Үнээ нэмье гэхээр ард түмнээ бодож байна гэдэг. Эрчим хүчний салбараар улс төр хийхээ л больчихмоор байна. Бид 40 жил ажиллачихлаа. Дараагийн 40 жил нь яах юм. Энэ хэвэндээ байвал манай салбар удахгүй сөнөнө. Юм гэдэг хязгаартай. Хязгаар руугаа тун ойрхон очсон шүү. Бид ажил үүргээ сайн биелүүлэхийн төлөө зүтгэдэг. Тоноглолоо засна, ажиллуулна. Биднээс үл шалтгаалсан байдлаар ажил доголдоод байхаар хэцүү. Болохгүй болохоор бид гарах арга замуудаа хайгаад байна шүү дээ. Танай сэтгүүл бидэнтэй дуу хоолойгоо нэгтгэх гээд “Эрчим хүчний салбараа аваръя” контент хийж байгаа нь сайн. Сайн учраас

бид та бүхний хийсэн зүйлийг дэмжиж байгаа. Эрчим хүчнийхний дунд буй эмзэг асуудлыг та бүхэн “Эрчим хүчний салбараа аваръя” гэж оновчтой үгээр илэрхийлсэн.

Станцын тоноглолууд хуучирсан. Үүнийг дагаад гэмтэл гарч байгаа учраас хязгаарлалт хийхэд хүрдэг. 2000 оны эхээр зуухан цехэд ажиллаж байхад зундаа дөрвөн зуух, гурван машины горимоор явдаг байсан. Одоо бид таван зуух, дөрвөн машины (турбингенератор) горимоос буухгүй байна. Хэрэглээ өссөн гэсэн үг. Гэтэл энэхүү эрчим хүчнийхээ хэрэглээг бүрэн хангаж чадахгүй болсон нь өөрөө том аюул шүү дээ. Аюулын харанга дэлдэхээс өөр яах билээ. Тогтсон хэв маяг, авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээ одоо цагт зөв биш гэдэг нь нотлогдоод байна.

Нэг зуух зогсоход, 100 мянган айлын гэрэл шууд унтарна. Ийм үед бид 50-70 градустай болсон халуун зуух руугаа ороод л гэмтлээ засна шүү дээ.



Т.Доржханд: Эрчим хүчний салбар хувийн хэвшлийнхэнд хаалгаа нээх ёстой

УИХ-ын гишүүн,
Монгол Улсын Шадар
сайд, Эрчим хүчний
үндэсний хорооны дарга
Т.Доржхандтай эрчим
хүчний салбарын хөгжил,
реформын чиглэлээр
ярилцлаа.

-Эхлээд Үндэсний хорооныхоо талаар товч танилцуулна уу?

-Эрчим хүчний реформ буюу эрчим хүчний шилжилт хийх зорилготой Эрчим хүчний үндэсний хороог Засгийн газрын түвшинд байгуулсан. Шадар сайдын хувьд Үндэсний хороог ахалж, Эрчим хүчний сайд нарийн бичгийн даргаар, УИХ-д суудалтай, Засгийн газрыг

бүрдүүлж буй намуудын төлөөлөл болсон УИХ-ын зургаан гишүүн ажиллаж байна. Мөн салбарын байгууллагууд, яамд, хувийн хэвшил, олон нийтийн байгууллага гээд олон байгууллагын төлөөлөлтэйгээр Эрчим хүчний үндэсний хороо ажиллаж байна. Яагаад энэ хороог байгуулах болсон юм бэ гэдэг талаар тайлбар хэлье.

Улс орны тулгамдсан асуудлуудыг шийдэх, томоохон бүтээн байгуулалтуудыг хийх, хөдөлгөх зорилгоор хамтарсан Засгийн газрыг байгуулсан. Монгол Улсын түүхэнд анх удаа холимог системээр парламентын сонгууль явж, 126 гишүүнтэй болсон. Үр дүнд нь бие биедээ дэгээ тавьж, хоосон хийрхэж, шүүмжилдэг, улстөрждөг, попордог байдлыг хойноо үлдээе, эсрэгээр, 30 гаруй жил хийж чадаагүй реформууд, бүтээн байгуулалтуудыг хамтдаа хийхээр ажиллаж байна. Энэ нь өөрөө цаашдаа соёл болж, хамтарч нэгдэж, ажилладаг сайн жишиг болох юм.

ХҮН нам энэ үүднээс шийдвэрээ гаргаж, бодлогоо тов тодорхой тодорхойлоод хамтарсан засагт орсон. Үүний нэг шалтгаан нь эрчим хүчний салбарын реформ юм. Намуудын Мөрийн хөтөлбөрүүдээс эрчим хүчний салбарт хамгийн бодитой бөгөөд хэрэгжиж болохуйц хөтөлбөр бол ХҮН намын Мөрийн хөтөлбөр байна гэж үзсэн. Тиймээс Засгийн газрын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаад явья гэсэн байдлаар бодлого тодорхой гарсан. Нэгэнт өөрсдийн дэвшүүлсэн хөтөлбөрөө биелүүлж, хэрэгжүүлэх нь бидний үүрэг юм.

-Эрчим хүчний салбарын реформыг хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

-Реформ богино, дунд, урт хугацаанд хэрэгжинэ. **Богино хугацаандаа бол тус салбарыг зах зээлийн эдийн засгийн харилцаанд оруулахаар төлөвлөж байна.** Төрийн монополиос гаргах, хувийн секторын хөрөнгө оруулалтыг бий болгох зорилт тавьсан. Энэ хүрээнд эхний ээлжинд үнэ тарифыг бодит өртөгт нь авчирья, Засгийн газрын татаасыг больж, өр авлагын асуудлыг шийднэ гэж зорьж байна. Өнөөдрийн байдлаар 1.8 их наядын урт хугацааны өр, дунд хугацаанд 350.0 тэрбум төгрөгийн өр, алдагдал, чөтгөрийн тойрог шиг бие биенээ тойрсон станц, уурхай, төмөр замуудын алдагдлын асуудлыг шийдэж, алдагдалгүй ажилладаг болгоно. Тиймээс үнэ тарифыг хөдөлгөх асуудал зайлшгүй. Цаашдаа үнийг индексжүүлэх байдлаар

зах зээлийнх нь зарчмаар явуулна. Энэ ажлын хажуугаар эрчим хүчийг хэмнэлттэй байлгах, эрчим хүчний ухаалаг систем, мөн дулааны ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлж, цаашдаа эрчим хүчээ хэрхэн хэмнэх юм бэ гэдэг ойлголт мэдээллийг иргэдэд өгөх болно. Үүний хүрээнд 2025 оны улсын төсөвт тодорхой хэмжээний эх үүсвэр тусгах, Төрийн банкны Ногоон хөгжлийн банк болгоё гэдэг саналыг Эрчим хүчний үндэсний хорооноос тавьж төсвийг УИХ-д өргөн бариад байна.

Дунд хугацаанд салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог бий болгох, хөрөнгө оруулалт татах ажлууд хийнэ. Эрчим хүчний салбарын компаниуд бүгд төрийн өмчийн эзэмшилтэй. Эхний ээлжинд компаниудын удирдлагад хувийн хэвшлийн менежментийн багийг оруулж ажиллуулна. Компаниудыг нээлттэй, зөв засаглалтай болгоно. Эрчим хүч үйлдвэрлэж буй компаниудад бүтцийн өөрчлөлт хийнэ. Ингэснээр салбарын үр ашиггүй байдал, дугагдалтай хүнийн нөөц, албан тушаалын асуудлууд шийдэгдэх бүрэн боломжтой гэж харж байгаа.

Урт хугацааны алсын харааг бол маш том амбицтайгаар харж байна. Монгол эрчим хүчний үндэстэн улс. Дэлхийн 200 гаруй улсаас газрын дорх эрчим хүчний нөөцөөр Монгол Улс эхний 5-д эрэмбэлэгдэж байна. Би өөрөө ОУВС-д ажиллаж байсан. ОУВС, Дэлхийн банкны судалгаагаар ингэж гардаг. Бид газар дээрх эрчим хүчний нөөцөөр дэлхийд эхний 2-т ордог. Монгол том газар нутагтай, өндөрлөг газарт байрладаг. Тиймээс салхи маш хүчтэй байдаг бол нар нь хурц. Салхи, нарны нөөц их. Өнөөдрийн байдлаар 14000Гвт нөөц байна гэсэн судалгаа бий.

Эрчим хүч бусад бүх салбарынхаа түрүүнд явах ёстой байтал хязгаарлагч хүчин зүйл болчихсон хамгийн ард нь явна. Харамсалтай. Эрчим хүч байхгүй бол эдийн засгийн өсөлт байхгүй. Томоохон бүтээн байгуулалтууд явахгүй. Эрчим хүчний бие даасан байдал хамгийн чухал. Дараа нь эрчим хүчийг экспортлох асуудал.

Монгол Улс уул уурхайн орон гээд

Эрчим хүчний үндэсний хорооноос таван зорилгын хүрээнд реформ хийнэ.

Нэгдүгээрт, эрчим хүчний аюулгүй, найдвартай системийг бүрдүүлнэ.

Хоёрдугаарт, хөрөнгө оруулалт татахуйц тарифын шинэчлэл хийнэ.

Гуравдугаарт, төрийн өмчит компанийн засаглалыг өөрчлөх.

Дөрөвдүгээрт, өрсөлдөх чадвартай ногоон эрчим хүч рүү шилжилт хийх.

Тавдугаарт, эрчим хүчний зах зээлийг либеральчлах. Эдгээр таван чиглэл рүү зорьж ажиллана.



Аль болох нээлттэй, өрсөлдөөнийг дэмжсэн зохицуулалтуудыг хууль, засгийн түвшинд авч хэрэгжүүлнэ

нийт эдийн засгийн экспортын 90 хувийг уул уурхай эзэлдэг. Эрчим хүчний салбарт богино, дунд хугацаанд хөрөнгө оруулалт татаж реформ хийснээр урт хугацаандаа экспортын хувьд уул уурхайн салбартай өрсөлдөхүйц байх боломжтой салбар. Дэлхий дахинаараа ногоон эрчим хүчинд хөрөнгө оруулахад бэлэн байна. Энэ бол манай давуу тал. Ногоон эрчим хүчийг урт хугацаандаа экспортлох, цаашдаа Хятад, Зүүн Хойд Ази, Солонгос, Японы зах зээл рүү нийлүүлэх боломж байна. Эрчим хүчний реформ гэдэг нь энэ бүгдийг зангидаад цогцоор нь хийнэ гэж ойлгох хэрэгтэй.

Эрчим хүчний үндэсний хорооноос таван зорилгын хүрээнд реформ хийнэ. Үүнд. **Нэгдүгээрт**, эрчим хүчний аюулгүй, найдвартай системийг бүрдүүлнэ. **Хоёрдугаарт**, хөрөнгө оруулалт татахуйц тарифын шинэчлэл хийнэ. **Гуравдугаарт**, төрийн өмчит компанийн засаглалыг өөрчлөх. **Дөрөвдүгээрт**, өрсөлдөх чадвартай ногоон эрчим хүч рүү шилжилт хийх. **Тавдугаарт**, эрчим хүчний зах зээлийг либериальчлах. Эдгээр таван чиглэл рүү зорьж ажиллана. Үр дүнд нь Монгол Улс эрчим хүчээр өөрийгөө бүрэн хангах хэмжээний бие даасан эрчим хүчний эх үүсвэртэй, нөгөө талдаа экспортолж орлого олдог өрсөлдөхүйц эрчим хүчний салбарыг бий болгоно. Ийм үр дүнг хүлээж байна.

-Салбарт реформ хийж, либериальчлах тухай ярьж байна. Эхнээсээ эдгээр үгийг ойлгох ойлголт нэг, зөв байх ёстой болов уу? Эрчим хүчний салбарын реформ, либериальчлах гэдэг үгийг хэрхэн ойлговол зохих вэ?

-Тус салбарын реформыг ямар зорилттой хийх тухайд дээр ярилаа. Харин ямар байдлаар ажиллах вэ гэвэл хууль эрх зүйн орчныг өөрчилж, бодлогыг тодорхой болгоно. Гадна болон дотоодын хөрөнгө оруулагчид орж ирж, хөрөнгөө хийхэд маш ойлгомжтой, тов тодорхой, тогтвортой эрх зүйн орчныг бий болгоно. Төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулна. Түгээхээс бусад хэсэгт аль болох хувийн хэвшлийн оролцоог нэмж олон нийтийн компани болгоно. Бүтцийн хувьд оновчтой зохион байгуулалт хийнэ. Өөрөөр хэлбэл, хэн нь түгээж, хэн нь худалдаж авах, хэн нь борлуулах, ямар зах зээлийн системээр ажиллах бүтцийг тодорхой болгоно. Хувийн

хэвшил орж ажиллах боломжийг хангана. Ногоон эрчим хүч, СЭХ-ний хувьд Засгийн газар оролцохгүй. Зөвхөн хувийн хэвшил оролцоно гэдэг бодлогоо тодорхойлоод явна. Засаг ямар хэсэгт орж болох вэ гэхээр санхүүгийн хувьд олон улсын байгууллага, банкуудтай холбож өгөх, дотооддоо ногоон банк гэж үүсгээд илүү хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр урт хугацаатай зээлийн эх үүсвэрийг шийдэхэд дэмжлэг үзүүлэх байдлаар оролцоно. Аль болох нээлттэй, өрсөлдөөнийг дэмжсэн зохицуулалтуудыг хууль, засгийн түвшинд авч хэрэгжүүлнэ. Цаашид нүүрснээс цахилгаан гаргах, ялангуяа нүүрс шатааж тог гаргахад хөрөнгө оруулалт байхгүй болсон. Хөрөнгө оруулалт хаана байна гэхээр ногоон эрчим хүч дээр байна. Тэгэхээр ногоон эрчим хүчний хувь хэмжээг хамгийн өндөрт байлгахыг зорино. Бид одоо 2030, 2040 онд ногоон эрчим хүчийг ямар түвшинд байлгах талаар тоон дээр ажиллаж байна. Эрчим хүчний реформ гэдэг энэ ажлуудын хүрээнд багтаж байгаа. Реформ мэдээж үнэ тарифын шинэчлэлээс эхэлнэ. Эхлээд эрчим хүчний үнийг зардлаа нөхсөн түвшинд аваачина. Цаашаа үнийг индексжүүлээд явна. Орлого бага айл өрхөд дарамт бага байлгах болно. Харин эрчим хүчний хэрэглээ өндөр хэсэгт зах зээлийнх нь зарчмаар тооцож тарифын өөрчлөлт хийнэ.

Тэгэхээр базаад хэлбэл, эрчим хүчний шилжилт бол дутагдлаас экспорт руу, хүрнээс ногоон руу, төрөөс хувийн хэвшил уруу шилжих явцыг хэлнэ. Технологийн дэвшилтэт шилжилтүүдийг хийнэ. Засаглалын хувьд үр ашигтай ажилладаг шилжилт хийгдэнэ. Хөрөнгө оруулагч, зохицуулагч, хэрэгжүүлэгч байгууллагууд өөрчлөгдөж хувийн хэвшил түлхүү орж өгөх нь.

-Үндэсний хорооны гишүүд та бүхэн өнгөрсөн хугацаанд эрчим хүчний салбартай танилцах, үйлдвэр компаниудаар очиж уулзалт хийх гээд нэлээд явсан. Ингэж явахад танд ямар сэтгэгдэл төрсөн бол?

-Маш их харамссан сэтгэгдэл төрж байлаа. Технологиуд хуучирсан, станцуудын насжилт өндөр. Сүүлийн 40 жилд эрчим хүчний нэг ч эх үүсвэр бариагүй. Өвөлдөө л хөлдчихгүй юмсан гэсэн амь аргацаасан байдлаар олон жил явж иржээ. Тиймээс тогтолцоогоороо нурчихсан, хөрөнгө оруулалт байхгүй, зөвхөн улсын төсвөөс

хийх боломжтой, шинээр тоглогч орж ирэх ямар ч орон зай байхгүй, хэтэрхий хямд үнэ тарифтай, эрчим хүчний нийлүүлэлт байхгүй, алдагдалтай, ийм л салбар байна. Нөгөө л амь аргацаасан өргөтгөлийн ажил л хийдэг. бусад салбараа татаад унагаачихсан, өрийн сүлжээнд оруулчихсан, боловсон хүчин нь олон зуугаараа гараад эхэлчихсэн байна. Алдагдалтай үнэ мөрддөг учраас ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх боломжгүй. Гар аргаар ажилладаг нэг станцад 1000 гаруй хүн ажиллаж байх жишээтэй. 21-р зуун шүү дээ. Орчин үеийн цахилгаан станцууд гар аргаар бус технологийн дэвшлээр ажилладаг болчихсон.

Тухайлбал, хувийн хөрөнгө оруулалтаар хийж буй Бөөрөлжүүтийн 300 МВт станцын 150 МВт-ын галлагааг саяхан нээлээ. Тэнд 7 инженер, нийт 40 хүн ажиллахад л хангалттай гэж байна. Технологийн хувьд суперкритикэл гэдэг түвшинд очсон байна. Гэтэл манай эрчим хүчний салбарын технологи 1980,90 оны түвшинд байна. Технологийн өөрчлөлт хийгээгүй, гар механик аргаар явдаг, өрийн сүлжээнд орчихсон, бусад салбарын өсөлтийг хязгаарлачихсан салбар болжээ.

Өнгөрсөн хугацаанд халамжийн байдалтай л ажиллаж ирж. Уг нь бол эсрэгээрээ эрчим хүч үйлдвэрлээд, экспортлоод, орлого олдог бусад зах зээлтэй өрсөлдөөд явах ёстой салбар. Уг нь манай эрчим хүчний салбар маш их баялаг, нөөцтэй. Өгөгдөлтэй ч салбарын төрийн өмчит компаниуд, удирдлагын баг, хүмүүсийн сэтгэлгээ, хандлага, ажлын арга барил хоцрогдож. Тиимээс шинэчлэлийн хүрээнд бүтцийн өөрчлөлтийг маш зоригтойгоор тултал хийнэ. Шинэ хөндлөнгийн менежментийн багийг ажиллуулна гэдэг дээр хатуу байр суурьтай байгаа.

-Тус салбарын хамгийн ард хоцорчихсон шалтгааныг юу гэж та хэлэх үү?

-Маш тодорхой хоёр шалтгаантай. Нэгд, төр энэ 30 жилийн хугацаанд либеральчлал хийнэ гээд хийгээгүй. Ард иргэдэд таалагдах үүднээс хандсан бодлого явуулсан. Төр үнийг хатуу барьж ирсэн. Эрчим хүчийг үйлдвэрлэсэн өртгөөр нь зардаггүй, байнгын татаастай явж ирсний үр дүнд татвар төлөгч дээр их хэмжээний ачаалал ирж байна. Хоёрт, салбарын боловсон хүчин шинэчлэгдэх ёстой. Хуучнаар ЗХУ-ын хоцрогдсон техник технологи дээр ажилладаг хүмүүс байна. Үүнийг өөрчлөхөөс нааш үр дүн гарахгүй.

Салбарыг зах зээлийн харилцаанд оруулна.

Хувийн хэвшлийнхэнд хаалгаа нээх ёстой. Үүний тулд хувийн хэвшлийнхний төсөл нь ашигтай явах эдийн засгийн орчныг бүрдүүлнэ. Салбарын мэргэжилтнүүдийг бодлогоор бэлдэх шаардлагатай. Үүнийг хувийн хэвшлийнхэнтэй хамтарч хийнэ гэсэн хүлээлттэй байна.

- ХҮН нам засагт ороод эрчим хүчний реформыг эхлүүлж, үр дүнг үзнэ гэж байна. Нөгөө талд танай намыг хамтарсан засагт орохгүй сөрөг хүчний үүрэг гүйцэтгэх нь зөв байсан гэж үзэх хүмүүс бий.

-ХҮН нам яагаад хамтарсан Засгийн газарт орсон юм бэ гэдэг асуулт их гарч байгаа. Ганцхан шалтгаантай. Монгол Улсад хоёр намын тогтолцоо цаашид явахгүй. Дэлхий дээр хоёр намын тогтолцоо яваад үр дүнд хүрсэн нэг ч кэйс алга. Хамгийн сүүлийн дампуурсан Шри Ланка улс байна. Сүүлийн 30-40 жилд хоёр намын тогтолцоогоор явж, том төслүүд хэрэгжүүлэхээс илүү нийгмийн зардлаар өрсөлдөж, популизм хийсээр байгаад эдийн засгаа татаад унагаачихсан. Грек улсын жишээг аваад үзье. Хоёр нам нь бас л сүүлийн 30 жилд популист амлалт өгч өрсөлдсөөр байгаад эдийн засгаа унагаасан.

Дараагийн тод жишээ бол Монгол Улс. Зөв хэрэгтэй төслүүдээ явуулдаггүй, бие биедээ дэгээ тавьдаг, популист амлалт өгдөг байдал сүүлийн 30 жил явж ирлээ. Үр дүнд нь эрчим хүчний салбар зогсох дээрээ тулсан, өргөн, нарийн гэж хэрэлдсээр төмөр зам баригдахгүй 15 жил болсон. Арай гэж бариад хартал уулзах цэг зөрчихсөн, холбоос байхгүй гэх мэт манай зовлон их бий. Улс төр тогтворгүй, бодлого богино хугацаанд хэрэгжих нөхцөлд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэхгүй. Хөрөнгө оруулалт байхгүй бол эдийн засаг өсөхгүй. Эдийн засаг өсөхгүй бол таны, миний цалин нэмэгдэхгүй. Ингээд залуус нь гадагшаа явж, ахмадууд нь бухимдалтай үлдэж байгаа юм. Тэгээд яах вэ? Тогоон дотроо хэрэлдэж муудалцаж бие биенээ шүүмжлээд дуусах уу. Эсвэл тогоогоо нээгээд бүгдээрээ хамтраад том бүтээн байгуулалтууд руу орох уу. Хэрүүлээ хойш нь тавья. Реформуудаа зоригтой хийе. Энэ сонголт дээр ХҮН нам ирсэн. Эдийн засгаа өсгөхийн тулд эрчим хүчний реформыг зоригтой хийе. **Эрчим хүчний салбарыг шинэчлэхгүй бол улс хөгжихгүй юм байна гэж үзсэн. Засгийн газарт хамтарсны нэг гол шалтгаан энэ юм. Энэ ажлаа нэр төртэй хийнэ.**

Улс төрийн намууд сөрөг хүчин хийх



Эрчим хүчний салбарыг шинэчлэхгүй бол улс хөгжихгүй юм байна гэж үзсэн. Засгийн газарт хамтарсны нэг гол шалтгаан энэ юм



Эрчим хүчний шилжилт бол дутагдлаас экспорт руу, хүрнээс ногоон руу, төрөөс хувийн хэвшил уруу шилжих явцыг хэлнэ

гэж сонгуульд оролцдоггүй. Засгийн эрх авахын төлөө зорьдог. Засагт ороод бодлогоо хэрэгжүүлээд иргэдээр дүнгээ тавиулдаг. Нэг нам үнэмлэхүй ялж, нөгөө нам нь сөрөг хүчин хийдэг байсан бол одоо нэг нам үнэмлэхүй ялдаг байдал байхгүй болсон. Одоо бол нэгдэж нийлээд ажилладаг тогтолцоо уруу орсон. Үүний тулд ч Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийсэн. Тиймээс хүчээр бус өөрсдийн хүсэлтээр хамтарсан засаг байгуулагдсан. Одоо эдийн засгийн том реформуудыг хийх ёстой. Үүнд нэгдэж нийлж, хамтарч ажиллахаас өөр арга байхгүй юм аа. Цаашид ч хамтарсан Засгийн газар байгуулагдах болно. Хамтарсан засгийн давуу тал юу гэхээр бодлогын залгамж халаа алдагдахгүй. Нэг нам нь айхавтар савж ялахгүй, бас ялагдахгүй. Тогтвортой байдал бий болно. Энэ дөрвөн жилийн эрчим хүчний бодлого дараагийн дөрвөн жилд хэвээр хадгалагдана. Тэгэхээр Монгол Улсад тэрбум ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх гэж буй хөрөнгө оруулагч 10 жилийн хугацаанд хөрөнгө оруулалт хийгээд үр өгөөжөө авч чадах уу гэдэг тогтвортой бодлогыг л харна. Ийм орчинтой болж чадвал Монгол Улс хөгжинө. Өнөөдөр улс төрийн намуудын хөгжил, хандлага маш их өөрчлөгдөж байна.

-Украин Оросын дайн манай эрчим хүчний салбарт нөлөөлж байна. Манайх ОХУ, мөн Украинаас үйлдвэрүүдийн сэлбэг хэрэгслийг авдаг ч одоо авч чадахгүй болсон тухай салбарынхан ярьдаг.

-Дайн хойд бүс нутагт эдийн засгийн харилцаанд орох ямар ч боломжгүй нөхцөлийг үүсгэсэн. Монгол Улс эрчим хүч, нефтиэр ОХУ-ын хараат байдалд байна. Гэтэл нэг өдөр хойд хөршийн крант хаагдвал яах билээ. Нэг өдөр хойд хөрш өөрөө эрчим хүчний дутагдалд орвол яах билээ. Монгол Улс ийм л хараат байдалд байна. Яагаад энэ реформыг хийх ёстой вэ гэхээр манай станц, үйлдвэр компаниудын тоног төхөөрөмж ихэнхдээ ОХУ-ын тоног төхөөрөмжүүд. Үүнийг шинэчлэхгүй л бол цааш явахгүй. Зайлшгүй шинэчлэх ёстой. Технологи дэлхийд маш хурдтай өөрчлөгдөж байна. Нар, салхины төхөөрөмжүүд гайхалтай хурдан өөрчлөгдөж байна. Үнэ нь ч хямдарч байна. Технологийн хувьд дараагийн түвшинд гарах ёстой. Үүнийг реформын

хүрээнд хийх болно.

-Бодлого тодорхойлогчдын зүгээс эрчим хүчний реформд хандах хандлага, дэмжлэг хир байна вэ? Учир нь эрчим хүчний бодлогод томоохон шинэчлэл хийнэ гэж байгаа шүү дээ.

-УИХ дээр Эрчим хүчний хууль эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн тус салбарын төлөөллөөр сонгогдсон Энхцэцэг гишүүн ахалж байгаа. УИХ-ын нийт гишүүдийн дэмжлэг өндөр байгаа. УИХ-ын гишүүн С.Цэнгүүн УИХ дахь Эрчим хүчний шилжилтийг дэмжих лобби бүлгийг санаачлан ахлаад явж байна. Өнөөдөр 126 гишүүнээс 100-гаад нь дэмжихээ илэрхийлж гарын үсэг зурсан. Энэ бол маш том дэмжлэг юм. Үүнийг бид ард иргэддээ зөв ойлгуулах ёстой. Реформ хийх эхний явцад бид богино хугацаанд өвдөлт авах байх. Харин урт хугацаандаа Монгол Улс илүү хожсон, цахилгааны хязгаарлалтгүй, эрчим хүчээ экспортолж, орлого олж түүгээрээ эрүүл мэнд, боловсролдоо хөрөнгө оруулалт хийдэг орчин бүрдэнэ гэдэгт итгэж байна.

-Эрчим хүчний салбарынхан реформыг хэрхэн хүлээн авах ёстой вэ?

-Би эрчим хүчний салбарынханд хоёр зүйлийг л хэлээд байгаа. **Нэгдүгээрт**, өнөөдрийн буй нөхцөл байдлаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Алдагдалтай, өртэй, уналттай, бусад бүх салбарын ард яваа гэдгээ. **Хоёрт**, бүгдээрээ зөвхөн манай салбарын асуудал гэж битгий хараарай. Бүх л салбарын асуудал эрчим хүчээс хамаарч байна. Эрчим хүчний салбарт реформ хийснээр зөвхөн салбарынхан бус Монгол Улс нийтээрээ л хожих юм шүү дээ. Тиймээс маш том хариуцлага ирж байна гэдгээ ойлгох ёстой. Харин ч эрчим хүчний салбарынханд энэ нь маш том боломж юм. Ингэж хүлээж авах хэрэгтэй. Ажлаа, ажлынхаа нөхцөл байдлыг, онцлогыг ард иргэдэд зөвөөр ойлгуулах, мэдээлэх, ярих үүргээ сайн хийх хэрэгтэй байна гэж хэлье. Салбарын олон мянган ажилтан маш хүнд нөхцөлд бага цалингаар чимээгүй ажиллаж, асуудлыг аргалж, эвдэрсэн технологийг гар аргаар засч сэлбэж иржээ. Гэтэл салбар нь энэ 30 жилд халамжийн байдалтай, уналттай салбар болоод хувирсан байна.

-Үнэ тариф хөдөлгөх асуудал яриад эхэлсэн байна. Энэ нь реформын эхний хэсэг гэж ойлгож болох уу?

-Эрчим хүчний салбарт том реформ хийж, эрчим хүчээр хараат бус улс болж, цаашид эрчим хүчээ экспортлоод орлого олдог байж гэвэл хамгийн түрүүнд гадаад дотоодын хөрөнгө оруулалтуудыг оруулж ирэх ёстой. Шинэ эх үүсвэр, станцуудыг барих ёстой. Шинэ станц барих эхний нөхцөл нь үнэ нь зах зээлийн зарчмаараа явж байгааг харна. Тэд хөрөнгө оруулалт хийж, айхавтар том ашиг орлого олохгүй юмаа гэхэд алдагдалгүй үнэ мөрдөх ёстой гэдэг зарчим хэлнэ. Тиймээс үнэ тарифын өөрчлөлт гарцаагүй. Эхний ээлжинд өглөг авлагаа дарж, бодит зардлаа нөхдөг үнэ тарифт шилжүүлэх хэрэгтэй байна. Бага орлоготой 10-15 хувийн түвшний хэсэгт дарамт үүрүүлэхгүй. Бусад хэсэгт үнийн тарифын өсөлтийг жигд хуваарилах үнийн тооцоог Эрчим хүчний зохицуулах хорооноос хийгээд явж байгаа.

-За тэгвэл ард иргэд хэрхэн хүлээн авах ёстой вэ? Иргэдийн хувьд цахилгаан, дулааны үнэ нэмэгдэнэ гэдэг бол маш том асуудал шүү дээ.

-Судалгаагаар, гэр хороололд буй нэг өрх найман сарын хугацаанд нүүрсээ худалдан авч, галаа түлж амьдрах зардал дунджаар 2.0 сая төгрөг байна. Түүнтэй дүйцэхүйц 50 ам метр талбайтай орон сууцанд амьдардаг өрхийн зардал найман сарын хугацаанд дунджаар 400,0 мянган төгрөг байна. Зөвхөн дулаан нь. Харьцуулахаар гэр хороололд буй иргэд орон сууцныхнаас дариу 4-5 дахин илүү зардал гаргаж байна. Орон сууцны айлууд өвөл халууцаад цонхоо онгойлгосон харагддаг шүү дээ. Цахилгаан, дулаан хямдхан байгаагийн шинж юм. Хөгжилтэй орнуудад эрчим хүч, дулаан бол жинхэнээсээ маш том тансаглал, үнэтэй ч бүтээгдэхүүн байдаг. Өнөөдөр бидний цахилгаан, дулаанд өгч буй мөнгө гар утсаа цэнэглэж буй мөнгөнөөс бага байгаа шүү дээ.

Би Японд оюутан байсан. Өглөө эрт босоод хамгийн эхний галт тэргээр явж сургууль дээрээ очно. Сургуулийнхаа номын санд сууж хичээлээ хийнэ. Цахилгаанаа хэмнэж байгаа юм. Хамгийн сүүлийн галт тэргээр гэртээ ирээд шууд л унтдаг байлаа. Англид амьдардаг иргэд бас ойлгож байгаа байх, цахилгаан дулаан үнэтэй, мөнгөө урьдчилж хийгээд халаалт



авдаг шүү дээ. Европын орнууд гэртээ 18 хэм дээр амьдардаг. Цахилгаан өөрөө өндөр өртөгтэй болохоор эрчим хүч хэмнэхэд суралцсан байдаг. Дэлхийн хөгжилтэй баян орнууд цахилгаан, дулаанаа хэмнэж, хязгаарлалттайгаар хэрэглэж байна. Гэтэл хөгжиж буй манай улсад зарим хэрэглэгч өвөлдөө цонхоо онгойлгоод халууцаад сууж байна.

Эцэст нь хэлэхэд, монголчууддаа эх оронч байгаасай гэж хүсмээр байна. Эрчим хүчний бие даасан байдал үнэхээр чухал. Тог тасраа л бол аврал байхгүй. Хотоороо, улсаараа хөлдөнө. Эх оронч байна гэдэг нь бие даасан эрчим хүчний системтэй болох л асуудал. Өмнөд Солонгосын эдийн засгийн хямралаар эмэгтэйчүүд нь алт мөнгөн ээмэг, бөгжөө улсдаа очерлоод өгч байсныг дэлхий мартаагүй. Өнөө ч бахархдаг. Энэ бол эх оронч сэтгэлгээ юм.

Үүнтэй адилхан бид эрчим хүчний маш хүнд байдалд орчихсон, хотоороо хөлдөх, улсаараа зогсоход бэлэн байгаа энэ үед хамтдаа энэ бүхнийг даван туулж гарах ёстой. Тиймээс эрчим хүчний реформыг дэмжих нь маш чухал. Эрчим хүчний хязгаарлалтуудыг ойлгож, болж өгвөл гэрээ, байшингаа сайн дулаалах хэрэгтэй. Эрчим хүчээ хэмнэх чиглэл рүү анхаараад явбал хүндрэл бага гарч, реформ ч амжилттай явж, салбар зах зээлийн зарчмаараа хөгжиж эхлэх болно гэдгийг хэлмээр байна.



Нар, салхины төхөөрөмжүүд гайхалтай хурдан өөрчлөгдөж байна. Үнэ нь ч хямдарч байна. Технологийн хувьд дараагийн түвшинд гарах ёстой. Үүнийг реформын хүрээнд хийх болно



М.Энхцэцэг: Эрчим хүчний салбарт шинэтгэл хийх цаг болсныг бүх түвшинд хүлээн зөвшөөрч, дэмжиж байна



“Улсын төсвөөсөө эрчим хүчний салбарт зарцуулаач ээ” гэж хэлмээр байна

УИХ-ын гишүүн, Эрчим хүчний үндэсний хорооны дэд дарга М.Энхцэцэгтэй эрчим хүчний асуудлын талаар ярилцлаа. Тэрбээр УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа юм.

-Та эрчим хүчний салбараас УИХ-ын гишүүн болсон. Эрчим хүчний салбар эх үүсвэрийн дутагдлаас ер нь яаж гарах вэ?

-Эрчим хүчний салбар маш хүнд байдалд байна. Олон жил нийгмийн хариуцлагыг нуруундаа үүрч, үнэ тарифаа өртгөө нөхөхгүй түвшинд барьж ирснээс болоод өрөндөө баригдсан, тоног төхөөрөмжөө шинэчилж чадахгүй, эх үүсвэрийн дутагдалд орсон,

олон жил бэлтгэсэн инженер, техникийн ажилчдаа алдсан, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болсон салбар болчихоод байна.

Маш олон хэрэглэгч үйлдвэр, орон сууц барья гэсэн боловч цахилгаан, дулаанаар хангагдаж чадахгүй, техникийн нөхцөл авч чадахгүй, хүлээлтийн байдалд байна. Хамтарсан засгийн газар олон том бүтээн байгуулалтын ажлуудыг хийхээр төлөвлөсөн боловч энэ бүх төсөл цахилгаан, дулаанаар хангагдаж чадахгүй хэмжээнд хүрэхээр байна.

Цахилгааны хэрэглээ жилд дунджаар 200 МВт-аар өсөж байна. Гэтэл энэ бодит өсөлт биш юм. Учир нь маш олон хэрэглэгчийг эх үүсвэрийн дутагдлаас цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнүүд нь хэт ачаалагдсан байдлаас болоод холбож чадахгүй, техникийн нөхцөл өгөхгүй байгаа. Хэрэв эдгээр хэрэглэгчийг холбох, мөн хийхээр төлөвлөөд байгаа бүтээн байгуулалтын ажлууд өрнөөд эхэлбэл цахилгааны хэрэглээ жилд дунджаар 300-400 МВт-аар өснө.

Хэдийгээр бид Бөөрөлжүүтийн 600 МВт, Төв аймгийн Баян суманд 660 МВт-ыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа хэдий ч энэ нь хангалтгүй юм. Цахилгаан, дулааны хэрэглээний энэ огцом том өсөлтийн хурдыг гүйцэхэд маш хүнд байна.

Иймд бид эрчим хүчний салбарыг түрүүлэн хөгжүүлэхийн тулд бүх л нөөц боломжоо буюу улсын төсвөө, гадаадын зээл тусламжаа, хувийн хөрөнгө оруулалтаа ашиглах шаардлагатай. Бага чадлын, хөрөнгө оруулалт багатай, тархмал эх үүсвэрүүдийг хурдан хугацаанд улсын төсвөөрөө барьж, алс хол байрладаг аймаг, сумуудын цахилгаан, дулаан хангамжийг найдваржуулах, том чадлын, хөрөнгө оруулалт өндөртэй төслүүдээ гадаадын зээл тусламжаар, хувийн

хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Саяхан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг УИХ баталлаа. Үүн дээр сэтгэл хангалуун бус байсан. Учир нь Эрчим хүчний салбарт нийтдээ 24 төсөл тусгагдаж орж ирсэн. Гэтэл ердөө гурван төсөл л улсын төсвөөр бусад 21 төсөл нь гадаадын зээл тусламжаар хэрэгжихээр тусгагдсан байсан. Бид эрчим хүч рүү түлхүү анхаарсан төсөв, төлөвлөгөө орж ирэх байх гэсэн хүлээлттэй байсан. Гаднын зээл тусламжийг бүтээхэд маш их цаг хугацаа ордог, хувийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ тарифаа тохирох гэж хэлэлцэж суусаар цаг хугацаа их алддаг нь өнгөрсөн туршлагаас тодорхой харагддаг. Жишээ нь Чойр-Сайншандын 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг одоо гадаадын зээл, тусламжаар барих гэж байна. Энэ төслийн зээл тусламжийг бүтээхэд бараг 4 жил зарцуулсан байна. Иймд бид тодорхой хэмжээний улсын төсвийг эрчим хүчний бага оврын тархмал эх үүсвэр, цахилгаан дамжуулах түгээх сүлжээгээ өргөтгөхөд зарцуулах зайлшгүй шаардлагатай гэж харж байна. Улаанбаатар хотын бараг бүх 110 кВ-ын дэд станцууд хэт ачаалагдан, нэмж хэрэглэгч холбох боломжгүй байгаа. Гэтэл Улаанбаатарт барих шаардлагатай 110 кВ-ын дэд станцуудыг хүртэл гадаадын зээл тусламжаар хийнэ гэхээр бид цаг хугацаа алдаж, орон сууцны хорооллуудаас эхлээд том бүтээн байгуулалтуудаа хийхэд хүндрэл бэрхшээл тулгарна гэсэн үг юм.

Эрчим хүчний салбарын хувьд нийгэм, улс төрийн маш таатай уур амьсгал бий болжээ гэж харж байгаа. Үнэ тарифыг өртгөө нөхдөг болгох нэмэх, бүх хөрөнгө оруулалтаа эрчим хүч рүүгээ хийе гэдгийг улс төрчид, олон нийт хүлээн зөвшөөрсөн байна. Гол нь эрчим хүчний салбар энэ таатай энэ үеийг маш сайн ашиглаж, асуудлаа сайн ойлгуулж, бүх л хөрөнгө оруулалтыг татахыг хичээх ёстой. Энэ салбараас УИХ-ын гишүүн болсон хүний хувьд салбараа сайн төлөөлөхийг хичээх ёстой гэж ойлгож байгаа. Ер нь их хэцүү байдаг юм байна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд гурван ажил оруулах гэж багагүй юм болж оруулсан. Нэг ажил нь Архангай, Өвөрхангай, Баянхонгор

гурван аймгийн цахилгаан хангамжийг найдваржуулах асуудал. Энэ гурван аймаг нь хаа байсан Эрдэнэтээс 110 кВ-ын хэт урт, насжилт өндөртэй шугамаар тэжээгддэг. Зундаа “шугам дээрээ засвар хийж байна” гээд цахилгаангүй олон хонодог, өвөлдөө Хархорины шугам дээр тулгуур унахад л гурван аймаг, олон арван сум хөлдөх хэмжээний эрсдэлтэй байдалд байдаг. Тэгэхээр энэ гурван аймаг дээр нарны станцыг батарейтай нь бариад цахилгаан хангамжийг нь найдваржуулж, гурван аймаг, олон сумыг хөлдөхөөс аврах асуудлыг олон гишүүн ойлгож, дэмжиж ажилласанд баярлаж байгаа. Гэх мэтээр 5-6 сарын дотор хэрэгжүүлэх боломжтой, бага хөрөнгө оруулалттай, бага оврын тархмал сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд, ДЦС-уудыг аймаг, сумын төвүүдэд барьж, цахилгаан, дулаан хангамжийг найдваржуулах нь энэ салбарын тулгамдсан асуудлуудын нэг юм. Бөөрөлжүүт, Баянсумын ДЦС-ууд нь алс хол байрладаг эдгээр аймгийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэх боломжгүй юм.

-Эрчим хүчний салбарт реформ хийх шаардлагатай гэдэг дээр бодлого тодорхойлогчид санал нийлж эрчтэй ажилдаа орж байгаа харагдаж байна?

Засгийн газрын дэргэд Шадар сайд Т.Доржхандаар ахлуулсан Эрчим хүчний реформыг хэрэгжүүлэх Үндэсний хороог байгуулсан. Энэ хороо нь эрчим хүчний шилжилтийн бодлогыг тодорхойлох, салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, салбарын асуудлыг олон нийтэд танилцуулах, салбарын байгууллагуудын засаглалыг сайжруулах, мега төслүүдийг хэрэгжүүлэх гэсэн зургаан гол ажил дээр төвлөрч ажиллана. Миний бие энэ хорооны дэд даргаар ажиллахаас гадна салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлыг ахалж байна. Улсын Их Хурлын даргын 2024 оны 80 дугаар захирамжаар Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай гэсэн гурван хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, ажлын хэсэгт Б.Найдалаа, С.Цэнгүүн,



Үнэ тарифыг өртгөө нөхдөг болгох нэмэх, бүх хөрөнгө оруулалтаа эрчим хүч рүүгээ хийе гэдгийг улс төрчид, олон нийт хүлээн зөвшөөрсөн байна



Эрчим хүчний
тухай хууль
2001 онд
батлагдаж,
дэлхийн 150
гаруй улсад
хэрэгжсэн
реформыг
Монгол улсад
хэрэгжүүлсэн

Д.Энхтуяа, Ж.Золжаргал, Б.Жаргалан, Ч.Анар гишүүд ажиллаж байна. Одоогоор эрчим хүчний хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хуулийн эрэлт хэрэгцээнд тандан судалгаа хийх, оролцогч талуудаас санал авах, салбарын дүрэм, журмуудыг судлах ажлуудыг хийж байна.

Эрчим хүчний тухай хууль 2001 онд батлагдсан байдаг. Дэлхийн 150 гаруй улсад хэрэгжсэн реформыг Монгол Улсад хэрэгжүүлсэн. Энэ реформ нь босоо бүтэцтэй байсан эрчим хүчний салбарыг задлаад хэвтээ хэлбэрт оруулж, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч гэсэн олон компани болгож бүтцийг өөрчлөх, үнэ тарифыг тодорхойлох зохицуулах хороог байгуулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар өрсөлдөөнийг бий болгох талаар зохицуулалт гэсэн 4 том зорилготой байсан. Монгол Улсын хувьд реформ-1 буюу эхний хоёрыг амжилттай хэрэгжүүлсэн. Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг бий болгох зорилтуудыг хэрэгжүүлж амжаагүй байна. Тиймээс эрчим хүчний хуулийг шинэчлэн боловсруулж, реформ-2 буюу хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг бий болгохоос гадна ногоон хөгжлийг бий болгох зорилтуудыг хэрэгжүүлэх нь чухал юм. Харин хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэнээр бизнесийн хүнд суртал үгүй болдог, улс төрийн хараат байдлаас гардаг, ашиг, алдагдал, зардлын хяналт ил тод болж, үйлчлүүлэгчдээ дээдэлдэг, үйлчилгээний чанар сайжирдаг, өрсөлдөөн бий болсноор зэх зээл дээр байж болох хамгийн доод үнэ тогтдог болохыг дэлхийн олон улс орон туршиж тогтоон хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Тэгэхээр бид энэ чиглэл рүү л явахыг зорих ёстой.

-Эрчим хүчний хуулийг шинэчлэхэд гол анхаарах зүйл юу вэ?

-Монгол Улсын анхны 126 гишүүнтэй парламент хүн төвтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой гэсэн “Турван төгөлдөршил”-ийн

бодлогыг тусгасан хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх 54 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ерөнхийдөө хууль нь тухайн салбар дахь оролцогч талуудын дунд үүсэж байгаа харилцааны хэм хэмжээг тодорхойлох зорилгыг агуулдаг. Тухайн хууль салбар дахь харилцааг иж бүрнээр нь оновчтой зохицуулж байгаа эсэх, хэрэглэгч буюу оролцогч талуудын эрх ашгийг хангаж байгаа эсэхийг хэмждэг. Хамгийн эхний хэмжүүр нь тэр салбарт гомдсон, хүндрэл бэрхшээлтэй тулгарсан, шүүх цагдаадаа тулсан оролцогч талуудын тоо байдаг. Эрчим хүчний салбарт ийм асуудал олон байгааг хүн бүр мэдэж байгаа. Мөн 2001 онд батлагдсан хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх асуудал чухал. Мөн урьдчилсан байдлаар харахад Эрчим хүчний тухай хууль маань маш ерөнхий. Дулааны салбарыг бараг зохицуулаагүй гэж хэлж болно. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг нарийвчлаад харах юм бол уртаашаа гурван хуудсанд багтдаг. Нэр томьёо, тодорхойлолтууд, тэгээд төрийн байгууллагын эрх, үүрэг, тусгай зөвшөөрөл, үнэ тариф гээд л дуусдаг. Хуулийн зохицуулалтыг ингэж хэт ерөнхий боловсруулж баталснаас болж системийн нарийвчилсан харилцааг хуулиас давсан олон тооны журам, дүрмүүдээр зохицуулахаас аргагүй болж байгаа юм. Журам, дүрмүүдийг дурын нэг дарга ирээд сольж, шинэчлээд байдаг болохоор салбарын эрх зүйн орчин бүхэлдээ тогтворгүй болчихжээ. Гадаад орнуудын хууль тогтоомжуудаас харж байхад эрчим хүчний салбарын бүхий л харилцааг эмх цэгцтэйгээр нэг бүрчлэн хуульчлан зохицуулсан байгаа юм. Хууль бол дүрэм, журмуудыг бодвол тогтвортой, өөрчлөгдөж, солигдох нь харьцангуй бага шүү дээ. Хууль тогтоомжийн хуулийн дагуу аливаа хуулийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэхэд хамгийн түрүүнд хийдэг ажил нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийдэг. Бид энэ ажлыг одоо хийж байгаа ба энэ үнэлгээг хийснээр дүгнэлтүүд нилээд тодорхой болж гарч ирнэ.

С.Цэнгүүн: Эрчим хүчний реформыг дэмжих бүлэгт УИХ-ын 100 гаруй гишүүн гарын үсэг зурсан

УИХ-ын гишүүн, Эрчим хүчний үндэсний хорооны гишүүн С.Цэнгүүнтэй ярилцлаа.

-Эрчим хүчний салбарыг хэрхэн харж бна вэ?

-Эрчим хүчний салбар социализмын үеийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн байдлаараа өнөөг хүртэл явж байгаа. Зах зээлийн системд шилжээгүй сүүлийн салбар болоод үлдчихсэн. Ашигт ажиллагаан дээр суурилахгүйгээр зөвхөн төрөөс л бүх бодлого, төлөвлөгөөг баталж, үнийг тогтоодог, үйл ажиллагаа нь хүртэл төр дангаар хариуцдаг салбар. Тиймээс гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах боломжгүй болон үлдсэн ганц салбар. Үнийг нь өртгөөс нь багаар тогтоохоор систем нь өөрөө дааж явж чадахгүйд хүрчээ. Эрчим хүч тасалдал, доголдолгүй байнгын, найдвартай ажиллах ёстой. Үүний тулд байнгын засвар үйлчилгээ, тордолгоо хийх ёстой атал энэ засвар үйлчилгээгээ хийж чадахгүйд хүрсэн байдалтай байна. Техник технологийн шинэчлэл хийхгүй, ажилтнуудынхаа цалин урамшууллыг нэмж чадахгүй явснаас болж хүний нөөцийн хомсдолд орж, хуучирсан техник технологитой цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байдал үүсчихээд байна.

Бид бодит үнэнтэй нүүр тулах ёстой. Эрчим хүчний салбарыг чөлөөт өрсөлдөөний зарчимд нь оруулах зайлшгүй шаардлагатай. Үүний төлөө эрчим хүчний реформ хийхээр ажиллаж байна.

-Реформ гэдгийг хэрхэн ойлгох вэ?

-Бид үзэл баримтлалын хувьд зайлшгүй шинэчлэл хийх шаардлагатай. Реформ хийнэ гэдэг нь хууль эрх зүйн орчинд маш том шинэчлэл хийнэ. Өөрөөр хэлбэл, зах зээлийн зарчимд нийцүүлнэ гэсэн үг. Энэ салбар төрөөс хамааралгүйгээр бие дааж ажиллах ёстой. Энэ үзэл баримтлал дээр тулгуурлаж бодлого, эрх зүйн орчинд өөрчлөлт хийх юм.



Энгийнээр хэлэхэд, эрчим хүчний салбарт төрийн оролцоог халж зах зээлийн систем рүү л шилжүүлэх тухай ойлголт. Төрийн өмчийн компаниудын менежментийг сайжруулж, алдагдалгүй ажилладаг болгож, олон нийтийн хяналтыг тогтоох асуудал.

Үнэ тарифын хувьд маш зөв, зах зээлийн индексжүүлсэн зарчмаар өрсөлдөөн бий болгох байдлаар бодлогын орчныг шинэчилнэ. Дэлхий дахинд эрчим хүчний салбарын уламжлалт сэтгэхүй өнөөдөр ихээхэн өөрчлөгдөж байна. Ялангуяа ОХУ, Укрианы дайны дараагаас улс орнууд тархмал эх үүсвэрийг хөгжүүлэхэд анхаарч байна. Тархмал эх үүсвэр нь ч давуу тал болж хурдтай хөгжиж байна. Шийдвэрлэх боломж, техникийн нөхцөлүүд гарч ирлээ. Энэ нь жижиг хөрөнгө оруулагчдад боломж болох юм. Айл өрхийн түвшинд ч эрчим хүч үйлдвэрлэх боломжтой технологийн дэвшлүүд гарч ирж байна. Эрчим хүчийг үзэл баримтлалын хувьд өөрөөр харах зайлшгүй шаардлага гэж энэ бүхнийг хэлээд байгаа юм.

Реформыг амжилттай хэрэгжүүлэхийн



Эрчим хүчний реформыг ямар нэг улс төр, попролгүйгээр явуулж өгөөсэй гэж хүсч байна



Бид үзэл баримтлалын хувьд зайлшгүй шинэчлэл хийх шаардлагатай. Реформ хийнэ гэдэг нь хууль эрх зүйн орчинд маш том шинэчлэл хийнэ. Энэ салбар төрөөс хамааралгүйгээр бие дааж ажиллах ёстой

тулд бид эхлээд үнэ тарифыг өртөгт нь хүргэх хэрэгтэй байна. Мэдээж үүнд олон үе шат, дамжлага шаардагдана. Нөгөө талд, эрчим хүчний үйлдвэрүүдийн шинэчлэлийг даруй хийх ёстой. Салбарын үйлдвэр, компаниудыг ашигтай ажиллуулах талд зохицуулалт хийхгүй бол үр дүнд хүрч чадахгүй. Хамтад нь шинэчлээд явах ёстой. Зарим хүн төрийн компаниудын алдагдлыг байхгүй болгочихоод дараа нь үнэ тарифаа ярих ёстой гэж хэлдэг. Монгол Улсад эрчим хүчний мега төслүүд хэрэгжихгүй олон жилийн турш гацсан. Эдгээр мега төслийг хөдөлгөхийн тулд гурван намын хамтарсан Засгийн газар байгуулагдсан. Энэ төслүүдийг хөдөлгөхийн тулд үнэ тарифыг хөндөх шаардлагатай болж байгаа юм. Ингээд харахаар шинэ эх үүсвэрүүд барих, хөрөнгө оруулалт татахын тулд үнэ тарифт шинэчлэл хийх шаардлагатай. Үнэ нэмж, тогтоохдоо бус, үнэ тариф зах зээлийн зарчмаараа явдаг л эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал юм.

Үнэ нэмнэ гэж олон нийтэд буруу ойлголт өгөөд байна. Эхлээд үнийг өртөгт нь нийцүүлэх тухай асуудал юм. Өртгөөсөө хэд дахин бага үнээр явсаар ирсэн салбар учраас өнөөдөр ийм алдагдалд орчихсон байна. Өмнөх засгуудын явуулсан алдаатай бодлогын үр дүн. Тиймээс 20,30 хувиар үнийг өсгөх хэрэгтэй болж байна. Одоо бид эрчим хүчний салбарын асуудлыг ойлгож, бодит байдлыг хүлээн зөвшөөрч, үнийг өртөгт нь хүргэж, мөн шинэчлэл хийхгүй бол энэ салбар удахгүй зогсоно гэдэг нь тодорхой байна. Эрчим хүчний доголдол хөгжлийн доголдол юм.

-Дэд хорооны гишүүд өнгөрсөн хугацаанд салбарын үйл ажиллагаатай танилцаж, салбарынхантай уулзаж, асуудлыг сонсож явсан. Ингэж явахад танд ямар сэтгэгдэл төрж байв?

-Нэг зүйлд бахархмаар, нөгөө талдаа гунигтай санагдсан. Эрчим хүчний салбарынхан ихэнхдээ инженер,техник мэргэжлийн хүмүүс байдаг. Энэ хүмүүс өнөөг хүртэл салбараа аврахын төлөө, үйл ажиллагааг тасалдуулахгүйн төлөө явж иржээ. Өдөр шөнөгүй ажиллаж, өөрсдийн бие, сэтгэлээр эрсдлээ хүлээгээд хар аргаар ч хамаагүй технологио засч сэлбээд засварлаж иржээ. Хүн ажиллах боломжгүй нөхцөлд ч асуудал ярилгүй ажиллаж, биднийг гэрэл цахилгаантай байлгахын төлөө явсан байна. Энэ бол бахархал. Нөгөө талдаа салбарын

ажилтнууд улаан дохиог эрт хэлж, сануулж, анхааруулж, дуугарч явахгүй яав даа гэж бодож харамсч сонссон. Гэхдээ тэд хэлж ярьж байсан ч түүнийг нь хүлээн аваагүй байх.

Дараагийн хамгийн том асуудал бол эрчим хүчний салбарт хүний нөөцийн хомсдол. Салбартаа чин сэтгэлээсээ ажилласан туршлагатай ажилтнууд нь өнөөдөр ихэнхдээ тэтгэвэрт гарчээ. Залуу үеэ бэлдэе гэхээр ажиллах сонирхолтой залуус алга байна. Энэ нь цалин хангамжтай холбоотой.

Бидний өнөөгийн амьдрал дулаан, цахилгаантай зайлшгүй холбогдчихсон шүү дээ. Тог тасраад хоёр цаг болоход бидний амьдрал хэцүүднэ. Хотоороо, улсаараа цахилгаан, дулаангүй болох, цаашлаад хөлдөх ч эрсдэлд орчихоод байна. Энэ асуудлыг бид цогцоор нь шийдэхээс өөр аргагүй. Реформыг богино хугацаанд эхлүүлж, хэрэгжүүлж явахаас өөр сонголтгүй.

-Салбарын талаарх олон нийтийн ойлголт мэдээлэл хир байна гэж харж байна вэ?

-Сүүлийн жилүүдэд олон нийт эрчим хүчний салбар хүнд байгаа, үнэ тарифыг нэмэхээс өөр аргагүй байна гэдэг талаар мэдээлэл авч тодорхой ойлголттой болсон. Салбарын нөхцөл байдлыг олон нийт ерөнхийдөө гадарлаж байна. Нэг зүйл хэлэхэд, реформ хийхэд олон нийтийн сэтгэлгээ, хандлага их чухал. Олон нийтэд асуудлаа илэн далангүй ярьж, мэдээллээд явах нь ач холбогдолтой. Энэ хүнд цаг үеийг хамтдаа давж гарахад олон нийтийн дэмжлэг маш чухал. Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө, салбарын найдвартай, аюулгүй байдлын төлөө тал талдаа зөв ойлголт, мэдээлэлтэй, бие биенээ дэмжсэн хандлагатай ажиллахаас өөр аргагүй.

Нөгөө талд, салбарын ажиллагсдын сэтгэлгээг өөрчлөх нь тулгарч буй том бэрхшээл юм байна гэж харсан. Энэ хүмүүсийн буруу биш. Социализмын 70, зах зээлийн системийн 30 гээд уламжлалт системийн бараг 100 жилийн түүхтэй системийг эвдэж өөрчилнө, зах зээлийн зарчмаар нь ажиллуулна гэхээр хүлээж авч чадахгүй байна. Шинэ, хуучны ялгаа гарна. Гэхдээ бид салбарын ажилтнуудтай сайн тулж ажиллаад хамтдаа гарц шийдлийг хайж шинэчлэлийг хийнэ.

-Бодлого тодорхойлогчдын зүгээс эрчим хүчний салбарын реформыг дэмжих, хүлээн авах хандлага ямар байна вэ?

-Сайн байгаа. Шинэ УИХ 126 гишүүнтэй.

Эрчим хүчний реформыг дэмжих бүлэгт 100 гаруй гишүүн гарын үсэг зурсан. Энэ бол өөрөө маш том дэмжлэг гэж бодож байгаа. Миний хувьд энэ лобби бүлгийг байгуулаад, ахлаад явж буйн хувьд гишүүн бүртэй уулзсан, ярьсан. Тэд эрчим хүчний салбарыг ойлгож, асуудлыг зөв өнцгөөс харж, танилцмаар байна гэж байсан. Энэ бол зөв дохио юм. УИХ-ын гишүүд эрчим хүчийг хамгийн чухал салбар гэж харж, хүлээн авч байгаа нь маш том ач холбогдолтой. Реформд маш том дэмжлэг болно. Мэдээж сайны хажуугаар саар гэгчээр цөөн гишүүн өөр байр суурьтай байгаа. УИХ-ын чуулган дээр үг хэлж буй байдлаас нь харж болно. Өөрийн рейтингийг өсгөх үүднээс олон

нийтэд буруу ташаа мэдээлэл өгч, попорч хандаж байгаа. Харамсалтай. Учир нь эрчим хүчний салбарыг шинэчилж, өөрчилж, хөгжүүлж байж улс орон хөгжинө. Тиймээс ямар нэг улс төр, ямар нэг попролгүйгээр реформыг явуулж өгөөсэй гэж хүсч байна.

-Таны хувьд УИХ дахь хамгийн залуу гишүүн, Gen Z үеийн төлөөлөл. Эрчим хүчний салбарыг яагаад сонирхож, асуудлыг барьж авав?

-Би АН-ын Хөгжлийн бодлого хариуцсан нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Тухайн үед “Мөрийн хөтөлбөр” боловсруулахын тулд бид удаан хугацаанд ажилласан. Намынхаа гишүүдээс, ард иргэдээс, байгууллагуудаас

санал авсан. Энэ хооронд бүх байгууллага, иргэд Монгол улсад тулгамдаж буй хамгийн гол асуудал эрчим хүч гэдэгтэй санал нэгдсэн. Хөгжлийн бодлого ярихаар л эрчим хүчний салбар дээр ирээд зогсдог. Хөгжлийн гол гогцоо, тушаа нь эрчим хүч гэдэг нь харагдсан. Би асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх ёстой гэж үздэг. Эндээс эрчим хүчний асуудлыг шийдэхгүйгээр бид аж үйлдвэржилт, хөгжил ярих ямар ч боломжгүй юм байна гэдгийг ойлгосон. Тиймээс энэ салбарын асуудлыг шийдэхийн төлөө орж ажиллая, дахин цаг алдаж болохгүй гэдэг үүднээс эрчим хүчний салбарт түлхүү анхаарч орсон.



Б.НАЙДАЛАА
УИХ-ын гишүүн, Эрчим хүчний үндэсний хорооны гишүүн



Засаглал нь үр ашиг сайтай, хөрөнгө оруулагчдаа татах боломжтой болвол дулааны цахилгаан станцууд, усны, нарны эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулалт орж ирнэ

Б.Найдалаа: Эрчим хүчний шинэчлэлийн суурийг одоо л тавих цаг ирсэн

Эрчим хүчний реформыг өргөн хүрээнд харж байгаа. Зөвхөн үнэ тарифийн өөрчлөлт гэж хүмүүс буруу харах гээд байна. Энэ бол 20-30 жил шинэчлэл хийж чадахгүй байсаар байгаад цахилгаангүй болох хэмжээнд хүндэрсэн асуудал. Тиймээс эрчим хүчний шинэчлэлийг манлайлах үндэсний хороог байгуулсан. Үндэсний хороо олон багц асуудлыг шийднэ. Хамгийн чухал нь засаглал. Ямар ч тохиолдолд эрчим хүчний компаниуд цахилгаан станцаасаа авахуулаад түгээх, дамжуулах байгууллагуудын засаглал нь сайн байх ёстой. Үр ашигтай ажилладаг, зардал хэмнэдэг ба, ажилчид нь өндөр цалинтай байх ёстой. Энэ бол нэн тэргүүнд хийх ёстой ажил юм. Үүний дараа зардлаа нөхөхүйц шударга үнэ тариф мөрдөх ёстой. Ингэсний дараа засаглал нь үр ашиг сайтай, хөрөнгө оруулагчдаа татах боломжтой болж, шинэ эх

үүсвэр, цахилгаан станцууд усны, нарны, нүүрсний эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулалт орж ирнэ.

2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хууль өнөөг хүртэл шинэчлэгдээгүй. Хуульд байхгүй шинэ үзэгдэл энэ салбарт гараад ирсэн. Тиймээс эрх зүйн шинэчлэлийг иж бүрнээр нь хийх ёстой. Энэ өөрчлөлтүүд нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд дарамт ачаалал багатай хийгдэх ёстой. Эрчим хүчийг хэрэглэж байгаа иргэд, байгууллага бүрт өөр өөр тариф тогтоох хэрэгтэй. Үүнийг нь оновчтой шударга тогтоох нь шинэчлэлийн нэг хэсэг байгаа юм. Эрчим хүчний салбарын 10-20 жилийн дараах хурдацтай хөгжлийн суурийг бид өнөөдөр тавих ёстой. Асуудлыг хойш нь тавьсаар байгаад энэ асуудлыг хүндрүүлчихээд байна. Тиймээс бид реформын суурийг нь цаг алдалгүй тавих нь чухал байна.



Д.Энхтуяа: УИХ-ын гишүүд эрчим хүчний реформ хийхээр зориг гаргаад ажиллаж байна



Д.ЭНХТУЯА
УИХ-ын гишүүн,
Эрчим хүчний
үндэсний хорооны
гишүүн



Монголчууд тусгаар тогтнолоо эрхэмлэдэг ард түмэн шүү дээ. Эрчим хүчээр найдвартай, хүртээмжтэй, иж бүрэн хангагдаж байх нь улс орны тусгаар тогтнолын нэг чухал баталгаа юм. Тиймээс бид хамтдаа бүх асуудал бэрхшээлээ ил тавьж байгаад шийдэх л хэрэгтэй

Шинэ парламент бүрдсэний дараа хамгийн анх байгуулагдсан эрчим хүчний шинэчлэл хийх дэд хорооны гишүүнээр сонгогдоод ажиллаж байна.

Парламентад зонхилох суудал бүхий гурван намын хамтран ажиллах гэрээнд үндэслэсэн “Тогтвортой хөгжлийн төлөөх зориг” гэсэн малгайн дор ажиллаж байгаа хамтарсан Засгийн газрын хийх чухал ажил бол эрчим хүчний реформ. Эрчим хүч бол манай улсын тэргүүлэх салбар байх ёстой. Том мега төслүүд хэрэгжүүлнэ гээд л яриад байдаг. Гэтэл эрчим хүчний асуудал нь шийдэгдээгүй байхад энэ нь ямар ч боломжгүй. Өнөөдөр эрчим хүчний салбар маань маш хүнд байдалд байна. Тиймээс УИХ-ын гишүүд эрчим хүчний реформыг яаралтай хийе гээд зориг гаргаад ажиллаж байна. Эрчим хүчний шинэчлэл бол зөвхөн үнэ тарифын асуудал биш. Үнэ тарифтай холбоотойгоор маш их улстөржилт явагддаг учраас энэ салбар улсын татаасаар явсаар өнөөдрийн хүнд байдалд орсон.

Зөвхөн үнэ тарифын асуудал ярихаас илүүтэйгээр эрчим хүчний салбарт цогц реформыг хийх хэрэгцээ, шаардлага бий. Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудад сайн засаглалыг бэхжүүлэх, салбарын байгууллага, нэгжүүдийн ажил үүргийн хуваарийг оновчтой, үр дүнтэй болгох зорилгоор бүтцийн шинэчлэл хийх, салбарын ажиллах хүчин, мэргэжилтэй боловсон хүчний талаар тусгайлан анхаарах, энэ салбарт өрсөлдөөнийг бий болгох, тенхик-технологийн шинэчлэл хийх гэх мэтээр шийдэх асуудал бол их. Миний хувьд энэ салбарын хүн биш. Эрчим хүчний салбарт улстөржилт их явдаг. Тухайн үеийн эрх баригчид нь “өөрчилье, шинэчлэл хийе” гэхээр сөрөг хүчин, ард түмэнтэйгээ нийлээд эсэргүүцээр мухардлын байдалд оруулчихсан. Тиймээс зонхилох гурван намын хамтарсан Засгийн газар байгуулагдсан энэ цаг үед энэ өөрчлөлтийг хийх боломжтой. Хэвлэл мэдээллийн салбарт ажилласан туршлага, нийгмийн асуудлаар голчлон ажилладгийг маань харгалзаж, Үндэсний хороонд оруулсан гэж ойлгож байгаа. Тиймээс эрчим хүчний цогц өөрчлөлтийн талаар нийгэмд бодит зөв мэдээлэл хүргэж, зөв ойлголт бий болгохын төлөө чармайн ажиллаж байна. Монгол хүмүүс ухаантай, улс орондоо хайртай, тусгаар тогтнолоо эрхэмлэдэг ард түмэн шүү дээ. Улс орны тусгаар байдлын нэг чухал баталгаа бол эрчим хүчний систем, хангамжийн найдвартай, хүртээмжтэй, хангалттай, иж бүрэн байдал гэж боддог. Тиймээс бид хамтдаа бүх асуудал бэрхшээлээ ил тавьж байгаад шийдэх л хэрэгтэй. Ард нь гарна гэдэгт эргэлзэхгүй байгаа.

Ч.Анар: Халамжийн сэтгэхүйгээр яваад байвал энэ салбарт хөгжлийн тухай яриад нэмэргүй

Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал халамжийн байдалтай явж ирсэн. Улсын төсвөөс татаастай, дэд бүтэц нь хоцорч хуучирсан, хоёр хөршөөс хараат байдалтай гэх мэт. Эрэлт өнөдөртэй, нийлүүлэлт дутагдалтай. Сууриар нь дорвитой өөрчлөлт хийж засахгүй бол эрчим хүчний салбар маань тэр чигээрээ уналтад орох бодитой аюул ойрхон болсон байгаа. Эрчим хүчний хязгаарлалтууд ч үүнийг харуулна. Энэ чиглэлээр Үндэсний хороо томоохон ажлууд хийхээр төлөвлөж байна. Үнэ тарифын хувьд ард иргэдэд дарамт үүсгэхгүйгээр үе шаттайгаар нэмэх бодлого баримтлах судалгааг хийж байна. Нөгөө талаас, эрчим хүчний үнэ өртгөөсөө бага байна гэдэг нь эрчим хүчийг үнэгүйдүүлж байна. Энэ нь өөрөө үндэсний аюулгүй байдлын асуудал боллоо. Тиймээс цахилгаан, дулааны үнийг үе шаттайгаар нэмэгдүүлснээр хэрэглэгчдийн хувьд ухамсарт хэрэглээ рүү орох нөхцөлийг бүрдүүлнэ гэж харж байна. Мөн салбар гадны хөрөнгө оруулалт татаж, салбар хөгжиж, улмаар олон улсад экспортлох хэмжээний чадавхитай болох юм. Эрчим хүчний салбар өнөөдөр татаасаар яваад байгаа тул хөрөнгө оруулалт хийгдэхгүй, хөгжихгүй байна.

Реформ хийснээр салбар зах зээлийн системээр өрсөлдөөн дунд ажиллаж эхэлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт орж ирнэ. Айл өрх бүр сэргээгдэх эрчим хүч нийлүүлэгч, үйлдвэрлэгч болох боломжтой болно. Энэ нь эрчим хүчний салбар эдийн засгийн хувьд чадавхижиж, эрчим хүчний томоохон экспорлогч болох боломжтой болно. Газар зүйн ийм том байршил, давуу талтай улс шүү дээ. Энэ боломж нөхцөлүүдээ ашиглаад ирээдүйд томоохон орлого олох



боломжтой болно гэж харж байгаа.

УИХ дээр Эрчим хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийх зорилготой ажлын хэсгийг байгуулсан. М.Энхцэцэг гишүүн ахалж байгаа.

Монголд хүнд аж үйлдвэрийг хөгжүүлбэл, бүтээн байгуулалтуудыг хийе гэвэл эрчим хүчний салбараа хөгжүүлэхээс өөр сонголтгүй. Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байж, хүнд аж үйлдвэр, улс орон хөгжинө. Суурь асуудлыг шийдэж байж хөгжил ярина. Үүнээс өөр гаргалгаа байхгүй. Тиймээс зоригтой эхлүүлэх хэрэгтэй. Түүнээс халамжийн сэтгэхүйгээр яваад байвал энэ салбарт хөгжлийн тухай яриад нэмэргүй. Тухайлбал, сүүлийн өдрүүдэд өрнөж Куб улсын жишээ сонгодог жишээ болж байна. Маш хямдхан эрчим хүч нийлүүлж явсаар байгаад эцэс сүүлд нь эрчим хүчний салбар уналтад орж, улс үндэстнээрээ тоггүй болох эрсдэл маш ойрхон байна гэдгийг хэлье.

Ч.АНАР

УИХ-ын гишүүн,
Эрчим хүчний
үндэсний хорооны
гишүүн



Эрчим хүчний
үйлдвэрлэлийг
нэмэгдүүлж
байж, хүнд аж
үйлдвэр, улс орон
хөгжинө. Суурь
асуудлыг шийдэж
байж хөгжил
ярина. Үүнээс
өөр гаргалгаа
байхгүй



Ж.Золжаргал: Эдийн засгийн тэлэлт нь эрчим хүчнээсээ болоод боомилогдсон

Ж.ЗОЛЖАРГАЛ
УИХ-ын гишүүн,
Эрчим хүчний
үндэсний хорооны
гишүүн



Эрчим хүчний
зохицуулах
хорооны
мэргэжлийн
зохицуулагчдыг
улс төрийн
нөлөөллөөс
холдуулах
хэрэгтэй



Монголд буруу тогтолцоо, бодит бус эдийн засаг явж ирсний гор нь эрчим хүчээр дамжиж гарч ирж байгаа. Бодит өртөг зардлыг нь тооцохгүйгээр улстөрчдийн хүслийн дагуу үнэ тогтоох нь эдийн засгийг эрүүл бус болгож байгаа юм. Үр дүнд нь эрчим хүчний үнэ тариф хямд боловч монголчууд маш их өртөг төлж байна. Нэгдүгээрт, салбар өөрөө тэр чигтээ алдагдалд орчихоор хаа нэгэн газраас нөхөж таарна. Угаасаа л тэр зөрүүг бүгдээрээ хуваагаад төлж байгаа гэсэн үг. Дээрээс нь үйлдвэрлэл явуулъя эрчим хүч байхгүй. Гэр хороололд, дэд бүтэц дулааны шугам сүлжээ тавъя эх үүсвэр байхгүй. Эдийн засгийн тэлэлт нь эрчим хүчнээсээ болоод боомилогдсон. Нийтээрээ төлж байгаа төлөөс бол энэ.

Хоёрдахь буруу үр дагавар нь хувийн сууц, байшинг цахилгаанаар халаах нь маш өндөр

өртөгтэй. Хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг. Эрчим хүч бодит өртөгтөө орвол тэр айлууд маш том алдагдалд орно. Дулааны үнэ бодит өртгөөсөө 60-70 хувь хямдхан. Үр дүнд нь хотын төвөөр баригдсан өндөр шилэн барилгууд тэр чигээрээ дулааны алдагдалтай. Үр дагавар нь улам том нөлөө үзүүлнэ. Энэ нь эдийн засгаа хойш нь татдаг. Энэ чигээрээ явбал эрчим хүчний хэрэглээгээ даахаа болиод сөхөрнө. Тиймээс үнэ тарифыг бодит болгох хэрэгтэй.

Эрчим хүчний тухай хуульд үнэ тарифыг тогтоохдоо зардлыг нөхөөд ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх тухай заалт бий. Эрчим хүчний зохицуулах хороонд үнэ тариф зохицуулдаг журам бий. Гэвч хэрэгждэггүй. Тэгэхээр Эрчим хүчний зохицуулах хорооны мэргэжлийн зохицуулагч нарыг улс төрийн нөлөөллөөс холдуулах хэрэгтэй. Түүнчлэн эрчим хүчний аж ахуйн нэгжүүд мэргэжлийн, хараат бус үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Түүний дараа арай харьцангуй эрүүлжээд ирэхээр хувийн хэвшлийн тоглолтууд илүү нэмэгдэнэ. Бүр дараа нь хөрөнгө оруулалт, эх үүсвэрүүд татаад эхэлнэ. Төслүүд нэмэгдээд эх үүсвэрүүд олшроод ирэхээр бид хуучин станцуудаа хувьчлах талаар ярьж болно.

Монгол Улсын эрчим хүчний салбарт хөрөнгө оруулдаг олон эх үүсвэртэй, аймгийн төвүүд дээр дулааны цахилгаан станц, дээрээс нь нар, салхины станц, усан станцтай, олон төрлийн орон даяар тархсан найдвартай ажиллагаатай, нэг нь зогсоход нөгөөдүүл нь зогсдоггүй, холимог, хагас бие даасан системтэй байх хэрэгтэй. Тэр нь эдийн засаг үйлдвэрлэлээ хөгжүүлэхэд хангалттай хэмжээний эрчим хүч гаргаж чаддаг байгаасай гэж хүсэж байна.



Тэвчээрийн тог тасарлаа

Өнгөрсөн есдүгээр сард Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооноос “Тэвчээрийн тог тасарлаа” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ үеэр холбогдох байгууллагын удирдлага, ажилтнуудын хэлсэн үгийг хүргэж байна. Эрчим хүчний салбарын ажиллагсдын нийгмийн асуудал ч орхигдсоныг хэлэлцүүлгийн үеэр

ажилтнууд онцолж байв. Тухайлбал, 2019 онд 5.7 тэрбум төгрөгөөр 333 ажилтны нийгмийн асуудлыг шийдэж орон сууцанд хамруулж байсан бол цар тахлаас хойш 59 хүнийг л орон сууцтай болгожээ. Бага цалинтай ч нийгмийн асуудлаа шийдүүлнэ гэсэн хүлээлттэй байсан хүмүүс тэсэхээ больж ажлаасаа гарч эхэлсэн байна.

Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга **Д.Долгор:**



Манай салбарт мэргэжилдээ хайртай, салбартаа ажиллах сонирхолтой цөөн хүн л үлдэж байна. 2021 онд ажиллагсдын 10, 2022 онд 18, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 16 хувь нь ажлаасаа гарсан. Үүнээс үүдэж хүний нөөцийн дутагдал үүссэн. Эрчим хүч бол нарийн мэргэжлийн хүмүүс ажилладаг салбар.

Гэтэл бид инженер, техникийн нарийн мэргэжлийн хүмүүсээ өндөр цалинтай бусад салбарт алдсаар байна. Наад зах нь станцууд, шугам сүлжээнд гэмтэл саатал гарахад цаг алдалгүй засварлах хүн хүчгүй болно. Цаашлаад аваар, саатал гарах эрсдэл улам нэмэгдэнэ.

Эрчим хүчний салбарын ахмад ажилтан **Ц.Уламбаяр:**



Эрчим хүчний салбар маш өндөр мэргэжил, мэдлэг шаардахаас гадна ажлын нөхцөл хүнд. Залуучуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд ажлын нөхцөлийг сайжруулж, цалинг нь нэмэх хэрэгтэй. Эрчим хүчний том техник, тоног төхөөрөмжийг дээд зэргийн гагнуурчид гагнана. Хэрэв чадахгүй бол зуух зогсоно, тэсэрч дэлбэрэхээс эхлээд улс орон маш их хохирол хүлээнэ. Өндөр хүчдэлийн шугамыг найдвартай хийхгүй бол бас л улс

оронд хохирол учирна. Манай гагнуурчид Өмнөд Солонгос руу олноор явж байгаа. Тэнд очсон өндөр зэрэглэлийн гагнуурчин хэд дахин илүү цалин авах нь мэдээж. Мөн эрчим хүчийг залуу үедээ сурталчлах хэрэгтэй. “Ахмадууд шигээ яаж мундаг мэргэжил, мэдлэгтэй болох вэ” гэж манай залуучууд их асуудаг. “Та нар мэргэжилдээ үнэнчээр зүтгээд байвал нэг мэдэхэд бидэн шиг болно шүү дээ” гэдэг.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн монтёр **Г.Чинзориг:**



Арван жилийн өмнө авч байсан 700 мянган төгрөгийн цалин тэр үедээ 500 ам.доллар байсан. Хэдий цалин нэмэгдсэн ч өнөөгийн нийгэмд 1.7 сая төгрөгийн цалин 500 ам.доллар хэвээрээ л байна. Хүнс бараа, байр орон сууцны үнэ хэд дахин өссөн, банк санхүүгийн хүүлэлт бидний амьдралыг улам дордуулсаар байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн ҮЭХ-ны дарга **Г.Дашдаржаа:**



Манай байгууллага нийслэлийн хэмжээнд ганцхан эксковаторчинтай ажиллаж байна. Эксковаторчин, цахилгаанчин, слесарь зэрэг мэргэжлийн хүмүүсийг ажилд авах гэхээр хүн ирэхгүй байна.



Х.Нямбаатар: Улаанбаатар хотын бүх бүтээн байгуулалт эрчим хүчээс болж саатах гээд байна



Бурхны авралаар шинэ төслүүд ашиглалтад ортол энэ станцууд маань амь барчихгүйхэн шиг л байгаасай гэж залбирч байна. Үнэхээр гомдмоор шүү

“Energy Mongolia” сэтгүүл Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатартай товч ярилцлаа.

-Улаанбаатарт тулгамдаад байгаа асуудлын тэргүүн эгнээнд эрчим хүчний дутагдал зүй ёсоор орно. Өнгөрсөн жилээс эхлэн нийслэлийнхэн цахилгааны хязгаарлалтад орж, энэ салбар ямар хүнд байгааг бага ч болов мэдэрсэн байх. Ер нь нөхцөл байдал ямар байна вэ?

Монгол Улсын төвийн эрчим хүчний систем маш хүнд байдалд байгаа. Манай нийт хэрэглээ 1636 МВт хүрсэн. Гэтэл суурилагдсан хүчин чадал маань дэндүү

чамлалтай байгааг ихэнх нь гадарлаж байгаа байх. Эрчим хүчний салбарт сүүлийн 20 гаруй жил маш олон томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжих алтан боломж байсан ч хийрхэл, улстөржилтөөс болж алдсан. 2013, 2014 он хүртэл дэлхийн зах зээл дээр нүүрсний цахилгаан станцуудад хөрөнгө босгох боломж байсан. Тэр цагаас хойш дэлхий даяар ногоон, эко эрчим хүч, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулж байна. Үүнд чиглэсэн НҮБ, Парисын Уур амьсгалын хэлэлцээр зэрэг уриалга, баримт бичгүүд ч бий. Ингээд нүүрсний цахилгаан станцад гаднын хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөл

үндсэндээ хумигдсан гэж болно.

Бид Дулааны V цахилгаан станц барих боломжоо 20 жилийн өмнө алдсан. Багануурын цахилгаан станцыг бас гацаасан. Үр дүнд нь өнгөрсөн өвлийг бараг 200 МВт-ын дутагдалтай өнгөрүүлээ. Ирэх жил 400 МВт-ын дутагдалтай өвөлжих тооцоолол гарсан.

-Тэгвэл эрчим хүчний маш гүн хомсдол үүсэх нь ээ?

-Шударгаар хэлэхэд тийм. Нийслэлчүүд хоногийн талд шахам эрчим хүчээ хязгаарлуулах хүртэл гамшгийн хэмжээний нөхцөл үүсэхэд бэлэн байна гэсэн үг. Улс орны хэмжээний хамгийн чухал асуудал орхигдчихоод байна. Энэ бол эрчим хүчний аюулгүй, найдвартай хэрэглээ.

-Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг ашиглалтад оруулчихвал асуудал шийдэгдэх үү?

-Бас ч тийм биш ээ. Хэрэв бид энэ жил Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг ашиглалтад оруулаад, батерейн 80-100 МВт-ын хүчин чадалтай станц шинээр барьчихвал ирэх жил цахилгааны хязгаарлалт харьцангуй бага байх юм билээ. Эрчим хүчний салбарынхантай хамтарч энэ тал дээр тооцоо, судалгаа хийсэн. Мэдээж, цаана нь бас эрчим хүч дутагдсан хэвээр байна.

Үйлдвэрлэлийг 400 МВт-аар нэмэгдүүлэх шаардлагатай гэж би дээр хэлсэн шүү дээ. Ер нь эрчим хүчний хэрэглээ, хэрэгцээ нь эдийн засгийн өсөлттэй ч шууд холбогддог. Өнгөрсөн өвлийн 11, 12 дугаар сард эрчим хүчний хэрэглээ 13 хувиар огцом өссөн. Энэ жил дахиад 12, 13 хувиар өсөх төлөвтэй байгаа. Дээр дурдсан хоёр төслийг хэрэгжүүлбэл 200 МВт-ын дутагдлаа нөхнө. Гэвч цаана нь дахиад 200 МВт-ын дутагдал гараад байна аа даа. Хэрвээ энэ хэмжээний эрчим хүчний асуудлыг шийдэж чадахгүй бол нийслэлийнхэн цахилгааны хязгаарлалтад орно.

Эрчим хүчний тарифыг боомилсоор байгаад давжааруулаад өсөлтийг нь зогсоочихсон. Тэгэхээр энэ салбар руу хэн ч орж ирэхгүй. Би сая Эрчим хүчний сайдтай уулзалт хийсэн. “Бид хотын эрчим хүчинд өөрчлөлт гаргая аа. Дулааны II цахилгаан станцаа манай өмчид шилжүүлээд өгчих.

Наадах чинь бүр онигоо шүү дээ. 22-хон МВт-ын эрчим хүч үйлдвэрлэдэг. Үүнийг 300 МВт-аар өргөтгөө, ТЭЗҮ-тэйгээ өгчих. Бид өөрсдөө дотоод зах зээл дээр мөнгө босгоод, өмчлөөд эрчим хүчний салбарт сэргэлт хийе” гэж хэлсэн. Харин Эрчим хүчний сайд “Татгалзах зүйлгүй гэдэг бичгээ өгье” гэсэн. Засгийн газар хэрхэн яаж шийдэхийг би хэлж мэдэхгүй байна. Үүнийг шийдчихвэл гурав дахь эрчим хүчнийхээ төсөл рүү орно.

-Нэлээд бухимдалтай байгаа юм аа даа?

-Би их ярьвал олон албан тушаалтанд бухимдсан сэтгэгдлээ илэрхийлэх байх. Улаанбаатар хотын бүх бүтээн байгуулалт эрчим хүчээс болж саатах гээд байна. Тиймээс арга буюу хот өөрөө эрчим хүчний төсөл рүү оръё гэж байгаа юм. Метро, орон сууцжуулах төслөөс эхлээд бүх бүтээн байгуулалт эрчим хүчнээс шалтгаална.

Улаанбаатарт хоёр том “шүдний өвчин” байна. Нэг нь эрчим хүч, нөгөөх нь хөрсний ус. Хөрсний усыг зайлуулахад мөн л эрчим хүч хэрэгтэй. Бүх зүйлийн анхдагч суурь нь эрчим хүч. Мөн 1984 оноос хойш нэг ч дулааны цахилгаан станц бариагүй. Байгаа станцуудынх нь насжилт хүндэрсэн л гээд байгаа. Бурхны авралаар, шинэ төслүүд ашиглалтад ортол энэ станцууд маань амь барчихгүйхэн шиг л байгаасай гэж залбирч байна. Үнэхээр гомдмоор шүү.

-Эрчим хүчнээс гадна дулаан хангамжийн асуудал хүндэрсэн. Дулааны асуудал дээр ямар ажил хийхээр төлөвлөж байгаа вэ?

-Улаанбаатарт дулааны тархмал эх үүсвэртэй 23 станц барих шаардлагатай байна. Таван станцын газрын асуудлыг Засгийн газарт оруулсан. Мөн л гагцхиад байна. Уг нь сайд нар нь ажлынхаа чиг үүргийн хүрээнд Засгийн газрын хуралдаанд оруулаад шийдэх ёстой шүү дээ. Таван станц ирэх жилийг түр л аргална.

Цаашид бид 18 дулааны станц барьж байж дулааны асуудлыг шийднэ. Арвынх нь зураг төсөл бэлэн болсон. Үүний тавыг нь энэ жил эхэлье гэж байгаа юм. Уг нь эхэлчихвэл маш хурдан барих боломжтой.


2024.05 сар



Улаанбаатарт дулааны тархмал эх үүсвэртэй 23 станц барих шаардлагатай байна. Таван станцын газрын асуудлыг Засгийн газарт оруулсан. Мөн л гагцхиад байна



“Бурханаас заяасан зовлон”-той Монгол Улсын цахилгаан эрчим хүч



Монгол Улсын эрчим хүчний салбар хүнд байдалд байна. Гэсэн хэдий ч 21 аймаг, 330 сумд эрчим хүчээр хангагдсан. Энэ бол тус салбарын гавъяа. Лаа барьдаг, оройны 18 цагт гэрэл асахыг хүлээж суудаг тэр цаг үе ард хоцорсон. Гэвч асуудал бий. Байсаар ч ирсэн. 21 аймаг, сумдыг эрчим хүчээр хангахын тулд Улаанбаатар хотын II, III, IV дулааны цахилгаан станц, Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд нийлээд мачийтлаа ажиллаж байна. Монгол Улсын Эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал 1649 МВт. Тодруулбал, Дулааны цахилгаан станц 1264 МВт буюу 76.7 хувь, Салхи 155 МВт буюу 9 хувь, Нарны цахилгаан станц 115 МВт буюу 7 хувь, Усан цахилгаан станц 26.035 МВт буюу 2 хувь, дизель 8.55 МВт буюу 0.52 хувь, батарей хуримтлуур 80 МВт буюу 4.85 хувийг эзэлж байна.

Гэвч жилээс жилд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангаж чадахгүй хэмжээнд аль хэдийн

хүрсэн. Өнгөрсөн 30 жилийн турш төрөөс цахилгаан станц барих талаар мөрөөдөж ярьсан ч талаар болсон. Энэ хугацаанд гурван хөтөлбөрийг цуцалжээ.

Монгол Улс эрчим хүчний хувьд орон зай, хэрэглээг шийдвэрлэх боломж хүнд. Дамжуулах шугам нь уртсах тусам маш бага эрчим хүч дамжуулж алдагдалд орж байна. Хүн амын өсөлт бага, хэрэглэгч хол байгаа нь өөрөө “Бурханаас заяасан зовлон” гэж. Энэ нь газар нутаг том, аймгууд хол оршдогтой холбоотой. Тухайлбал, Эрдэнэтээс явсан цахилгааны шугам 1000 км-ийн цаана байх Завхан аймагт хүрч байна. Замдаа өндөр уул нурууд, даваа гүвээ давна. Ингээд очихоор аймгийн сумдад цахилгаан эрчим хүчний чадал унаж очиж буйг мэргэжилтнүүд хэлж байгаа юм.

Харин дулааны хувьд Ерөнхий төлөвлөгөөний дагуу өсөн нэмэгдэх хэрэглээг хангах дэд бүтцийг барьж байгуулах, нийтийн зориулалттай орон сууцны байруудыг дулаалж хэрэглэгчийн дулааны алдагдлыг бууруулах, дундын өмчлөлийн

шугам сүлжээг засварлах, шинэчлэх ажлыг орон нутгийн төсөв, төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгаж хэрэгжүүлэх нь чухал гэдгийг Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Дулаан хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Оюунтунгалаг хэлж байна. Төв, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудад БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр дулааны станц барих төсөл эхэлсэн ч санхүү, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэргээс шалтгаалан одоо болтол царцанги байдалтай байгаа аж.

Аймгийн төвүүд, томоохон суурин газруудад ажиллаж буй нийт 193 халаалтын зуухны 90 хувь нь ашигт үйлийн коэффициент 60-70 хувь байгаа нь агаар орчныг ихээр бохирдуулж байна.

"Energy Mongolia" сэтгүүл Монгол Улсын нийслэл Улаанбаатар болон 21 аймагт цахилгаан, дулааны нөхцөл байдал ямар байгаа мэдээллийг хүргэж байна.

УЛААНБААТАР

ЦАХИЛГААН

994 MBT

УБ хотын дулааны цахилгаан станцуудын нийт хүчин чадал

75 MBT

Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал

2023 оны өвлийн оргил ачааллын үеэр

1636 MBT

хүчин чадал хүрсэн байна.

Цахилгаан дамжуулах сүлжээ:

Улаанбаатар хотыг цахилгаан эрчим хүчээр хангаж буй их болон бага тойрог сүлжээ нь шинээр хэрэглэгч нэмэх боломжгүй, нөхцөл байдалд байна. Тухайлбал, Улаанбаатар хотод 34 дэд станц, ил хуваарилах байгууламж байдаг. Үүнээс 17 нь 30-аас дээш жил ашиглагдсан, насжилт өндөртэй, ашиглалтын хугацаа

дуусчээ. Мөн нийт 34 дэд станцаас 21 дэд станц нь шинээр ачаалал нэмэх боломжгүй, 101-106, 111-112, 125-128, 131-138, 205-206 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай болжээ.

Улаанбаатар хотын 23 дэд станцаас найман дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж, шинээр 16 дэд станц барьж, 110 кВ их болон бага тойргийн сүлжээнээс холбох бөгөөд цахилгаан дамжуулах агаарын шугамыг нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх аж.

Үүнд, Улаанбаатар хотын төвийн өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах “Парк” 110/35/10 кВ-ын 2*63 МВА чадалтай дэд станцыг барих төлөвлөлтийн талаар тусгайлан оруулах шаардлага тулгарчээ. Улаанбаатар хотын төвд цахилгаан дамжуулах шугам дэд станц байхгүйгээс шугам сүлжээний чадал хүрэлцэхгүй болсон байна. Орчин үеийн их чадал шаарддаг хэт өндөр хэрэглээтэй орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг цахилгаан эрчим хүчээр хангахад энэ станцын ач холбогдол асар өндөр байдаг байна.

Цахилгаан түгээх сүлжээ:

“УБЦТС” ТӨХК нь Улаанбаатар хотын наймаг дүүрэг, Төв аймгийн 16 сумын аж ахуйн нэгж, айл өрхийн 494,850 гаруй хэрэглэгч буюу Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Үйлчлэх хүрээний нийт 4812.67 МВА суурилагдсан чадал бүхий 35 кВ-ын 1091.72 км шугам, 302 дэд станц, 6-10 кВ-ын 6181.43 км шугам, 8457 дэд станц, 127 хуваарилах байгууламж, 0.4 кВ-ын 4987.27 км шугам үүнээс компанийн ашиглалтын 2325.78 МВА суурилагдсан хүчин чадал бүхий 35 кВ-ын 916.29 км шугам, 67 дэд станц, 6-10 кВ-ын 3061.86 км шугам, 2780 дэд станц, 101 хуваарилах байгууламж, 0.4 кВ-ын 3722.14 км шугамын тасралтгүй найдвартай ажиллагааг ханган ажилладаг.

Улаанбаатар хотын цахилгаан ачааллын өсөлт, түгээх сүлжээний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахын тулд шинээр дэд станц, шугам тоноглол барих, одоогийн шугам тоноглолыг өргөтгөл шинэчлэлийн ажлыг зайлшгүй хийх шаардлага тулгараад байна.

ДУЛААН

Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрүүдийн дулаан үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал 2318 Гкал/ц бол дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгчдийн тооцоот ачаалал 3166 Гкал/ц болж нэмэгдсэн байна. Мөн техникийн нөхцлөө авсан 473 Гкал/ц-ийн хэрэглээ хүлээгдэж байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотод агаарын температур -35 хэмээс доош тогтвортой хүйтэрсэн нөхцөлд дулаан хангамжийн систем чадлын дутагдалд орж дулаан хангамжийн системийн эх

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

№	Эх үүсвэр	Анх ашиглалтад орсон он	Насжилт	Нэмэгдүүлэх хүчин чадал, өргөтгөл, шинэчлэлт Гкал/ц	Төсөл хэрэгжих хугацаа
1	ДЦС-3-ын өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	1983	41	100 Гкал/ц	2026-2028
2	ДЦС-3-ын дунд даралтын хэсгийг буулган, шинэ 250 МВт-ын дулааны цахилгаан станц барих	1968	56	240 Гкал/ц	2028-2030
3	Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөх төсөл	2015	9	100 Гкал/ц	2022-2024
4	ДЦС-2 -ийн дэд бүтцийг түшиглэн 300 МВт-ын дулааны цахилгаан шинээр барих	1961	63	340 Гкал/ц	2024-2029
	Нийт дүн			780 Гкал/ц	

үүсвэрээсээ алсдагдсан цэгүүдэд хүндрэл үүсэх эрсдэл өндөр нөхцөлд байна.

Улаанбаатар хотод жилд дунджаар 190 гаруй Гкал/ц-ийн хэрэглээ бүхий 280 гаруй барилга байгууламж төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр холбогдож байна. Нийслэлийн дулааны хэрэглээ жилд 7-8 хувиар өсөн нэмэгдэж, энэ хэмжээгээр хэрэглээний өсөлт тогтвортой гарвал 2025 оны түвшинд холбогдсон хэрэглэгчдийн ачаалал 3874 Гкал/ц болно.

Нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн системд 2015 онд Амгалангийн дулааны станц, 2020 онд Сэлбэ дэд төвийг барьж ашиглалтад оруулснаар дулааны үйлдвэрлэлийн хүчин чадал бага хэмжээгээр нэмэгдсэн боловч хэрэглээний өсөлтийг бүрэн хангаж чадахгүй байна. Улаанбаатар хотод шинэ дулааны эх үүсвэрүүд нэн шаардлагатай байна.

ӨВЛИЙН ИХ АЧААЛЛЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц, Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд амжилттай хэрэгжиж системийн суурилагдсан хүчин чадлыг 159 МВт-аар, ОХУ-аас импортоор авах эрчим хүчний дээд хязгаарыг 100 МВт-аар тус тус нэмэгдүүлснээр 2020 оноос өнөөдрийг хүртэлх өвлийн их ачааллыг эрсдэл хүндрэл багатай давж ирсэн. Цаашид том чадлын шинэ эх үүсвэр барьж ашиглалтад оруулахгүйгээр 2024-2025 оны өвлийн их ачааллаас эхлэн эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангаж чадахгүй, эрчим хүчний хангамжийн хязгаарлалтаас өөр сонголтгүй хүндрэлтэй нөхцөл байдал, цаг хугацаа эхэлж байна.

Дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолуудын аваарийн зогсолт, цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээний их бага хэмжээний гэмтэл, тасралтын тоо нэмэгдэж байгаа нь төлөвлөгөөт засвар, шинэчлэл бүрэн хийгдэж чадахгүй, байгаатай шууд хамааралтай байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд эх үүсвэр болон цахилгаан дулааны дамжуулах, түгээх сүлжээний үндсэн тоног төхөөрөмжийн насжилт, хуучралт нь эх үүсвэрийн дутагдлаас дутахгүй эрсдэлийг бий болгож байна.

Дулааны цахилгаан станцуудын насжилт 36-61 жил бол дулаан болон цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний насжилт 33-63 жил байна. Энэ нь насжилт өндөртэй шугам сүлжээг шинэчлэх ажлыг хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тухай бүр бүрэн шинэчилж чадахгүй байгаатай холбоотой юм. Ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд дулаан үйлдвэрлэгч эх үүсвэрүүдийн дулаанжуулалтын тоноглол 38-60 жилийн насжилттай байна.

2023-2024 оны халаалтын улирлын оргил ачааллын үед ДЦС-3, ДЦС-4-ийн дулаанжуулалтын тоноглолууд, зуух, турбин бүгд ажиллагаанд залгагдаж бэлтгэл тоноглолгүй өвөлжсөн. Энэ нь ажиллаж буй үндсэн тоноглол ялангуяа зуух, турбин доголдох, гэмтэл гарч зогсоход хотын сүлжээний горим шууд доголдох аюултай нүүр тулгарч байна.

Цаашид авах арга хэмжээ:

Улаанбаатар хотыг 2040 хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд 136 нэгж хорооллын 1638 Гкал/ц-ийн хэрэглээ шинээр нэмж холбогдохоор төлөвлөгөө гаргасан байна.

Дулаан хангамжийн эх үүсвэрийн чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлууд:

- Монгол Улсын Засгийн газрын 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрт эх үүсвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил, ТЭЗҮ хийгдсэн. /ДЦС-2 (395МВт), ДЦС-3 (395МВт), ДЦС-4 (210МВт), АДС (116МВт) /, +1116 МВт (960Гкал/ц)
- Дулаан хангамжийн оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн системтэй хослон ажиллах бичил эх үүсвэрүүд /Дэнжийн-1000 дэд төв (93МВт), НС-10 (112МВт), Дүнжингарав (84МВт), Их засаг (46МВт) ТЭЗҮ хийгдсэн. +335 МВт +288Гкал/ц ачаалал/.

Дээрх эх үүсвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлууд хийгдсэнээр 1451МВт (1248Гкал/ц)-ийн ачаалал хангах нөхцөл бүрдэх аж.

Дулаан хангамжийн дамжуулах шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлууд:

- 210МВт 2Ф800мм голчтой 4.2 хос.км шугам, 11г магистраль 2Ф1000мм голчтой 3.4 хос.км шугам, 10вгд магистраль Ф1000/800мм голчтой 4.2 хос.км шугам, Даралт өргөх насос станц №7 гэх мэт 19 нэр төрлийн дамжуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлуудыг 2024-2030 онуудад хөрөнгө оруулалтын асуудлыг үе шаттай шийдвэрлэж ашиглалтанд оруулах зайлшгүй шаардлагатай байна.
- 2019 оноос хойш эх үүсвэр болон дамжуулах шугамын хүчин чадал хүрэлцээгүй болсноос шалтгаалан хэрэглээ нэмэх боломжгүй байршлуудад шинээр техникийн нөхцөл олгохыг үе шаттай хязгаарлах шаардлага тулгарчээ.

АРХАНГАЙ

ЦАХИЛГААН

Архангай аймгийн 110/35/10 кВ-ын “Цэцэрлэг” дэд станцаас Хөвсгөл аймгийн 35/10 кВ-ын “Жаргалант” дэд станц хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нь 256.4 км урт нэг хэлхээт шугамаас Архангай, Завхан, Хөвсгөл аймгийн 10 сум, 6 багийн төв эрчим хүчээр хангагддаг. Эцсийн хэрэглэгч дээрх хүчдэлийн түвшин 29.7 кВ, 8.3 кВ хүртэл тус тус унаж, Нэгдсэн сүлжээний дүрэм (НСД)-д заасан зөвшөөрөгдөх хамгийн доод утгаас бага байна.

Завхан аймгийн Их-Уул-Жаргалант 35 кВ-ын 50.0 км Цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/, дэд станц барьж ашиглалтад оруулвал /12.95 тэрбум төгрөг/ Завхан аймгийн Их-Уул, Хөвсгөл аймгийн Жаргалант, Галт, Шинэ-Идэр сумдын эрчим хүчний чанар, хүчдэлийн уналт хэвийн хэмжээнд орно. Архангай аймгийн Чулуут, Тариат, Өндөр-

Улаан сумдын эрчим хүчний чанар, хүчдэлийн уналт сайжирна.

Үндсэн шийдэл: Мандалговь-Арвайхээрийн 220 кВ-ын хоёр хэлхээт 287 км урттай ЦДАШ баригдсанаар Монгол Улсын төвийн бүсийн аймгуудын өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаас гадна аймгийн төвүүдийн цахилгаан хангамж сайжирч хүн амыг тохь тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжихөд чухал ач холбогдолтой төсөл юм. Мөн Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Дундговь аймгийн хойд сумд, Төв аймгийн баруун захын сумд, Алтай Улиастайн Эрчим Хүчний Систем нь хоёр талын тэжээлтэй болж цахилгаан эрчим хүчний чанар болон найдвартай ажиллагаа эрс дээшлэх юм.

Төсөвт өртөг: 177,8 тэрбум төгрөг /62,3 сая.ам.доллар/

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Эх голомтын илч” ХХК

Суурилагдсан чадал: 25.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 15.0 Гкал/ц

Чадлын нөөц: 10.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 25 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 14 ш дулаан дамжуулах төв, 8.4 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно. 13.23 сая ам долларын төсөвт өртөгтэй. /ТЭЗҮ-ийн дүнгээр/

Тайлбар: Архангай аймгийн дулааны станцын төслийн хувьд “Эх Голомтын Илч” ХХК-тай холбоотой шүүхийн маргааны улмаас гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт хийгдээгүй хугацаа алдсан байдалтай байна.

БАЯН-ӨЛГИЙ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ББЭХС” ТӨХК-ийн харьяа Баян-Өлгий салбар

- 110кВ-ын Өмнөговь-Өлгий АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээт 144,8 км урттай ЦДАШ,
- 110/35/10 кВ-ын “Баян-Өлгий” дэд станц нь 2х8 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...62.5 хувь

Т-2 ...62 хувь

Үндсэн шийдэл: Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 220 кВ-ын хоёр хэлхээт 468,3 км урттай ЦДАШ,

шинээр 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцууд барих шаардлагатай. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг тус ЦДАШ-аар дамжуулан Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын хэрэглэгчдийг дотоодын хямд цахилгаан эрчим хүчээр хангаж, хараат байдлаас гаргана.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Эрчимбаян-Өлгий” ХК

Суурилагдсан чадал: 45.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 21.0 Гкал/ц

Чадлын нөөц: 24.0 Гкал/ц

Тайлбар: Баян-Өлгий аймгийн Өлгий сумын агаарын бохирдлыг бууруулах, өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах, шинээр төлөвлөж буй орон сууцны хорооллын дулаан хангамжийг шийдвэрлэхэд шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ-г боловсруулах шаардлагатай.

БАЯНХОНГОР

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Хангайн бүсийн салбар

- 110 кВ-ын “Арвайхээр- Баянхонгор” чиглэлийн АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 205.25 км урттай ЦДАШ
- 110/35/6 кВ-ын “Баянхонгор” дэд станц нь 2х6.3 МВА, 110/35/10 кВ-ын 1х2.5 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- Т-1 ...90 хувь
- Т-2 ...92 хувь
- Т-3 ...25 хувь

Хэрэгжиж буй төсөл арга

хэмжээ: Улсын төсвийн хөрөнгө оруулалт 13 тэрбум төгрөг
110/35/10 кВ-ын 2х16 МВА, станцын өргөтгөлийн ажилд зарцуулна.

1. Баацагаан, Баянбулаг, Бууцагаан, Гурванбулаг, Жаргалант, Заг, Хүрээмарал сумын төвийн хэрэглэгчдийн хүчдэлийн уналтыг сайжруулахын тулд Баянхонгор-Бөмбөгөр сумын 35 кВ-ийн ЦДАШ-ыг 110 кВ-болгон өргөтгөх шаардлагатай.

2. Баян-Овоо, Галуут сумдыг тэжээж байгаа 15 кВ-ийн ЦДАШ-аас уурхай

цахилгаан эрчим хүч авдгаас сумын төвийн хүчдэлийн уналтыг бий болгож байна.

3. Эрдэнэцогт, Өлзийт сумыг түгээх сүлжээний шинэчлэлээр хүчдэлийн уналтыг шийдэх боломжтой. Мандалговь-Арвайхээрийн 220 кВ-ын хоёр хэлхээт 287 км урттай ЦДАШ баригдсанаар Монгол Улсын төвийн бүсийн аймгуудын өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаас гадна аймгийн төвүүдийн цахилгаан хангамж сайжирч хүн амыг тохь тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжихөд чухал ач холбогдолтой төсөл юм. Мөн Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Дундговь аймгийн хойд сумд, Төв аймгийн баруун захын сумд, Алтай Улиастайн эрчим хүчний систем нь хоёр талын тэжээлтэй болж цахилгаан эрчим хүчний чанар болон найдвартай ажиллагаа эрс дээшлэх юм.

Төсөвт өртөг: 177,8 тэрбум төгрөг /62,3 сая.ам.доллар/

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: Хувийн хэвшлийн болон орон нутгийн өмчит найман аж ахуйн нэгж хариуцдаг.

Суурилагдсан чадал: 23.3 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 24.0 Гкал/ц

Чадлын нөөц: Хүчин чадал тулсан
Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, найман ширхэг дулаан дамжуулах төв, 7.3 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаардлагатай. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж, ажлын явцыг удаашруулж байна.

БУЛГАН

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Хангайн бүсийн салбар

- 110 кВ-ын “Эрдэнэт-Булган” чиглэлийн АС-150/24 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 54.51 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Булган” дэд станц нь 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- Т-1 ...Бэлтгэлд
- Т-2 ...51 хувь

1. Булган аймгийн Баяннуур сум хүчдэлийн уналт шийдэх боломжтой.

Үндсэн шийдэл: Мандалговь-Арвайхээрийн 220 кВ-ын хоёр хэлхээт 287 км урттай ЦДАШ баригдсанаар Монгол Улсын төвийн бүсийн аймгуудын өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаас гадна аймгийн төвүүдийн цахилгаан

хангамж сайжирч хүн амыг тохь тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжихөд чухал ач холбогдолтой төсөл юм. Мөн Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Дундговь аймгийн хойд сумд, Төв аймгийн баруун захын сумд, Алтай Улиастайн эрчим хүчний систем нь хоёр талын тэжээлтэй болж цахилгаан эрчим хүчний чанар болон найдвартай

ажиллагаа эрс дээшлэх юм.

Төсөвт өртөг: 177,8 тэрбум төгрөг /62,3 сая.ам.доллар/

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Энержи плас” ХХК, “Булганмээж” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 24.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 14.0 Гкал/ц

Чадлын нөөц: 10.0 Гкал/ц

Тайлбар: Булган аймагт төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2014 онд “Энержи Плас” ХХК-тай гэрээ байгуулан 2019 онд 28 МВт-ийн хүчин чадалтай дулааны станцыг (сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий эргэлдэх буцламтгай давхаргатай зуухтай) ашиглалтад оруулж, аймгийн хэрэглэгчдийг дулаанаар ханган ажиллаж байна. Дулааны эх

үүсвэрийн хувьд чадлын нөөцтэй.

Тайлбар: Тус аймгийн дулаан түгээх, хангах үйл ажиллагааг хариуцан ажилладаг “Булган Мээж” ОНӨХХК-тай “Энержи Плас” ХХК өр авлагын асуудлаас шалтгаалан урсгал болон их засвар, нүүрс, ажилчдын цалингийн асуудлаа шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа нь тус аймгийн дулаан хангамжийн аюулгүй ажиллагаа, найдвартай байдалд хүндрэл үүсгэж байна.

ГОВЬ-АЛТАЙ

ЦАХИЛГААН

110/35/6 кВ-ын 2х12.5 МВА чадалтай “Тайшир УЦС”, 35/6 кВ-ын “Есөнбулаг” дэд станц нь 3х4000 кВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...80 хувь

Т-2 ...85 хувь

Т-3 ...60 хувь

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг-Бигэр-Чандмань сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаас Бигэр, Чандмань, Цээл, Халиун, Эрдэнэ, Цогт сумдыг тэжээдэг. Энэ шугамаас тэжээгдэж байгаа сумын төвийн хүчдэлийн уналтыг Бигэр сумын нутагт орших “Хан-Алтай” алтны уурхай 1.4 МВт ачаалал авснаар бий болгож байна. Тайшир-Есөнбулагын 110 кВ-ын ЦДАШ, дэд станц 10 гаруй жил баригдаж энэ онд ашиглалтад орох төлөвтэй. 1200 шахам километр үргэлжилсэн энэ шугам горимын хүндрэл ихтэй. Гэвч тодорхой хэмжээнд хүчдэл сайжруулахаар байна.

2. Манхан сумын 110/35/10 кВ-ын дэд станцаас Манхан-Зэрэг-

Хөшөөт-Дарви-Шарга-Есөнбулаг хүртэл 35 кВ-ын 380 гаруй км ЦДАШ ашигладаг. Энэ шугамаар тэжээгдэж байгаа сумуудын хүчдэлийн уналтыг сайжруулахын тулд Манхан сумын 110/35/10 кВ-ын дэд станцаас Хөшөөтын уурхай хүртэл барих 110 кВ-ын ЦДАШ, дэд станцыг үргэлжлүүлэн Дарви сум хүртэл барих шаардлагатай.

Үндсэн шийдэл: Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 220 кВ-ын хоёр хэлхээт 468,3 км урттай ЦДАШ, шинээр 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцууд барьж, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг тус ЦДАШ-аар дамжуулан Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын хэрэглэгчдийг дотоодын хямд цахилгаанаар хангах боломжтой.

ДУЛААН

Алтай хотын төвийн хэрэглэгчдийн 90 гаруй хувийг “Мандал голомт” ХХК бусад хэрэглэгчдийг “Удмын Ундраа”, “Ундррам-Оюу” ХХК хариуцан ажилладаг. Хэсэгчилсэн дулаан

хангамжийн системтэй.

Ашиглагч: “Мандал голомт” ХХК, хувийн өмчтэй

Суурилагдсан чадал: 54.5 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 30.0 Гкал/ц

Чадлын нөөц: 22.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 25 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, зургаан ширхэг дулаан дамжуулах төв, 4.5 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж, ажлын явцыг удаашруулж байна.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй, зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаардлагатай.

ГОВЬСҮМБЭР

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Зүүн-Өмнөд бүсийн салбар

- 220 кВ-ын Багануур-Чойр чиглэлийн 207-р ЦДАШ АС-300/39 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 6.9 км, АС-240/32 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 171.1 км урттай
- 220/110/35/6 кВ-ын "Чойр" дэд станц нь 2х200 МВА хүчин чадалтай, 110/35/6 кВ-ын 2х4000 кВА

Ачаалал:

- АТ-1 ...40 хувь
- АТ-2 ...Бэлтгэлд
- Т-3 ...100 хувь
- Т-4...Бэлтгэлд

Хүчдэлийн уналттай сум байхгүй.

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Ус Ду” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 22.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 10.5 Гкал/ц

Чадлын нөөц: 11.5 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, таван ширхэг дулаан дамжуулах төв, 7.5 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн

зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж, ажлын явцыг удаашруулж байна.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай.

ДАРХАН-УУЛ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Төвийн бүсийн салбар

- 220 кВ-ын (Улс хоорондын транзит АШ-257, 258) нь АС-300/39 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 111.3 км урттай ЦДАШ
- 220 кВ-ын (208 АШ) нь АС-300/39 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 121.4 км урттай ЦДАШ
- 220/110/35 кВ-ын “Дархан” дэд станц, 2х63 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- АТ-1 ... 40 хувь
- АТ-2 ... 81 хувь

- 110/6 кВ-ын “Бурхант” дэд станц, 2х25 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- Т-1 ... Бэлтгэлд
- Т-2 ... 50 хувь

- 110/6 кВ-ын “Үйлдвэр” дэд станц, 2х25 МВА хүчин чадалтай,

Ачаалал:

Т-1 ... 14 хувь

Т-2 ... Бэлтгэлд

- 110/6 кВ-ын “Давхар” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ... 34%

Т-2 ... 42%

- 110/6 кВ-ын “Тосгон” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ... 21%

Т-2 ... 11%

Үндсэн шийдэл: Улаанбаатар хотоос Сонгино-Дархан 220 кВ-ын хүчдэлтэй, 220 км урттай ЦДАШ, 220 кВ-ын дэд станцыг 154 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьснаар Төвийн эрчим хүчний системийн Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын цахилгаан хангамж, тогтворжилт, найдвартай ажиллагаа эрс дээшилнэ.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК

Суурилагдсан чадал: 364.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 246.0 Гкал/ц

Чадлын нөөц: 118.0 Гкал/ц

Дархан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 218.03 Гкал/ц-ийн тооцоот ачаалал бүхий 15921 айл өрх, 1713 аж ахуй нэгж байгууллагыг 23.7 хос км дулаан дамжуулах шугам, 91.4 хос км түгээх салбар шугам, 3.3 км уурын шугам, насосны гурван дэд станц, 14 дулаан дамжуулах төвөөр дамжуулан, “ДҮТ” ТӨХХК-аас баталсан өвлийн их ачааллын горимыг хэрэгжүүлэн жилд дунджаар 631-647 мянган Гкал дулааны эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн ажиллаж байна.

Тайлбар: Дархан сумын дулаан хангамжийн системд 2023-2024 оны халаалтын улиралд нийт 12.8 Гкал/ц бүхий 84 барилга шинээр холбогдсон. 2024-2025 оны халаалтын улиралд дулааны сүлжээнд холбогдохоор хүлээгдэж байгаа “ДДС” ТӨХК-иас олгосон дулааны техникийн нөхцөлтэй 76.5 Гкал/ц-ийн тооцоот ачаалал бүхий

барилга байгууламж байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого “Алсын хараа-50”, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын төвлөрөлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрүүд, Дархан хотын хөгжлийн ерөнхий болон

хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу дулааны эрчим хүчний хэрэглээ хурдацтай өсөж байна. 2025 он гэхэд дулааны эрчим хүчний хэрэглээ 7.6-9.0 хувиар өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Иймд зайлшгүй шинэ эх үүсвэрийг барьж байгуулах шаардлага үүсээд байна. Үүний тулд шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төслийг хийлгэх шаардлагатай.

ДОРНОГОВЬ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Зүүн-Өмнөд бүсийн салбар

- 110 кВ-ын Сайнишанд ЦДАШ нь АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 124.3 км урттай
- 110/35/10 кВ-ын Сайнишанд дэд станц, 2х16 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- Т-1 ...86 хувь
- Т-2 ...86 хувь

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Чандмань-Илч” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 35.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 32.0 Гкал/ц

Чадлын нөөц: 3.0 Гкал/ц

Хэрэгжүүлэх шаардлагатай

төсөл: Аймгийн төвийн дулааны

станцын зуух №2, 3-ыг шинэчлэх шаардлагатай. Нэг зуухыг шинэчлэхэд гурван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Тайлбар: Цаашид сумын агаарын бохирдлыг бууруулах, өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах, шинээр төлөвлөж буй орон сууцны хорооллын дулаан хангамж шийдвэрлэхэд шинэ эх үүсвэрийг барих шаардлагатай.

ДОРНОД

ЦАХИЛГААН

Ашиглагч “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

- 36 МВт-ын хүчин чадалтай ДЦС
- 110/35/6 кВ-ын “Чойбалсан” дэд станц 1х10МВА, 1х16МВА, “Чойбалсан ДЦС”-ийн 1х10 МВА, 3х16 МВА, 1х25 МВА хүчин чадалтай болон 6 кВ-ын хуваарилах байгууламж

Ачаалал:

- “Чойбалсан” дэд станц:
- Т-1 ...бэлтгэлд

Т-2 ...45 хувь
“Чойбалсан ДЦС”:

Т-110 хувь

Т-2бэлтгэлд

Т-351 хувь

Т-4бэлтгэлд

Т-5.....55 хувь

6 кВ-ын хуваарилах байгууламж: 10.5 МВт

1. Дашбалбар сумын 10 кВ-ын ЦДАШ-ын хүчин чадал хүрэлцэхгүй тул 2022-2024 онд

Монгол Улсын төсвийн 9,68 тэрбум төгрөгөөр 35 кВ-ын ЦДАШ, дэд станц барьж хүчин чадал нэмэгдүүлсэн. Одоо 10 кВ, 0,4 кВ-ын шугам сүлжээг өргөтгөнө.

2. Халхгол, Баян-Уул, Чойбалсан сумдыг түгээх сүлжээний шинэчлэлээр шийдэх боломжтой.

Үндсэн шийдэл: Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын хүчдэлтэй, хоёр хэлхээт 518 км урттай ЦДАШ, 220/110/35 кВ-ын 2х63 МВА хүчин чадалтай “Чингис”

дэд станц, 220/110/35 кВ-ын “Багануур” дэд станцын өргөтгөл 380 тэрбум төгрөгөөр барьж /131 сая.ам.доллар/ Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах боломж бүрдэнэ. Хүн ам суурьших, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих нийгмийн чанартай том төсөл болохоос гадна Монгол Улсын нэгдсэн эрчим хүчний систем буюу үндэсний цахилгаан дамжуулах сүлжээг байгуулах үндсэн бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

Суурилагдсан чадал: 170.0 Гкал/ц
Холбогдсон хэрэглээ: 90.0 Гкал/ц
Чадлын нөөц: 80.0 Гкал/ц

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани болон зохион байгуулагдсан. Тус компани Дорнод, Сүхбаатар аймгийн 27 сум, суурин газрын 29806 айл өрх, 3140 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүдийг 0.4, 10, 15, 35, 110 кВ-ын 3455,1 км агаарын болон кабель шугам, 507 ком дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Мөн Чойбалсан хотын 822 аж ахуйн нэгж, 6117 айл өрхийн хэрэглэгчдийг 26,5

хос/км далд болон ил шугамаар дамжуулан дулааны эрчим хүчээр тус тус хангаж байна.

Хэрэгжиж буй төсөл:

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 50 МВт-ын өргөтгөл төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж, төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын “ТВЕА” ХХК ажиллаж байна. Тус төсөл хэрэгжснээр дулааны хүчин чадал 100 Гкал/ц нэмэгдэнэ. Дулааны дамжуулах төв шугамыг өргөтгөх ажил 2024 оны улсын төсөвт тусгагдан гэрээ байгуулан ажиллаж байна. Ийнхүү дулаан хангамжийн найдвартай ажиллагаа дээшилсэн.

ДУНДГОВЬ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Говийн бүсийн салбар

- 220 кВ-ын “Сонгино-Мандалговь” 2 хэлхээ 250 км урттай 213, 214 ЦДАШ,
- 220 кВ-ын “Чойр-Мандалговь” 1 хэлхээ 191 км урттай 225 дугаар ЦДАШ-аар 220/110/35 кВ-ын “Мандал” дэд станц 2х63 МВА хүчин чадалтай

Ачаалал:

АТ-1 ...13 хувь

АТ-2 ...Бэлтгэлд

Хүчдэлийн уналттай сум байхгүй.

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Дундговь-Ус” ОНӨҮТ, “Тэвшийн говь” ХХК, “Ган-Илч” ХХК

Суурилагдсан чадал: 23.2 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 15.5 Гкал/ц

Чадлын нөөц: 7.7 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, таван ширхэг дулаан дамжуулах төв, 7.5 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно. Төслийг

хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж байгаагаа илэрхийлэн ажлын явцыг удаашруулж байна.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай.

ЗАВХАН

ЦАХИЛГААН

Ашиглагч: “Алтай-Улайстайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Завхан салбар.

- 110кВ-ын “Улиастай-Тэлмэн” АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 119.5 км урттай ЦДАШ
- 110кВ-ын “Тайшир-Улиастай” АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 133.9 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Улиастай” дэд станц 1х6.3 МВА, 1х16 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...Бэлтгэлд
Т-2 ...46 хувь

Цахилгаан дамжуулах агаарын шугам их урттай тул тасралт саатал ихтэй, дамжуулах чадлын нөөц багатай. Тосонцэнгэлийн 18 МВт чадалтай дулааны цахилгаан станц ашиглалтад 2025 онд орсноор цахилгаан хангамж сайжирна.

Үндсэн шийдэл: Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 220 кВ-ын хоёр хэлхээт 468,3 км урттай ЦДАШ, шинээр 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцууд барьж, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг тус ЦДАШ-аар дамжуулан Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын хэрэглэгчдийг дотоодын хямд цахилгаанаар хангах боломжтой.

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: Хувийн хэвшлийн 12 ААН хариуцдаг.

Суурилагдсан чадал 37.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 30.0 Гкал/ц

Чадлын нөөц: 7.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл:

БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 25 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, зургаан ширхэг дулаан дамжуулах төв, 4.5 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж, ажлын явцыг удаашруулж байна.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай.

ОРХОН

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК-ийн Хангайн бүсийн салбар

- 220 кВ-ын “Улаанбаатар-Эрдэнэт” чиглэлийн (АШ-203,204) АС-400/51 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 133.18 км урттай ЦДАШ
- 220 кВ-ын “Дархан-Эрдэнэт” чиглэлийн (АШ-201, 202) АСО-300/39 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 153.8 км урттай ЦДАШ
- 220/110/35/6 кВ-ын “Эрдэнэт” дэд станц нь 2х200 МВА, 110/35/6 кВ-ын

“Эрдэнэт” дэд станц нь 2х40 МВА хүчин чадалтай

Ачаалал:

АТ-1 ...40 хувь
АТ-2 ...40 хувь
Т-1...50 хувь
Т-2...50 хувь

Орхон аймгийн цахилгаан хангамжийг сайжруулах 35 кВ-ын ЦДАШ, дэд станцуудын ажлын зураг төсөл хийгдсэн. Төсөвт өртөг 33,9 тэрбум төгрөг бөгөөд 2025 оны Улс орон нутгийн

төсөвт тусгуулах төлөвлөгөөтэй. Хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдвэл хоёр жилийн дотор баригдана.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэт-Ус” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 302.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 150.0 Гкал/ц

Чадлын нөөц: 152.0 Гкал/ц

ӨВӨРХАНГАЙ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Хангайн бүсийн салбар

- 110 кВ-ын “Хархорин-Арвайхээр” чиглэлийн АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 122,98 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Арвайхээр” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай, Ачаалал:
Т-1 ...65 хувь
Т-2 ...75 хувь

Өвөрхангай аймгийн 110/35/10 кВ-ын “Баянтээг” дэд станцаас Баянхонгор аймгийн 35/15 кВ-ын “Шинэжинст” дэд станц хүртэлх 35 кВ-ын 297.7 км урт цахилгаан дамжуулах агаарын нэг хэлхээт агаарын шугамаас Баянхонгор, Өвөрхангай аймгийн есөн сумын төв эрчим хүчээр хангагдаж эцсийн хэрэглэгч дээрх хүчдэлийн түвшин 29.7 кВ, 12.2 кВ, 8.5 кВ хүртэл тус тус унаж байна. Баянлиг, “Шинэжинст” суманд батарей, нар хосолсон систем “Тархмал эх үүсвэр” барьж хүчдэлийн уналтыг сайжруулах боломжтой.

Үндсэн шийдэл: Мандалговь-Арвайхээрийн 220 кВ-ын хоёр хэлхээт 287 км урттай ЦДАШ баригдсанаар Монгол Улсын төвийн бүсийн аймгуудын өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахаас гадна аймгийн төвүүдийн цахилгаан хангамж сайжирч хүн амыг тохь тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжихөд чухал ач холбогдолтой төсөл юм. Мөн Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Дундговь аймгийн хойд сумд, Төв аймгийн баруун захын сумд, Алтай Улиастайн эрчим хүчний систем нь хоёр талын тэжээлтэй болж цахилгаан эрчим хүчний чанар болон найдвартай ажиллагаа эрс дээшлэх юм.

Төсөвт өртөг: 177,8 тэрбум төгрөг /62,3 сая.ам.доллар/

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: Хувийн хэвшлийн

дөрвөн аж ахуйн нэгж хариуцдаг.

Суурилагдсан чадал: 21.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 18.0 Гкал/ц

Чадлын нөөц: 2.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 11 ширхэг дулаан дамжуулах төв, 8.3 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж, ажлыг удаашруулж байна.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай.

ӨМНӨГОВЬ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК-ийн Говийн бүсийн салбар

- 9 МВт-ын Даланзадгадын ДЦС,
- 220 кВ-ын “Мандалговь-Тавантолгой” чиглэлийн (АШ-215, 216) LGJ-300/40 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээ 249,8 км урттай ЦДАШ
- 110 кВ-ын “Тавантолгой-Даланзадгад” чиглэлийн АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 86,9 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Даланзадгад” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...60 хувь

Т-2 ...55 хувь

1.Цогтцэций сумын төвийг Ухаа худгийн ДЦС-аас 10 кВ шугамаар хангадаг. Сум хөгжиж байгаа учраас Тавантолгой дэд станцаас 35 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барьж ашиглалтад оруулж байна.

2. Гурвантэс сумын 2023 оны өвлийн их ачаалалын хэмжилтээр сумын төвийн АТП-ын 0.4 кВ-ын

тал дээр доод талын хүчдэл 321 В, нэг фазын хүчдэл 185 В хүртэл унасан.

Шийдэл: 10 кВ-ын шугамыг 35 кВ-ын ЦДАШ болгон өргөтгөх шаардлагатай.

Ноён, Сэврэй сумдуудын төвийн хүчдэлийн уналтыг БНХАУ-аас Нарийнсухайт хүртэл 35 кВ-ийн ЦДАШ-ыг 110 кВ-болгон өргөтгөх ажил энэ онд дуусаж байна. Үүнтэй холбоотойгоор хүчдэлийн уналт арилна.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК

Суурилагдсан чадал: 23.1 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 32.0 Гкал/ц

Чадлын нөөц: 0.0 Гкал/ц

Хэрэгжүүлэх шаардлагатай төсөл:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд ТЭЗҮ хийгдэж, Эрчим хүчний яамны Шинжлэх Ухаан, Технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжсэн. Төслийн санхүүжилт 118 сая ам.доллар бөгөөд Аймгийн

төвд 50 МВт-ын ДЦС барих юм.

Тулгамдаж буй асуудал: Эрчим хүчний хангамжийн хувьд нөөцгүй, хүндрэлтэй. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх шаардлагатай.

СҮХБААТАР

ЦАХИЛГААН

Ашиглагч: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

- Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн 110 кВ-ын АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 214.5 км урттай ЦДАШ
- “Чойбалсан-Баруун Урт” чиглэлийн 110 кВ-ын АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 187.3 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Баруун-Урт” дэд станц, 1х6.3 МВА, 1х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ... бэлтгэлд

Т-2 ... 5.9 МВт

Үндсэн шийдэл: Багануур-Чингис-

Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын хүчдэлтэй, хоёр хэлхээт 518 км урттай ЦДАШ, 220/110/35 кВ-ын 2х63 МВА хүчин чадалтай “Чингис” дэд станц, 220/110/35 кВ-ын “Багануур” дэд станцын өргөтгөл 380 тэрбум төгрөгөөр барьж, /131 сая.ам.доллар/ Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах боломж бүрдэнэ. Хүн ам суурьших, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих нийгмийн чанартай том төсөл болохоос гадна Монгол Улсын нэгдсэн эрчим хүчний систем буюу үндэсний цахилгаан дамжуулах сүлжээг байгуулах үндсэн бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Дөрвөлж” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 41.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 30.0 Гкал/ц

Чадлын нөөц: 11.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлийн төслөөр Сүхбаатар аймгийн төвд 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 61м дулаан дамжуулах шугам баригдана.

Тайлбар: Өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй, зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаардлагатай.

СЭЛЭНГЭ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Төвийн бүсийн салбар

- 110 кВ-ын Сүхбаатар АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 102 км урттай ЦДАШ
- 110/35/6 кВ-ын “Сүхбаатар” дэд станц нь, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...38 хувь

Т-2 ...71 хувь

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 35.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 34.0 Гкал/ц

Чадлын нөөц: 1.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл:

“Райдмонголиа” ХХК Хувийн

хэвшлийн 150 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 70 МВт-ийн ДЦС барих төслийг 2023-2027 онд хэрэгжүүлэхээр эхлүүлсэн. Төслийн барилга угсралтын ажил 10 хувьтай үргэлжилж байна.

Тулгамдаж буй асуудал: Дулаан хангамжийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай.

ТӨВ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК-ийн Улаанбаатар болон Төвийн бүсийн салбар

- Яармаг-Зуунмод АС-95 маягийн дамжуулагч бүхий хоёр хэлхээт 22.5 км урттай ЦДАШ
- 110/35/6 кВ-ын “Зуунмод” дэд станц 2х6300 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-154 хувь

Т-272 хувь

Хэрэгжиж буй төсөл арга хэмжээ:**Улсын төсвийн хөрөнгө**

оруулалт: 18.6 тэрбум төгрөг
110/35/10 кВ-ын 2х25 МВА,

Гэрээний хугацаа: 2023.09.30

Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Лүн, Сэргэлэн, Эрдэнэ, Зуунмод сумын төвийн хүчдэлийн уналтыг эдгээр сумуудыг тэжээж байгаа өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас холбогдож байгаа хэрэглэгчдийн асуудлыг шийдвэрлэх боломжтой.

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Төв чандмань” ОНӨААТҮГ

Суурилагдсан чадал: 48.0 Гкал/ц
Холбогдсон хэрэглээ: 23.0 Гкал/ц

Чадлын нөөц: 25.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, найман ширхэг дулаан дамжуулах төв, 8.6 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай.

УВС

ЦАХИЛГААН

Ашиглагч: “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК.

- 110 кВ-ын “Улаангом-Хандгайт” чиглэлийн (ОХУ) АСО-300 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээт 101.3 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Чандмань-Уул” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

Т-1 ...55 хувь

Т-2 ...55 хувь

Үндсэн шийдэл: Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 220 кВ-ын 2 хэлхээт 468,3 км урттай ЦДАШ, шинээр 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцууд барьж, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин

чадалтай УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг тус ЦДАШ-аар дамжуулан Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын хэрэглэгчдийг дотоодын хямд эрчим хүчээр хангах боломжтой.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй. Хоёр дулааны станцтай. Увс аймгийн төв Улаангом сумыг дулаан үйлдвэрлэдэг “Увс дулааны станц” ХХК, “Дулааны II станц” ТӨХК гэсэн хоёр станцаас төвлөрсөн дулаан хангамжийн системээр 818 амины орон сууц, 1616 айл өрх, нийт 2434 өрхийн 8800 хүнийг дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Ашиглагч: “Улаангом-Улааномын дулааны 2-р станц” ТӨХК

Суурилагдсан чадал: 30.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 30.0 Гкал/ц

Чадлын нөөц: 0.0 Гкал/ц

Ашиглагч: “Увс дулааны станц” ХХК

Суурилагдсан чадал: 39.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 15.0 Гкал/ц

Чадлын нөөц: 24.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: 21 МВт-ийн өргөтгөл хийгдэхээр 2024 онд Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр дэмжигдэн, зураг төслийг мөн тухайн онд хийж баталгаажуулсан. Өргөтгөлийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхэд санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай.

ХОВД

ЦАХИЛГААН

Ашиглагч: “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

- 110 кВ-ын “Өмнөговь-Мянгад” чиглэлийн АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээт 96.1 км урттай ЦДАШ
- 110/35/10 кВ-ын “Мянгад” дэд станц, 2х25МВА хүчин чадалтай,
- 35/6 кВ-ын “Жаргалант” дэд станц, 2х10 МВА хүчин чадалтай

Ачаалал:

T-1 ...Бэлтгэлд

T-2 ...52 хувь

35/6 кВ-ын “Ховд” дэд станц 2х6.3 МВА хүчин чадалтай

Ачаалал:

T-1 ...52 хувь

T-2 ...52 хувь

Манхан сумын 110/35/10 кВ-ын дэд станцаас Хөшөөтын уурхай хүртэл 30 км 110 кВ-ын ЦДАШ бариад байна. Одоо 90 км шугамыг үргэлжлүүлэн барих хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүй гурван жил болж байна.

Энэ 120 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг

ашиглалтад оруулсан тохиолдолд Хөшөөт-Үенч сумын одоо баригдаж байгаа 230 км орчим 35 кВ-ын ЦДАШ-аар Үенч, Алтай сумдын хүчдэлийн уналтыг шийдэх боломжтой.

Гэвч Булган сум 10000 гаруй хүн амтай хэрэглээ өндөртэй тул шийдэх шинэ эх үүсвэр барьж дотоодоос хангах боломжтой.

Үндсэн шийдэл: Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 220 кВ-ын хоёр хэлхээт 468,3 км урттай ЦДАШ, шинээр 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцууд барьж, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг тус ЦДАШ-аар дамжуулан Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын хэрэглэгчдийг дотоодын хямд эрчим хүчээр хангаж, импортын хараат байдлаас гаргах боломжтой.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй. Ховд аймгийн төв нь хувийн болон орон нутгийн өмчтэй хоёр дулааны станцтай.

1.“Бадамлах дөл” ХХК Ховд аймгийн хуучин дулааны станц нь 1986 онд ашиглалтад орж, 2005 онд хувьчлагдсан.

2. “Ховд аймгийн дулааны станц” ТӨХК: Монгол Улсын 2012-2014 оны улсын төсвийн 13,97 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон. 1558 айл өрх, 92 ААНБ, 20 төсөвт байгууллага, нийт 146 объект холбогдсон.

Ашиглагч: “Ховдын дулааны станц” ТӨХК

Суурилагдсан чадал: 36.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 21.0 Гкал/ц

Чадлын нөөц: 5.0 Гкал/ц

Ашиглагч: “Бадамлах дөл” ХХК

Суурилагдсан чадал: 32.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 15.0 Гкал/ц

Чадлын нөөц: 7.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: Дулааны станцын өргөтгөх шаардлагатай бөгөөд 2023-2024 оны улсын төсөвт 8.0 тэрбум төгрөгийн суулган дулааны станцын өргөтгөлийн / Хүчин чадал 20 Гкал/ц/ барилга угсралтын ажил хийгдэж байна.

ХӨВСГӨЛ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК-ийн Хангайн бүсийн салбар

- 110 кВ-ын “Булган-Мөрөн” чиглэлийн АС-120/19 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 231.6 км урттай ЦДАШ
- 110/35/6 кВ-ын “Мөрөн” дэд станц, 2х6.3 болон 1х2.5 МВА хүчин чадалтай

Ачаалал:

T-1 ...99 хувь

T-2 ...95 хувь

T-3 ...66 хувь

Хэрэгжиж буй төсөл: Азийн хөгжлийн банкны 9.5 сая доллараар 10 МВт-ын нарны цахилгаан станц барьж байгаа.

Цахилгаан дамжуулах агаарын шугам их урттай тул тасралт саатал ихтэй, дамжуулах чадлын нөөц багатай. Тосонцэнгэлийн 18 МВт чадалтай дулааны цахилгаан станц ашиглалтад 2025 онд орсноор цахилгаан хангамж сайжирна.

ДУЛААН

Төвлөрсөн дулаан хангамжийн

системтэй.

Ашиглагч: “Хөвсгөлийн дулааны станц” ТӨХК

Суурилагдсан чадал: 30.0 Гкал/ц

Холбогдсон хэрэглээ: 33.0 Гкал/ц

Чадлын нөөц: 0.0 Гкал/ц

Хэрэгжүүлэх шаардлагатай төсөл:

Хөвсгөлийн дулааны станцын суурилагдсан хүчин чадлын 20 Гкал/ц-ийн 1 зуухаар өргөтгөх шаардлагатай. Зуух өргөтгөхөд 2024 оны Улсын төсөвт 16.7 тэрбум төгрөг тусгуулах шаардлагатай.

ХЭНТИЙ

ЦАХИЛГААН

Ашиглагч: “ЦДҮС” ТӨХК, Зүүн-Өмнөд бүсийн салбар

- 110 кВ-ын “Бор-Өндөр-Өндөрхаан” чиглэлийн АС-120 маягийн дамжуулагч бүхий нэг хэлхээ 176,8 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам
- 110/35/6 кВ-ын “Өндөрхаан” дэд станц, 1х10, 110/6 кВ 1х6.3 МВА хүчин чадалтай

Ачаалал:

- Т-1 ...70 хувь
- Т-2 ...Бэлтгэлд

Үндсэн шийдэл: Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын хүчдэлтэй, хоёр хэлхээт 518 км урттай ЦДАШ, 220/110/35 кВ-ын 2х63 МВА хүчин чадалтай “Чингис” дэд станц, 220/110/35 кВ-ын “Багануур” дэд станцын өргөтгөл 380 тэрбум

төгрөгөөр барьж /131 сая. ам.доллар/ Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын ЦЭХ-ний хэрэглээний өсөлтийг хангах боломж бүрдэнэ.

ДУЛААН

Хэсэгчилсэн дулаан хангамжийн системтэй.

Ашиглагч: “Хэнтий Ус” ОНӨААТҮГ
Суурилагдсан чадал: 22.0 Гкал/ц
Холбогдсон хэрэглээ: 18.0 Гкал/ц
Чадлын нөөц: 4.0 Гкал/ц

Хэрэгжиж буй төсөл: БНСУ-ын Эксим банкны хөнгөлттэй зээлээр аймгийн төвд 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 16 ширхэг дулаан дамжуулах төв, 10.3 км урт дулааны шугам сүлжээ баригдаж төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болно.

Тайлбар: Хувийн уурын зуухнууд ажилладаг тул өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэлтэй зайлшгүй дулааны станцыг ашиглалтад оруулах шаарлагатай. Төслийг хэрэгжүүлж буй барилга угсралтын гүйцэтгэгч компаниас өнөөдрийн зах зээл дээрх материалын, ажиллах хүчний, валютын ханшийн, тээвэр ложистикийн үнийн өсөлт зэрэг нь төслийн 2018 онд боловсруулагдсан ТЭЗҮ-ийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсгэж байгаагаа илэрхийлэн ажлын явцыг удаашруулж байна.

Улсын төсвийн 21.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бэрх тосгонд 21МВт Дулааны станцыг барьж 2024 онд ашиглалтад хүлээлгэж өгсөн.

Эх сурвалж: ЭХЯ





ЭРЧИМ ХҮЧ

МЭДЭЭЛЛИЙН ПЛАТФОРМ



WEBSITE



erchimhuch.mn

FACEBOOK



Эрчим хүч сэтгүүл

TWITTER



Эрчим хүч сэтгүүл

LINKEDIN



Эрчим хүч сэтгүүл

